

Оросын
Холбооны
Улсын
Улс Түмний
Найрамдлын
Их Сургууль

ГАДААД ОРНУУДЫН

ОРОН НУТГИЙН ЭРХ ЗҮЙ СУРАХ БИЧИГ

ОНОЛ БА ОРЧИН
ҮЕИЙН ПРАКТИК

Оросын Холбооны Улсын Улс Түмний
Найрамдлын Их Сургууль

ГАДААД ОРНУУДЫН ОРОН НУТГИЙН ЭРХ ЗҮЙ

Онол ба орчин үеийн практик

Хянан тохиолдуулсан:
Хууль зүйн ухааны доктор, профессор
В.В.Еремян

*“Мэргэжлийн сурах бичиг”-ийн сургалт-арга зүйн
төвөөс “Юриспруденц” чиглэлээр сургалт
эрхлэн явуулдаг дээд сургуулийн оюутнуудад зориулсан
сурах бичиг гэж хүлээн зөвшөөрсөн.*

*Боловсрол-шинжлэх ухааны эрдэм шинжилгээ-судалгааны
институтээс “Юриспруденц” чиглэлээр сургалт
эрхлэн явуулдаг дээд сургуулийн оюутнуудад зориулсан
сурах бичиг гэж хүлээн зөвшөөрсөн.*

Юнити

Unity

Москва * 2017

Энэхүү ном нь ОХУ-ын “Мэргэжлийн сурах бичиг”-ийн
конкурсын алтан медальтай

УДК 342.553(1-87)(075.8)

ББК 67.400.7(3)я73-1

М90

Үндсэн хуулийн эрх зүй, үндсэн хуулийн
шүүх ажиллагааны Кафедра

Зохиогчид:

В.В.Еремян – Хууль зүйн ухааны доктор, профессор (ерөнхий редактор, Бүлэг 5,6)

Д.О. Ежевский – Хууль зүйн ухааны Доктор Ph, доцент (Бүлэг 2)

Е.Т.Ешинимаева – Шагдарова – Хууль зүйн ухааны Доктор Ph, Ахлах багш (Бүлэг 3)

И.В.Кокорев - Хууль зүйн ухааны Доктор Ph, Ахлах багш (Бүлэг 8)

Л.Т.Чихладзе - Хууль зүйн ухааны доктор, профессор (бүлэг 1,4)

А.С.Чупанов - Хууль зүйн ухааны Доктор Ph, Ахлах багш (Бүлэг 7)

Хэвлэлийн ерөнхий редактор Н.Д.Эриашвили,
Хууль зүйн ухааны Доктор Ph, Эдийн засгийн ухааны доктор, профессор,
шинжлэх ухаан техникийн салбарын ОХУ-ын Засгийн газрын шагналт

М90 Гадаад орнуудын орон нутгийн эрх зүй: Онол, орчин үеийн практик
"Юриспруденци" чиглэлээр их дээд сургуульд суралцагчдад зориулсан сурах
бичиг. Хянан тохиолдуулсан В.В.Еремян. – М.:ЮНИТИ-ДАНА, 2017. – 679 хуудас.
И. Ред. Еремян, Виталий Владимирович.

ISBN 978-5-238-02972-6

СІР РГБ Агентлаг

Үндсэн хуулийн болон орон нутгийн эрх зүйн шинэ хууль тогтоомжийг судалж, нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны практик, сүүлийн арван жилд зарим улс орнуудын хэрэгжүүлсэн орон нутгийн шинэчлэлийн үндсэн дээр гадаад орнуудын орон нутгийн эрх зүйн институцийн хөгжил, орон нутгийн тогтолцооны онцлогийг нээн илрүүллээ. Зарим тохиолдолд судлаачид орчин үеийн Оросын харьцуулсан эрх зүйн шинжилгээний аргыг хэрэглэлээ.

Хууль зүйн чиглэлийн хичээлүүдийн оюутан, аспирант, багш нар, төрийн болон орон нутгийн албан хаагчид, бүх шатны төлөөллийн байгууллагын депутат нар, түүнчлэн орчин үеийн дэлхийн нийтийн засаглалын асуудлыг сонирхогч бусад этгээдэд зориулав

ББК 67.400.7(3)я73-1

ISBN 978-5-238-02972-6

© ЮНИТА-ДАНА Хэвлэл, 2017

Уг номыг ашиглах болон түгээх онцгой эрх хадгалагдана (2013 оны 4 дүгээр сарын 5-ны 44-ФЗ дугаартай Холбооны хууль)

Номыг бүхэлд нь болон түүний аль ч хэсгийг ямар нэг хэрэгслээр, эсвэл ямар нэг хэлбэрээр, тэр дундаа интернетийн сүлжээгээр нийтлэгчийн зөвшөөрөлгүйгээр дахин үйлдвэрлэх, олшруулахыг хориглоно.

Оросын Холбооны Улсын Улс Түмний
Найрамдлын Их Сургууль

ГАДААД ОРНУУДЫН ОРОН НУТГИЙН ЭРХ ЗҮЙ

/МУНИЦИПАЛЬНОЕ ПРАВО ЗАРУБЕЖНЫХ СТРАН/

Сурах бичиг

Онол ба орчин үеийн практик

ДАА 340

ННА 67

Г-132

Зохиогчид:

В.В.Еремян - Хууль зүйн ухааны доктор, профессор (ерөнхий редактор, Бүлэг 5,6)

Д.О. Ежеский - Хууль зүйн ухааны Доктор Ph, доцент (Бүлэг 2)

Е.Т.Ешинимаева -Шагдарова -Хууль зүйн ухааны Доктор Ph, Ахлах багш (Бүлэг 3)

И.В.Кокорев - Хууль зүйн ухааны Доктор Ph, Ахлах багш (Бүлэг 8)

Л.Т.Чихладзе - Хууль зүйн ухааны доктор, профессор (бүлэг 1,4)

А.С.Чупанов - Хууль зүйн ухааны Доктор Ph, Ахлах багш (Бүлэг 7)

Гадаад орнуудын орон нутгийн эрх зүй Онол ба орчин үеийн практик

Хянан тохиолдуулсан:

Хууль зүйн ухааны доктор, профессор

В.В.Еремян

Орос хэлнээс орчуулсан: Г.Цэрэндулам

Редактор:

Д.Мөнхгэрэл

Д.Ганзориг

Эхийг бэлтгэсэн:

Д.Ганчимэг

Зохиогчийн бүх эрх хамгаалагдсан.

© Энэхүү гарын авлагыг орчуулах, хэвлэх эрхийг албан ёсоор авсны үндсэн дээр Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Швейцарын хөгжлийн агентлагийн хамтран хэрэгжүүлж буй «Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь» төслийн хүрээнд орчуулан хэвлэв.

ISBN 978-5-238-02972-6 (Орос)

ISBN 978-9919-9618-1-7 (Монгол)

Адмон принт хэвлэлийн газар

© Гадаад орнуудын орон нутгийн эрх зүй: Онол ба орчин үеийн практик

Бүлэг 7

ЗҮҮН-ӨМНӨД АЗИЙН УЛСУУДЫН НУТГИЙН ӨӨРИЙН УДИРДЛАГА, НУТГИЙН УДИРДЛАГА БОЛОН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН ХУВААРИЛАЛТ

Орчин үед гадаад орнуудын орон нутгийн практикт нийтийн эрх зүйн-нутгийн өөрийн удирдлага, нутгийн удирдлага гэсэн хоёр ангиллыг нэг нэгнээс нь ялгах тогтвортой уламжлал үүссэн.

Оросын төрийн шинжлэх ухаанд одоо үед улс орнуудыг хөгжсөн, хөгжиж байгаа орнууд гэж ангилдаггүй (яагаад гэвэл, юуны түрүүнд Зөвлөлтийн Холбоо задарсны дараа ОХУ бүх шинж тэмдгээрээ эхний ангиллаас хоёр дахь ангилалд шилжсэн), түүнчлэн бас социалист, хөрөнгөтөн улс (дээрхтэй ижил шалтгаанаар) гэж ялгадаггүй.

Үүний зэрэгцээгээр улс орнуудыг (төр) нийгэм-эдийн засгийн үндэслэлээр ангилах ангилал нь ардчилсан болон ардчилсан бус янз бүрийн хэлбэрийг (авторитар, тоталитар гэх мэт) багтаадаг улс төр-эрх зүйн дэглэмээр ангилах ангилалд байраа тавьж өгсөн. Ингэхдээ ийм ангилалд АНУ болон баруун Европын улсуудын хувьд уламжлал болсон “эрх мэдэл хуваарилах” институт, түүнчлэн нийтийн засгийг хууль ёсны болгох гэсэн зарим үйл ажиллагаа (процедур)-г тодорхойлохоос өөр бусад нэр томъёог бараг тусгадаггүй.

Гэхдээ энд зүүн-өмнөд Азийн улс орнуудыг авч үзэхдээ социалист онцлогийг тооцож үзэхгүй байж болохгүй юм.

Мөн үүний зэрэгцээгээр “нутгийн өөрийн удирдлага” гэдэг ойлголтыг социалист орнуудын төр-эрх зүйн шинжлэх ухаанд *de facto* хэрэглэдэггүй, учир нь социалист төр нь “ард түмний төр”, түүн дэх *priori* нь өөр өөр эрх зүйн байдал, зорилго, зорилт бүхий төрийн болон орон нутгийн засаглал байх боломжгүй. Ардын ардчилсан улсуудад нутгийн өөрийн удирдлагын институт төрийн эрх мэдлийн институтээс хамааралгүй байх нь онолын болон практик талаасаа утгагүй зүйл, учир нь тэдгээр “төрийн бүх эрх мэдэл угаасаа ард түмний мэдэлд” байдаг, харин хүн ам нь ардчилсан төвлөрлийн зарчмын дагуу бүс нутгийн болон орон нутгийн сонгогдсон байгууллагаар дамжуулан удирдах нөлөөгөө төрийн эрх барих дээд байгууллагад хүртэл үзүүлдэг.

Зүүн Өмнөд Азийн хамгийн онцлог (харьцуулсан эрх зүйн дүн

шинжилгээний үүднээс), оросын орон нутгийн эрх зүйд ихэвчлэн авч үздэггүй нэг улсыг авч үзье.

7.1. Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс

조선 민주주의 인민 공화국¹

Чосон Минджуджуый Инмин Коньхвагук

Оростой хиллэдэг, Зүүн өмнөд Азийн шинжилгээ судалгаа болон практик талаас хамгийн сонирхолтой улсуудын нэг бол Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс (цаашид БНАСАУ) юм.

БНАСАУ улс төрийн газрын зураг дээр гарч ирсэн нь ЗСБНХУ-ын зэвсэгт хүчин дэлхийн хоёрдугаар дайны төгсгөлийн шатанд гитлерийн эсрэг холбоотны байгуулсан гэрээний үүргээ биелүүлж Алс дорнодод тухайн нутаг дэвсгэрийг чөлөөлсний шууд үр дүн байсан. Тухайн түүхэн нөхцөлд хойгийн хойт хэсэгт ЗСБНХУ, өмнөд хэсэгт нь АНУ-ын зэвсэгт хүчин байрласан нь үзэл суртал, улс төр, эдийн засгийн үнэт зүйлд нөлөөлөхгүй байх аргагүй байсан бөгөөд уг хойг дээр БНАСАУ болно БНСУ тус тус байгуулагдахад хүрсэн.

Тэр тусмаа солонгосчууд өмнөх бараг 40 жилийн турш Японы хаант Улсын удирдлага дор өөрийн төргүй шахам явж ирсэн. Нэг ч улс байгаагүй байснаа гэнэт хоёр улс гарч ирсэн, сонирхолтой нь Солонгосын хойг гэсэн энгийн нэрийг хүртэл хойт болон өмнөд хэсэгт өөр өөрөөр бичиж, дууддаг².

1 Энд болон цаашид солонгос үгийг ашиглахдаа зөвхөн солонгос хэлний фонемик бичилт "чосонгыл" (сол. 조선글) -ийг, эсхүл БНАСАУ-д дангаар, БНСУ-д үндсэндээ хэрэглэгддэг "хангыл" (Сол. 한글)-ийг ашиглана. БНСУ-д "хангыл"-ын зэрэгцээгээр "ханча" (сол. 한자, 漢字, 漢字) - солонгос хэлний бичигт ашиглагдах хятад ханз байдаг. "Ханча"-г хятад хэлнээс

2 гаралтай үгийн бичлэгт хэрэглэдэг (энэ нь Солонгосын үгийн сангийн бараг хагасыг эзэлдэг). Хангылийг XV зуунд бүтээсэн боловч XIX зууны эцэс хүртэл бараг ашиглаагүй бөгөөд хүмүүсийн ухамсар өсөхийн хирээр хятад ханзны оронд хэрэглэх болсон. Одоо үед БНСУ-д ханчаг маш ховор хэрэглэдэг-голчлон шинжилгээ-судалгааны бүтээлүүд болон сонинд хэрэглэдэг. Энд болон цаашид транскрипцийг кирилл тайлбартайгаар хэрэглэнэ (Зохиогчийн тэмдэглэл).

Солонгос нь Орос болон европын хэлнүүд дээр 935-1392 онд Солонгосын хойгийн нутаг дэвсгэр дээр ноёрхож байсан Корёгийн хаант Улс (고려왕조)-ын нэрээр нэрлэгддэг. БНАСАУ-д 1392-1897 он хүртэл ноёрхож байсан Чосоны ("Өглөөний цэнгэг байдал") хаант Улсын нэрээс гаралтай, эртний солонгосын түүхт улс болох М.Э.Ө 2333-м.э. 108 онд байсан юм шиг ярьдаг "Эртний Чосон" (.....Ко Чосон) -той ойролцоо дуудагдах "Чосон" гэдэг нэрийг хэрэглэдэг. Яг л энэ нэр нь Хятад болон Японд хэрэглэдэг нэршилтэй ижил дуудагддаг. БНСУ-д "Хан Гук" (한 ("Ханы орон", "Агуу орон"), Солонгосын хоолойн орчим районд оршин суудаг Хан (한) үндэстний нэрээс гаралтай бөгөөд 1897-1910 онд хаан төрийг барьж байсан хаан (ван Коджон) улсын нэрийг "Тэ Хан Че Гук" (대한제국(Их хааны импери) гэж өөрчлөхөөр шийдсэн үед

БНАСАУ-лс болон БНСУ-лс нь *de facto* солонгосын хойгийг Японы дарангуйллаас 1945 онд чөлөөлснөөс гурван жилийн дараа 1948 онд үүссэн. Хоёр улсыг хоёуланг нь НҮБ-д 1991 онд хүлээж авсан, хоёул олон улсын харилцааны тэгш эрхт субъект мөн. Хоёр Солонгос НҮБ болон бусад олон арван олон улсын байгууллагын гишүүн бөгөөд тус бүр нь 150-иас дээш улстай дипломат харилцаатай байна.

Энэ утгаараа БНАСАУ-ын “тусгаарлалт” гэдэг Америкийн үзлийн үзэл суртлыг олон нийтийн санаа бодолд шаргуугаар нэвтрүүлсэн барууны, юуны өмнө америкийн үзэл суртлын ул мөр, түүнчлэн оросын хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон тулгамдсан ямар ч асуудлыг-шувууны ханиаднаас Карибын хямрал хүртэлх хэрэг явдлыг маш амархан шүүрч авч, дэгсдүүлж тайлбарлахад бэлэн зарим “мэргэжилтнүүд”-ийн тайлбар бодит байдалд нийцэхгүй байна.

БНАСАУ-ын социалист Үндсэн хууль (цаашид-социалист үндсэн хууль гэх)¹-ийн 4 дүгээр зүйлд зааснаар БНАСАУ-д засгийн эрх ажилчин, тариачин, хөдөлмөрийн сэхээтэн, нийт хөдөлмөрчин ард түмний мэдэлд байдаг бөгөөд тэд өөрсдийн төлөөллийн байгууллага-Ардын Дээд Хурал (Дээд зөвлөл) болон бүх шатны орон нутгийн ардын хурал (орон нутгийн зөвлөл)-аар дамжуулан хэрэгжүүлдэг².

Социалист Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд ардчилсан төвлөрсөн ёсны зарчмыг БНАСАУ-ын төрийн бүх байгууллагын байгуулагдах, үйл ажиллагаагаа явуулах суурь гэж тогтоосон.

Үндсэн хуулийн заалтын дагуу төр нь нийт ард түмний ашиг тусын тулд чиг шугамыг тодорхойлж, “Чхонсанри” үзэл, аргыг амьдралд хэрэгжүүлнэ.

Солонгосын төрийг нэрлэхэд хэрэглэж байсан. Энэ хоёр нэг хоёулаа хятад нэрнээс гаралтай бөгөөд хятад ханзны солонгос дуудлага. Ийм маягаар БНАСАУ (хойт) солонгосын жинхэнэ нэр нь орос хэл дээр “Ардын- Ардчилсан Бүгд Найрамдах Улс Чосон”, харин Бүгд Найрамдах Солонгос Улс (өмнөд)-ын нэр нь “Бүгд Найрамдах Хан Улс” байх байсан. “Солонгос” гэдэг үгийг эсрэгээр оросоос европын хэл, эсхүл хятад хэл рүү орчуулахад Чосон, Хан хоёрыг хоёуланг нь хэрэглэнэ. Энд хэрвээ орчуулагч нь улс төрийн хувьд Хойт СОлонгосын талыг баримталдаг, итгэл үнэмшлийн хувьд коммунист, социалист бол “Кореа” гэдэг үгийг “Чосон” гэж орчуулна. Эсрэг тохиолдолд орчуулагч нь өмнөд солонгосын талыг баримтлагч, үзэл бодлын хувьд барууны ардчиллыг дэмжигч, капиталист, эсхүл либерал бол “Кореа” гэдэг үгийг солонгос хэл дээр “Хан” гэж орчуулна. (Зохиогчийн тэмдэглэл)

1 БНАСАУ-ын Ардчилсан Үндсэн хууль- (кор. 조선민주주의 인민공화국 사회주의 헌법) Ардын Дээд хурлын 5 дахь удаагийн анхдугаар чуулганаас 1972 оны 12 сарын 27 нд батлагдсан; АДХ-ын 10 дахь удаагийн анхдугаар чуулганаас 1992 оны 4 сарын 9-нд, АДХ-ын 12 дахь удаагийн анхдугаар чуулганаас 2009 оны 4 сарын 9-нд тус тус өөрчлөлт оруулсан. Эх бичвэрийг нь БНАСАУ-ын социалист Үндсэн хууль. Пхеньян, Изд-во лит. на иностр.яз, 2009 гэж эшлэдэг.

2 Ардын хурал (кор. 인민회의). Зөвлөлийн болон оросын бүтээлүүдэд эдгээр байгууллагын нэрийг “ардын хурал” гэж орчуулж хэвшсэн, гэвч орос хэл рүү хамгийн тохиромжтой орчуулга нь “зөвлөл” юм.

Энэ үзлийн агуулга нь дээд шат нь доод шатандаа тусалж, асуудлын зөв шийдвэрийг олон нийтийн дундаас олох, улс төрийн ажил, олон нийттэй ажиллах ажлыг эхний ээлжинд тавих, тэдний санаачлагыг өрнүүлэхэд оршино.

1949 онд БНАСАУ-д Эх орны нэгдсэн ардчилсан фронт (ЭНАФ)¹-ыг байгуулсан, түүний удирдагч хүчин нь Солонгосын Хөдөлмөрийн нам (СХН).

СХН² нь эрх баригч нам, түүний удирдан чиглүүлэх үүргийг социалист Үндсэн хуульд бэхжүүлсэн.

Үүнээс гадна, БНАСАУ-д Солонгосын Социал Демократ нам³, энэ нам СХН-ын удирдагч үүргийг хүлээн зөвшөөрсөн бөгөөд ЭНАФ-д багтдаг.

Тэнгэрийн замын шашны залуу нөхдийн нам⁴, СХН-ын тэргүүлэгч

1 Эх орны Нэгдсэн ардчилсан фронт (тухайн улсын бүтээлүүдэд **조국통일 민주주의 전선**, гэж орчуулдаг- авторын санаа), энэ нь тийм ч зөв биш, зөв орчуулга нь - Эх орныг нэгтгэх Ардчилсан Фронт-1946 оны 7 сарын 22-нд байгуулагдсан. 1949 оны 6 сарын 25-28-нд Пхеньянд болж өнгөрсөн ЭНАФ-ыг байгуулах хурал дээр Хойт болон Өмнөд Солонгосын 70 орчим улс төрийн нам, нийгмийн байгууллагуудын төлөөлөл оролцсон. 1950-1953 оны Солонгосын дайны үед ЭНАФ нь НҮБ-ийн ивээл дор, БНАСАУ-ыг хамгаалж гадаадын цэрэг, дайны аюулын эсрэг тэмцсэн. ЭНАФ-ын хөтөлбөрт “империализмын эсрэг үндэсний чөлөөлөх хувьсгалын” зорилтыг тусгасан. Фронт нь Солонгос (Өмнөд) улсаас америкийн цэргийг гаргах, хоёр улсыг энх тайвны замаар нэгтгэх, нийгэм-эдийн засгийг өөрчлөхийн төлөө тэмцсэн. Фронт нь хоёр Солонгосыг нэгтгэх хөдөлгөөний санаачлагч байсан.

2 Солонгосын Хөдөлмөрийн нам (1946 оны 7 сарын 29-нд Шинэ Ардын нам (선민당 син мин дан , марксист-ленинист нам байгуулагдсан. Солонгосын Хөдөлмөрийн нам 1946 оны 7 сарын 29-нд Шинэ Ардын нам (선민당,), Хойт Солонгосын Коммунист нам, (сол 조선로동당, комсом родон дан - Солонгосын Коммунист нам, уг намыг Хятадаас эргэж ирсэн солонгосын коммунист Ким Ду Бон үүсгэн байгуулсан)-ын нэгдэх хөдөлгөөний дүнд байгуулж, тэдгээрийн нэгдлийг албан ёсоор зарлаж, албан ёсны зарлал гаргасан. Дараагийн саруудад нь хөдөөгийн (провинц), хошуу (уезд), хотын намын байгууллагууд нэгдсэн. 1946 оны 8 сарын 28-30-нд нэгдсэн намын анхдугаар их хурал Пхеньянд болж, намыг Хойт солонгосын хөдөлмөрийн нам (ХСХН조선공산당 ,) гэж нэрлэсэн, намын удирдагч нь Ким Ду Бон байсан. Өмнөд Солонгосын Хөдөлмөрийн нам (남조선로동당), 1946 онд Коммунист, Өмнөд Солонгосын Шинэ Ардын нам нэгдсэний дараа байгуулагдаж, 1949 онд нэгдэн орсон. Улс төрийн товчоонд 10 гишүүн орсон: Ким Ир Сен (Намын дарга), Хо Хон, Ким Сам Рён, Ким Чхек, Пак Хон Ён, Ли Сын Ёп, Ким Ду Бон, Хо Га И (Александр Иванович Хегай), Пак Ир У, Пак Чон Э. 2011 оны 9 сараас СХН-ын даргаар Ким Чен Ён (김정은) сонгогдсон, гишүүнчлэлийн тоо-ойролцоогоор 3,2 сая.

3 Солонгосын социал демократ нам (ССДН сол-조선사회민주당).1945 оны 11 сарын 3-нд үндэсний хөдөлгөөний нэрт зүтгэлтэн Чо Ман Сик Солонгосын Ардчилсан нам нэртэйгээр байгуулсан. 1981 онд Социал Демократ нам гэж өөрчлөн нэрлэсэн. ССДН дунд болон жижиг бизнес эрхлэгчид, худалдаачид, гар урлалчид, болон тариачдын нэг хэсэг, түүнчлэн христиануудыг Үндсэн зарчим нь-Солонгосын үндэсний онцлог, түүхэн нөхцөлд тохирсон-үндэсний социалист ардчилал, улс төрийн лозунг-бие даасан, хараат бус байдал, энх тайван, хүний эрхийг хамгаалах. Төв хорооны дарга нь-Ким Ён Дэ, гишүүнчлэл-30 мянган хүн.

4 Тэнгэрийн зам шашны залуу нөхдийн нам (сол. 조선사회민주당)- (орчуулга оновчтой биш, учир нь оросын бүтээлүүдэд заримдаа Чхондоге -чхонудан гэж нэрлэгддэг) 1946 оны 2 сарын 8-нд байгуулагдсан. 1947 оны эцэст бүрэлдэхүүнд 200 мянган гишүүн байсан. Анхандаа намын

үүргийг хүлээн зөвшөөрдөг, ЭНАФ-ын гишүүн.

Хошуу /уезд/-ны ардын хурлаас эхлээд Ардын дээд хурал хүртэл засгийн бүх шатны байгууллага нь бүх нийтийн, тэгш, шууд сонгуулийн эрхийн үндсэн дээр нууц санал хураалтын замаар сонгогддог¹.

Гэхдээ сонгууль нь нэг мандаттай сонгуулийн тойргоор явагдах учир ихэвчлэн сонгох хувилбаргүй байдаг. 17 насанд хүрсэн иргэн бүр сонгогдож болно.

Бүх шат эрх мэдлийн байгууллагын депутатууд Үндсэн хуулийн 7 дугаар зүйлд зааснаар сонгогчидтой ойр холбоотой байх бөгөөд өөрийн үйл хэргийг тэдэнд тайлагнана.

Депутат сонгогчдын итгэлийг алдвал сонгогчид нь хэзээ ч тэднийг эргүүлэн татаж болно (“императив мандат” үйлчилдэг).

БНАСАУ-д нутгийн удирдлагын үндсэн байгууллага болох ардын хурлыг авч үзье.

Хөдөөгийн (төвд харьяалалтай хотуудын), хотын (районы), хошуудын ардын хурал нь нутгийн засгийн эрх барих байгууллага юм.

Орон нутгийн ардын хурал бүх нийтийн, тэгш, шууд сонгуулийн эрхийн үндсэн дээр нууц санал хураалтын замаар 4 жилийн хугацаагаар сонгогдсон депутатуудаас бүрддэг (Ардын дээд хурал нь 5 жилээр).

Орон нутгийн ардын хурлын шинэ (ээлжит) сонгуулийг холбогдох орон нутгийн ардын хорооны тогтоолоор орон нутгийн ардын хурлын бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө зохион байгуулдаг.

Гарцаагүй нөхцөл байдлаас шалтгаалж сонгуулийг хугацаанд нь явуулах боломжгүй тохиолдолд тэдгээрийн хугацааг шинэ сонгууль хүртэл

хараат бус байгууллага гэж үзэж байсан боловч Сеул дахь өөрийн талынхныг нэгтгэж байдаг Чхондогё сектын удирдлагатай байнга холбоотой байсан. Намын дарга нь Ким Даль Хён байсан. Намын удирдлага лисынманы дэглэмийг баримталдаг, коммунистуудад илт сөргөөр ханддаг байсан. 1948 оны 1 сарын 29-нд сектийн удирдагч нарын хурал дээр 3 сарын 1-нд Пхеньянд 1919 онд болсон японы эсрэг бослого, коммунизмын эсрэг жагсаалын ойг тэмдэглэх шийдвэр гаргасан. Хуйвалдааныг илрүүлсний дүнд намын олон удирдагчид баривчлагдсан. Ким Даль Хён илтгэлийг дэмжээгүй тул намын дарга хэвээр үлдсэн. Намын төв Хорооны дарга-Рю Мин Ён (эмэгтэй. Сол-류미영), гишүүний тоо ойролцоогоор 10 мянга. Чхондөгё-. 류미영 XX зуунд гарсан Солонгосын үндэсний шашны хөдөлгөөн-ХІХ зууны Тонхак хөдөлгөөний залгамжлагч байсан. Өөртөө Буддизм, Күнфүци, христ, даосизмын шинжүүдийг агуулахаар сонгосон бөгөөд эцэст нь чхөдогёос маш олон сектүүд үүсэхэд хүргэсэн (гол сургаал нь бурхан хүн бүрийн сэтгэлд оршдог, гэхдээ түүнд итгэж найдах хэрэггүй, газар дээр диваажинг байгуулья, хүмүүнлэг социалист үзэлтэй төстэй олон тооны сургаалтай. БНС- Улсад (өмнөд) чхондөгийг шүтэгчид ойролцоогоор 1,1 сая хүн.

1 XII удаагийн Ардын дээд хурлын сонгууль 2009 оны 3 сарын 8-нд болж өнгөрсөн. Энд СХН 606 суудал, ССДН- 50 суудал, Залуу нөхдийн нам -23 суудал, Япон дахь Хойт солонгосын иргэдийн холбоо (сол -조선천도교청 우당 ,)-6 суудал, бие даан нэр дэвшигчид 3 суудал тус тус авсан.

сунгаж болдог.

Орон нутгийн ардын хурлын тухайд социалист үндсэн хууль дараах үүрэг, бүрэн эрхийг тогтоосон:

1) Орон нутгийн ардын аж ахуйн төлөвлөгөө, биелэлтийн тайланг хэлэлцэн, батлах;

2) Орон нутгийн төсөв, түүний биелэлтийг хэлэлцэж батлах;

3) Улсын хуулийг өөрсдийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

4) Холбогдох ардын хурлын хороодын гишүүн, орлогч дарга, дарга, хэргийг удирдах даргыг сонгох, чөлөөлөх;

5) Холбогдох шүүхийн шүүгч, ардын төлөөлгчдийг сонгох, чөлөөлөх;

6) Холбогдох ардын хороо болон доод шатны ардын хурлын маргаантай тогтоолыг хүчингүй болгох.

Орон нутгийн ардын хурал байнгын бус үндсэн дээр, чуулганы хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулах бөгөөд энэ нь нэг талаас, депутатуудад хүн амтай холбоог таслахгүй байх, нөгөө талаас, “ардын сонгогчид”-д тавих шаардлагад хамааралгүй хэв маягийн амьдралаар амьдрах боломж олгодог.

Нутгийн ардын хурлын ээлжит чуулганыг холбогдох ардын хорооны санаачлагаар жилд нэгээс хоёр удаа хуралдуулна.

Ээлжит бус чуулганыг холбогдох ардын хороо өөрийн үзэмжээр, эсхүл нийт депутатын гуравны нэгийн шаардлагаар хуралдуулна.

Орон нутгийн хурлын чуулган хурлыг даргалах даргыг сонгоно.

Эрх зүйн хэм хэмжээний актын үндсэн хэлбэр нь орон нутгийн ардын хорооны тогтоол байна.

Орон нутгийн ардын хурлын чуулганы хооронд нутгийн ардын хороо үйл ажиллагаа явуулна.

Хөдөөгийн (төвд харьяалалтай хотууд), хотын (районы), хошуудын ардын хороод нь орон нутгийн ардын хурлын чуулганы хооронд нутгийн эрх мэдлийн байгууллага болдог бөгөөд мөн засаг захиргааны гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага байна.

Орон нутгийн ардын хороод нь дарга, даргын орлогч, хэрэг удирдагч, гишүүдээс бүрдэнэ.

Орон нутгийн ардын хороодын бүрэн эрхийн хугацаа нь холбогдох ардын хурлын бүрэн эрхийн хугацаатай адил байна.

Нутгийн ардын хурлын хороод дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) Ардын хурлын чуулганыг зарлах;

2) Ардын хуралд депутатыг сонгох ажлыг зохион байгуулах;

3) Ардын хурлын депутатуудтай ажиллах;

4) Хууль тогтоомж, зарлиг, холбогдох дээд шатны ардын хурал, Сайд нарын кабинет, яам, тусгай газрын тогтоол, захирамжийг гүйцэтгэх;

5) Холбогдох районуудад захиргааны бүх хэргийг зохион байгуулах, гүйцэтгэх;

6) Ардын аж ахуйг хөгжүүлэх, орон нутгийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

7) Орон нутгийн төсвийг боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

8) Нийгмийн дэг журмыг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх, өмч болон төрийн ашиг сонирхол, нийгмийн болон хоршооны байгууллагыг хамгаалах, нутаг дэвсгэрийн иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах чиглэлээр арга хэмжээ авах;

9) Холбогдох районуудад төрийн удирдлагын журам тогтоох ажлыг хянах, шалгах;

10) Доод шатны ардын хороодын үйл ажиллагааг удирдах;

11) Маргаантай холбогдох доод шатны ардын хурлын тогтоолыг түдгэлзүүлэх, ардын хорооны ийм тогтоолыг хүчингүй болгох.

Орон нутгийн ардын хороод нь засгийн хамтын байгууллагын хувьд өөрийн үйл ажиллагааг нэгдсэн хуралдаан, тэргүүлэгчдийн хурал хэлбэрээр явуулна.

Орон нутгийн ардын хорооны нэгдсэн хуралдаан дээр хорооны бүх гишүүд, тэргүүлэгчдийн хурал дээр түүний дарга, орлогчид, хэргийг удирдагчид оролцох үүрэгтэй.

Орон нутгийн ардын хорооны нэгдсэн хуралдаан үүргээ биелүүлж, бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад үүссэн асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэнэ.

Нутгийн ардын хорооны тэргүүлэгчдийн хурал нь зөвхөн нэгдсэн хуралдаанаас даалгасан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

Нутгийн ардын хороо нь хууль хэрэгжүүлэх удирдлагын акт болох хэм хэмжээний шинжтэй тогтоол баталж, захирамж гаргана.

Орон нутгийн ардын хорооны дэргэд ардын хороодод тодорхой үйл ажиллагааны чиглэлээр туслалцаа үзүүлэх үндсэн зорилттой байнгын бус салбарын комиссыг үйл ажиллагааны чиглэлээр байгуулж болно.

Ардчилсан төвлөрлийн зарчмыг хэрэгжүүлэх хүрээнд орон нутгийн ардын хороод нь өөрийн үйл ажиллагаагаа (“хоёрдмол удирдлага” дор байна) холбогдох ардын хурлын өмнө тайлагнана. Мөн түүнчлэн дээд шатны ардын хороонд болон Сайд нарын кабинетад харьяалагдана.

БНАСАУ-ын хилийн гадна хамгийн түгээмэл болсон хамгийн чухал нийгмийн хяналт, ардын хяналтын тогтолцоон дахь механизм, төр засгийн олон нийтийн хамгийн доод үүр бол инминбан¹ - ардын, эсхүл хөршийн - олон сууцтай орон сууцны байрны ойролцоогоор 40 гэр бүлийг нэгтгэдэг

¹ Ардын бүлэг- (сол. 인민반)-ардын бүлэгт БНАСАУ-ын бүх хүн ам зохион байгуулагдсан, ардын бүлэгт дунджаар 20-50 гэр бүл ордог.

бүлэг.

Ардын бүлгийн үйл ажиллагааг судлах их сонирхолтой байдаг, учир нь тэдгээр нь БНАСАУ-д зохион байгуулагддаг үзэл суртлын болон олон нийтийг хамарсан кампанит ажиллагаа, хөдөлгөөний ихэнхэд идэвхтэйгээр оролцсон байдаг. Үүний зэрэгцээгээр инминбан - нийтийн механизм бөгөөд de facto орон нутгийн эрх мэдлийн байгууллагуудад хүн амтай шууд ажиллах боломж олгодог, шууд болон эргэх холбооны арга нь төрийн байгууллагуудад зохицуулж буй асуудлын хүрээгээ дээд зэргээр өргөтгөх боломж олгодог.

Ардын бүлэг бүр удирдагчтай (сол. 인민반장 Инмин банджан). Түүний үүрэгт хурал, нийгмийн ажлыг зохион байгуулах, түүнчлэн бүлгийн дотор дэг журам, улс төрийн найдвартай байдлыг дэмжих ордог.

Энэхүү механизмыг илүү сайн ойлгохын тулд түүхийг эргэж харах ёстой. Эрдэмтэн-эрх зүй судлаачдын таамаглалаар инминбаны уламжлал, үүслийн хувьд Хятадын түүхийн дунд үед хамаардаг. XVI-XIX зуунд солонгосын номын хорхойтон, философчид, XIX зууны хоёрдугаар хагаст энэ бүсийн орчин үеийн мэргэжилтнүүд Солонгосын төрийн байгуулалтад Хятадын нөлөөний чухлыг дуу нэгтэй үнэлж байсан¹.

Энэхүү тогтолцоо дундад зууны Солонгост ч байсан бөгөөд олон талаар Хятадын таван хашааны болон арван хашааны нийгэмлэгийн олон зүйлийг хуулбарласан байжээ.

XV зууны эхэнд Солонгост инбо-хөршийн нэгдлийг (нутгийн орон нутаг дэвсгэрийн нийгэмлэг) тойргоор батлан даах эртний уламжлал дээр үндэслэсэн. Энэ үйл ажиллагааны үндсэн зорилго нь засгийн зүгээс хүн бүрийг өдөр тутам хянах явдал байв. Тухайлбал инбо-гийн ахлах нь нийгмийн ажлын гүйцэтгэлийг хянах, шинээр ирэгсэд, үрэгдэгсэд, шинээр төрөгсдийг бүртгэх, гамшиг тохиолдсон болон форс мажор нөхцөлд туслалцаа үзүүлэх үүрэгтэй. Инбогийн насанд хүрсэн бүх гишүүд татвар төлөх, хөдөлмөр хийх тухайд хамтын хариуцлага хүлээдэг².

Дараа нь инбо тхон /таван айлын хашаа/ болж өөрчлөгдсөн. Гэмт хэргийн тухай мэдээлээгүй, нуусан тохиолдолд тхонд орсон гэр бүлийнхнийг бүгдийг нь нийслэлээс цөллөгт явуулж байсан³.

XIX зууны хоёрдугаар хагаст Солонгос их гүрнүүдийн колончлолоос чөлөөлөгдсөн үед оршин суугаа газраар хамтын хариуцлагын тогтолцоог гадаад орноос ирж болох халдлагаас хамгаалах, мөн дотоодын иргэд гадаадын шашин дэлгэрүүлэгчидтэй холбоо тогтооход хяналт тавихын тулд

1 Үзэх: Энциклопедический словарь Гранат. Т.25.СПб. 1917.с.198.

2 Үзэх: Ванин Ю.В. Аграрный строй феодальной Кореи XV-XVI вв. М., 1981. С. 182-183.

3 Үзэх: мөн тэнд. х. 183.

мөн өргөнөөр ашиглах болсон¹.

Япон Улс Солонгосыг колоничлох хугацаандаа энэ тогтолцоог зарим талаар түүний анхны зорилгод нийцүүлэн боловсронгуй болгож хадгалсаар ирсэн. Тухайлбал, 1934 оноос эхлэн хамтын хариуцлагын зарчмыг Солонгосын хилийн чанадад амьдардаг солонгосчууд олноор амьдарч байсан Манжуурт японы эзлэн түрэмгийллийн эсрэг партизаны хөдөлгөөнтэй тэмцэхэд өргөнөөр ашигласан².

1930 онд Японы эрх баригчидын санаачлагаар Солонгост янз бүрийн эх оронч байгууллагууд болон олон нийтийн хөдөлгөөнүүдийг хүн амын өөр өөр үе давхарга, ялангуяа залууст тавих хяналтыг хангахын тулд зохион байгуулсан. Цагдаагийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагааны хүрээг ихээхэн өргөтгөсөн. Энэхүү хамгаалалт нь улс төр, боловсрол, шашин, ёс суртахуун, эрүүл мэнд, нийгмийн хангамж, төрөл бүрийн татвар хураах, сайн дурын өглөгийн салбарт чухал хяналтын байгууллага болсон³.

1940 онд япончууд Солонгос даяар 350 мянган хөршийн эх орончдын бүлгийг байгуулсан. Бүлэг бүрт арван айлын хашаа ордог. Бүлгүүд нь японы эзлэн түрэмгийлэгчдийн захиргааны үйл ажиллагааг явуулахад зориулан бүх төрлийн татвар, мөнгөн болон материаллаг өглөгийг хураах, юуны өмнө хөдөлмөрийн үүргийг биелэлт, цагдаагийн хяналт болон өргөн хэрэглээний зарим төрлийн бүтээгдэхүүнийг нормын дагуу хуваарилах доод шатны хяналтын нэгж болж байсан.

1945 онд Солонгосыг чөлөөлсний дараа улсын хойт хэсэгт төрийн эрх барих байгууллагыг байгуулахтай хамт инминбаныг сэргээн байгуулж эхэлсэн нь одоо үед БНАСАУ-ын бүх хүн ам хамрагдаад байна. БНАСАУ-ын албан тушаалтнуудын хэлсэн үг, албан ёсны нийтлэлүүдэд хэлснээр “нийгмийн бүх гишүүд ямар нэг ялгаагүйгээр бүгд ардын бүлэгт нэгдсэн”, бүлэг нь “төр засгийн хамгийн доод шатны нэгж мөн”⁴.

БНАСАУ-ын төрийн эрх барих дээд байгууллага байгуулагдахаас өмнө Хойт Солонгосын Ардын Түр Хороо бүр анхны хууль тогтоомждоо-хүн амд хяналт тавих, төрөл бүрийн ажилд дайчлах бүрэн эрхийг засагт олгосон⁵.

Хэвлэл, мэдээллийн хэрэгслийн мэдээллийг шүүн тунгааж үзэхэд бүлгийн үйл ажиллагаанд Ким Ир Сен болон Ким Чин Ир нар байнга

1 Үзэх: Тягай Г.Д. Формирование идеологии национально-освободительного движения в Корее. М., 1983. С.55.

2 Үзэх: Ким Ир Сен. Өгүүлэгүүд. Т.1. Пхеньян, 1980. Х.2-4.

3 Үзэх: Henderson G. Korea: The Politics of the Vortex. Harvard Univ. Press, 1978. P.79.

4 로동신문 (Нодон синмун, Ажилчдын сонин), 1993.11.26; “평양신문” Пхёнян синмун Пхеньяны мэдээ) 07.04.1983.

5 Үзэх: Конституция и основные законодательные акты Корейской Народной Республики. М., 1952.с.346-347.

анхаарлаа хандуулж байсан. Тэд нэг бус удаа “тэдний зорилтоос бүлгийн удирдагчдын ажлын арга барил хүртэл бүлгийн үйл ажиллагааны талаар “дэлгэрэнгүй зааварчлага”¹ өгч байсан.

Ким Чен Ир “чучхе үзлийн үндсэн дээр нийгмийг бүхэлд нь өөрчлөх бодлогын дагуу бүлгийн ажлыг сайжруулах талаар”² дорвитой арга хэмжээг хэрэгжүүлсэн.

“Орон нутаг дахь удирдлага” бүлгийн ажиллагааг удирдах явцдаа Ким Чен Ир 1972 оны 7 сарын 11-нд Пхеньянд хэлсэн үгэндээ тэдгээрийн ажлыг зохион байгуулах “хөтөлбөрчилсөн заавар”, тэдгээрийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх арга замыг “бүх талаас нь тодорхойлсон”.

Тэр үеэс БНАСАУ хорооллын, бүлгийн, “7-р сарын 11-ний Улаан туг” хүндэт нэрийг авах олныг хамарсан хөдөлгөөн тууштай өрнөсөн³.

Ардын бүлгийн “үлгэр жишээ ажилтан”-ы ихэвчлэн удирдагчид (ахлах) болон орон сууцны хорооллын бичиг хэрэг (хороолын контор)-үүдийн хурлыг Төв, орон нутагт жилд нэгээс доошгүй удаа байнга зохион байгуулдаг. Хуралдаанд намын хороод болон орон нутгийн засаг захиргааны дарга нар *ex officio* (албан тушаалаас хамаарч) оролцдог.

Зохион байгуулалтын ийм маягийн хэлбэрийг удирдлагуудыг дотоод, гадаад бодлого болон бүлгийн үйл ажиллагаа, хийсэн ажлын тайлан, бүлгийн онцгой ажилтныг шагнаж урамшуулах, улс орны удирдагчдын ээлжит тангараг рүү гол чиглэлийг хандуулахад ашигладаг. Инминбаны идэвхтнүүдийн Бүгд Найрамдах Улсын хурлыг СХН, БНАСАУ-ын Засгийн газарын оролцоотойгоор 1993 оны 11 сарын 24-25-ны өдрүүдэд Пхеньянд зохион байгуулсан. Хэвлэлд мэдээлснээр энэ хурал Ким Чен Ирийн өөрийнх нь даалгавраар хийгдсэн байна⁴.

Ардын бүлгүүд орон сууцны хорооллын бичиг хэрэг буюу холбогдох ардын хороодын эрх шилжүүлсэн байгууллага гэж нэрлэгддэг конторуудтай харилцан хамтарч ажилладаг. Тэд орон нутгийн хүн ам болон орон нутгийн засаг захиргааг холбогч хэсэг нь болдог. Орон сууцны хорооллын конторын ажиллагааны хүрээнд 40-60 ардын бүлэг хамаардаг.

Орон сууцны хорооллын контор нь нутаг дэвсгэртээ улс орны удирдагчдын даалгавар, СХН-ын болон төв Засгийн газрын бодлого, шийдвэрийг тайлбарлаж, тэдгээрийн биелэлтийг зохион байгуулж, хэрэгжүүлдэг. Түүнчлэн орон сууцны сангийн тооллого, орон сууцны хорооллын оршин суугчдын үйлчлүүлэх дэлгүүрийн хуваарийг гаргаж, нормчиллол тогтоосон хангамжийн дагуу зайлшгүй хэрэгцээний зүйлийг

1 평양신문, (Пхёнян синмун, Пхеньяны мэдээ), 1983.04.07

2 Мөн тэнд бий

3 민주조선 (Минчжоу Чосон, Ардчилсан Солонгос) 1993.11.26.

4 “로동신문” (Нодон синмун, Ажилчдын сонин), 1993.11.26.

авахад хяналт тавих, хүн амд төрөл бүрийн лавлагаа, зөвшөөрөл олгох, үүнд өөр нутаг руу явах зөвшөөрөл орно. Эцэст нь түүний чиг үүрэгт ардын бүлгийг удирдах чиг үүрэг орох бөгөөд тэдгээрээр дамжуулж өөрийн чиг үүргийн ихэнх хэсгийг гүйцэтгэдэг¹.

Орон сууцны хорооллын конторын үндсэн зорилт, чиг үүрэг нь ардын бүлгийнхтэй маш ойр бөгөөд давхацдаг учраас эдгээр хоёр бүтцийн үйл ажиллагааг тайлбарлахдаа тэдгээрийг хамтад нь авч үзэж, шаардлагатай бол зарим онцлогийг нь дурьддаг².

Орон сууцны хорооллын контор бүр цөөхөн орон тооны ажилтнуудтай байдаг. Түүнийг хотын ардын хорооноос томилсон эрхлэгч удирддаг. Үүнээс гадна, конторын ажилтнуудын дунд ардын аюулгүй байдлын, ариун цэвэр, эрүүл ахуйн болон хэвлэсэн материал түгээгч ажилтан байдаг.

Хэвлэл түгээгчийн үүрэгт ахлахаас материалыг хүлээн авч шуудангаар илгээх, ахлах болон тодорхой ардын бүлгийн гишүүдийн нэр дээр ирсэн шуудан хүргэх ажил орно.

Тухайн оронд мөрдөж байгаа журмаар шуудангаар илгээж байгаа захидал, бусад илгээмж дээр гэрийн буюу байрын дугаарыг заадаггүй, харин орон сууцны хороолол болон ардын бүлгийн дугаарыг заадаг. Ийм маягаар орон сууцны хорооллын контор болон ардын бүлгийн ахлагч нь өөрийн харьяалалд байгаа иргэдийн захидал харилцаанд хяналт тавих боломжтой байдаг.

Орон сууцны хорооллын Солонгосын хөдөлмөрийн намын байгууллагын нарийн бичгийн дарга ардын бүлгийн намын нарийн бичгээс ялгаатай нь чөлөөлөгдсөн намын ажилтан энэ үүргийг гүйцэтгэдэг, хотын буюу хошууны намын хорооны орон тооны ажилтан байдаг, тухайн хорооноос тогтмол цалин авдаг. Орон сууцны хорооллын намын байгууллага конторт ажилладаг ардын бүлгийн намын үүрийн ажилтнаас (гэрийн эзэгтэй, тэтгэврийн хүн, хөгжлийн бэрхшээлтэй хүн) гадна намын үүрт тухайн орон сууцны хороололд амьдардаг эмнэлгийн, боловсролын, соёлын байгууллагын ажилтнуудыг ажиллуулж болно. Жишээ нь, Пхеньяны Синри хорооллын намын байгууллагад тухайн орон сууцны хороололд байрладаг эмнэлэг, ясли, сургууль, театрт ажилладаг СХН-ын гишүүд ордог байсан³.

Улсын нөөц хүрэлцээгүй, хатуу эдийн засаг, хүнсний бүтээгдэхүүн болон аж үйлдвэрийн бүтээгдэхүүний социализмын тэгш хуваарилалт зэрэг ХХ дугаар зууны 90-ээд оны дунд хүртэлх хугацааны БНАСАУ-ын хүн амын амьдралын нөхцөлийн зарим сонирхолтой үзэгдлийг авч үзье.

1 Үзэх: Гудошников Л.М. Орон сууцны хорооллын бичиг хэрэг ба ардын группы. Советы депутатов трудящихся. М., 1961. # 1. V.103.

2 Үзэх: Ким Ир Сен. Өгүүллэгийн түүвэр. Боть 25. Х.440.

3 Үзэх: Гудошников Д.М. Жагсаалтад дурдсан бүтээл. х.103.

Орон сууцны хорооллын конторын үйл ажиллагааны нэг чухал хүрээ нь орон сууцны хорооллын нутаг дэвсгэр дээр амьдрагчидыг хүнсний бүтээгдэхүүн, аж үйлдвэрийн бараагаар хангахын тулд тэдгээрийг тодорхой дэлгүүрээр үйлчлүүлдэг байсан. Бүлгийн ахлагч сард нэг, хоёр удаа орон сууцны хорооллын конторт цагаан будаа, мах, ургамлын тосны картыг хүлээн авч, ардын бүлгийн гишүүдэд тарааж өгдөг байсан.

Хүн ам хүнсний бүтээгдэхүүн болон барааг хүлээн авч байсан гол баримт бичиг нь худалдан авагчийн гэр бүлийн дэвтэр гэгч зүйл юм. Энэхүү дэвтрийг гэр бүл бүрт зөвхөн нэг хувийг хөтлөх бөгөөд өөрийнх нь оршин суугаа орон сууцны хорооллын дэлгүүрт байдаг байсан. Өөр бусад дэлгүүр эдгээр гэр бүлийнхэнд юуг ч худалддаггүй байсан.

Дэвтэрт гэр бүлийн гишүүдийн тоо, тэдний төлөвлөж байгаа жилийн орлогыг тэмдэглэдэг. “Төсөөлж байгаа орлогыг” тусгай багананд бичдэг, мөн хотын захад буюу хөдөө амьдардаг гэр бүлийн тухайд улсад жилд хоёр гахай худалдсанаас олох орлогыг тэмдэглэдэг. Хөдөөгийн болон том хотуудын захад амьдардаг иргэд жилд 2 гахай өсгөх үүрэгтэй байсан.

Гэр бүлийн дэвтрийн нэг хэсэгт “гэр бүлд болсон гол үйл явдал” гэж гарчигласан зүйл бий, үүнд БНАСАУ-ын иргэд нормативт бараа, бүтээгдэхүүнээс илүү бүтээгдэхүүн авч болох зургаан тохиолдлыг тоочсон байдаг байсан. Гол үйл явдлын дунд дараахыг дурдсан: 60 насны ойн баяр, 70 насны ойн баяр, хурим, хүүхэд төрсөн, гэр бүлийн гишүүн нас барсан, бусад үйл явдал.

Дараагийн бүлэг-сэнхваль чонман буюу үгийг шууд орчуулвал - “амьдралын хэтийн төлөв”. Энд гэр бүл худалдан авч болох удаан хугацааны хэрэглээний 17 нэр төрлийн аж үйлдвэрийн барааг тоочсон байсан. Холбогдох хэсэгт нь тодорхой барааг худалдан авсан огноог тэмдэглэнэ. Нэг нэрийн барааг зөвхөн засаг захиргаанаас тогтоосон хэрэглэх хугацаа дууссаны дараа худалдан авах боломжтой. Ингээд 1980 оны сүүлчээр энэ жагсаалтад телевизор, оёдлын машин, цаг, одоо, хөнжлийн даавуу, хөшиг, малгай, пальто орж байсан.

Үүнээс гадна “гал тогооны эд хогшил”, “даавуу болон хувцас” гэсэн бүлэг байдаг байсан. Сүүлчийн бүлгийг “төлөвлөөгүй орлого” гэж нэрлэсэн бөгөөд, үүнд гадаадад амьдарч байгаа төрөл төрөгсдөөс нь ирсэн мөнгийг тэмдэглэдэг.

Ийм маягаар худалдан авагчийн гэр бүлийн дэвтэр 1990 оны дунд үе хүртэл буюу төр өөрийн үүргээ биелүүлэх боломжгүй болсоноос нормчилсон хангалтын тогтолцоо ихээхэн уналтад орох хүртэл иргэдийн материаллаг байдалд бүх зүйлийг хамарсан өргөн хүрээний хяналт болсон. Энэ нь зөвхөн материалаг зүйлийг олж авахад тавих хяналт бус оршин суух газраа засаг захиргааны зөвшөөрөлгүйгээр солихыг хязгаарласан. Учир нь, хуваарилсан дэлгүүрээс өөр газарт ямар нэг зүйл худалдан авах боломжгүй

байсан.

Хүн амыг хүнсний гол гол төрлийн бүтээгдэхүүнээр хангах тогтолцоо илүү төвөгтэй байсан бөгөөд дэлгүүр болон хангалтын тусгай цэгүүдээс цагаан будаа гэх мэт хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнийг олгож байсан.

Нийгмийн шат давхаргад хүний эзлэх байр суурь болон тодорхой хот, суурины складанд байгаа үрийн нөөцөөс хамааруулж хуваарьт хүнсэн дэх цагаан будааны хэмжээ тавны нэг хүртэл буурч болно. Үлдсэн хэсэгт нь ихэвчлэн эрдэнэ шиш, гаолян, бусад төрлийн үр эзэлдэг.

Хүн амын зарим бүлэг нь хүнсний болон аж үйлдвэрийн барааны тусгай хангамжтай байсан. Үүнд СХН-ын аппаратын дээд болон дунд шатныхан, зэвсэгт хүчний генералууд, японы эсрэг дайнд оролцогчид хамрагддаг. Эдгээр ангиллын хүмүүс болон батлан хамгаалахын гол гол үйлдвэрийн ажилчид бүр 2002 оны зуны өөрчлөлтийн дараа ч өөрсдийн хуваарьт бүтээгдэхүүнийг хөнгөлөлттэй үнээр авдаг байсан.

Хүн амд зориулсан *үндсэн* болон нэмэгдэл хүсний бүтээгдэхүүний жагсаалтыг төрөөс тогтоодог байсан. Үндсэн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд урьдчилан захиалаггүйгээр, тодорхой хугацаанд, нормоор олгогдоно. Тэдгээрийн жагсаалтыг тэмдэглэлийн дэвтэр маягтайгаар хэвлэж айл бүрт өгдөг. Энд дурдсан бүтээгдэхүүний худалдан авах үедээ тухайн дэвтэр дээр худалдан авсан хэмжээ, худалдан авсан огноог тэмдэглэдэг.

Барааг худалдан авахын өмнө иргэн хялбар бус процедурыг дамжих ёстой байсан. Эхлээд иргэн дэлгүүр ороод *тусгай хянагч* дээр очиж өөрийн биеийн байцаалтаа үзүүлнэ. Тусгай хянагч нь мэдээллийг өөрийн дэвтэр дэх мэдээлэлтэй тулган шалгаж, дэвтэрт өөрийн гараар бүтээгдэхүүн худалдсан тухай тэмдэглэл хийж, энэхүү тэмдэглэл дээр тамга дарж, худалдан авагчийн гарын үсгийг зуруулна. Дараа нь хянагч худалдан авч болох махны хэмжээг бичсэн чек олгоно. Худалдан авагч чекийг худалдагчид өгч мөнгөө төлөөд барааг авна.

Ардын бүлгийн эрх зүйн байдал, түүний гишүүдийн эрх, үүрэг гадаадынхны хувьд хаалттай *тусгай баримт бичигт* тэмдэглэдэг.

Бүлгийг ахлагч толгойлдог, түүнийг орон сууцны хорооллын конторын саналыг харгалзан сонгодог, гэхдээ жинхэнэдээ бол томилдог. Ахлагчид нь ихэнхдээ ямар нэг шалтгаанаар ажилладаггүй ардын бүлгийн гишүүн, боломжтой бол бүр намын гишүүн бөгөөд ардын бүлэг дээр цаг хугацааны хувьд бүрэн байх боломжтой этгээд байх ёстой. Ахлагчдын олонх нь тэтгэврийнхэн, мөн олон эмэгтэйчүүд байдаг.

Ахлагчийн орлогч /зарим бүлэг 2 орлогчтой-эрүүл ахуй-ариун цэврийн ажилтан, ухуулагч/-ийг мөн дээрх маягаар хууль ёсны болгоно. Хойт Солонгосоос зугтагсдын мэдээллээр бүлэг бүрт аюулгүй байдлын агент¹

1 Human right in North Korea. (Хойд Солонгос дахь хүний эрхийн асуудал) Seoul. 1991. p.185

байдаг, гэхдээ ийм мэдээлэл үнэнтэй, худалтай байдаг. Эдгээр этгээд нь бүлгийн “цөм”¹-ийг бүрдүүлдэг.

Ардын бүлгийн ахлагч төр засгийн бүтэц дэх хамгийн тогтвортой эрх мэдлийн хэсэг гэж харагдаж байна. Тухайлбал, 1963 онд Пхеньянд болсон ардын бүлгийн үлгэр жишээ ажилчдын хурал дээр ахлагчийн албыг 1946 оноос 16 жил хашсан ахлагч өөрийн туршлагыг хуваалцсан. Энэ хуралд ахлагчийн албыг 8-10 жил хашсан олон хүмүүс оролцсон².

Бүлэгт ажил эрхэлдэггүй гурваас дээш СХН-ын гишүүн байх тохиолдолд нарийн бичгээр толгойлуулсан намын үүрийг байгуулдаг. Бусад тохиолдолд намын үүр нь зэрэгцээ орших хэд хэдэн орон сууцны хорооллын ажилтнуудын дунд байгуулагддаг.

Бүлгийн гишүүдийн хурлыг сард нэг удаа, шаардлагатай бол үүнээс олон удаа зохион байгуулна.

Ээлжит бус хурлыг хуралдуулах үндэслэл нь төрийн удирдлагын зааварчлага, нийгмийн том хэмжээний ажилд ажиллах хүчийг нэгтгэх, бүлгийн гишүүд ноцтой гэмт хэрэг үйлдсэн, захиргааны хууль зөрчсөн үйлдэлд тооцно.

Ким Ир Сений өөд болсны дараа Хойт Солонгосоос зугтсан олон хүмүүсийн мэдүүлэг дээр үндэслэсэн Өмнөд Солонгосын олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд нийтлэгдсэн мэдээллээр бүлгийн хяналт-ажиглалтын чиг үүргийг эрчимжүүлэх, үүнд холбогдох ажилтнуудын материаллаг сонирхлыг нэмэгдүүлэх оролдлогыг нэг биш удаа хийсэн. Ахлагчийн цалинг хоёр дахинаас илүүгээр нэмэгдүүлсэн. Эдгээр хүмүүсийн цалин 1980-аад онд сард 30 вон буюу улсын хэмжээний сарын цалингийн хэмжээний гуравны нэгтэй тэнцүү байсан бол 1990 онд сард 68 вон болсон. Мөн түүнчлэн тэдний хүнсний нормын хэмжээ нь тэтгэврийнхэнд тогтоосонтой адил үрээр үнэлэхэд 300 гр байсан бол ажилчдад зориулсантай ижил 700 гр болсон³.

БНАСАУ-ын албан ёсны нийтлэл материалуудаас төр нь бүлэг болон орон сууцны хорооллын конторын өмнө дараах үндсэн зорилтыг тавьдаг гэсэн дүгнэлт хийж болохоор байна:

- Үзэл суртлын боловсрол;
- Аж ахуй-зохион байгуулалтын ажиллагаа;
- Хүн амыг олон нийтийг хамарсан хөдөлгөөн, кампанит ажилд оролцуулах;

1 로동신 문 (Нодон синмун, Ажилчны сонин) 1963.03.15

2 로동신문 (Нодон синмун, Ажилчны сонин) 1963.03.13

3 Пукхан сिल्сан. Чонхап чаречип. (Обстановка в Северной Корее: Сб. материалов). Сеул, 1995. 3.131-132.

- Өөрөөр сэтгэхээс урьдчилан сэргийлэх зорилготой захиргааны хяналт,

Хүн амын итгэл үнэмшлийг бий болгох (“индокринация”) хэрэгт хамгийн чухал нь төрийн албан ёсны үзэл санаа /чучхе/-г сурталчлах (хүн бол хувь заяаныхаа болон байгалын эзэн, өвөрмөц байх үзэл санаа) юм¹.

Дотоод улс төрийн цаг үеийн бодлогоос хамаарч дараах асуудалд анхаарал төвлөрүүлж байсан:

- ангийн боловсрол;
- намын бодлогоор хүмүүжүүлэх;
- хувьсгалын уламжлалаар хүмүүжлэх;
- социалист эх оронч үзлээр хүмүүжүүлэх;
- коммунист хүмүүжлээр хүмүүжүүлэх;
- социалист ёс суртахууны хүмүүжлээр хүмүүжүүлэх².

БНАСАУ-ын хөгжлийн өөр өөр түвшинд чухалчлах зүйл нь өөрчлөгдөж байсан. XX зууны дунд үед эхний ээлжинд тавигдаж байсан хамтач үзлийг сурталчлах сурталчилгаа нь социализмын зүгээс капитализмтай тэмцэх тэмцэл нь-юуны өмнө хамт олонч үзэл, хувийн үзлийн хоорондын тэмцэл мөн гэсэн уриан дор явагдаж байсан. Хойт Солонгосын эрдэмтдийнхээр капитализмаас социализмын ялгарах давуу тал нь чухамхүү хувь хүнээс хамт олон давуу гэдэг үзэл бөгөөд БНАСАУ-д “ард түмэн хамт олонч үзлээр зэвсэглэх ёстой”³.

1 Барууны шинжлэх ухааны уламжлалд бидний үзэж байгаагаар эх хэл дээрээ бичиж байгаа текстэд гадаадын нэр томъёо, нэрийг тайлбаргүй хийх туйлын алдаатай практик байдаг. Ихэнхдээ энэхүү алдаатай практик философи, сэтгэл зүй, нийгэм судлал, түүхийн шинжлэх ухаанд тааралддаг. Хэн нэгний хүсээгүй юманд шинжлэх ухаанч юм шиг байдалтай болгох бүрхэгдүүлэхийн тулд орчуулга хийхгүй байх, “шинэ үг” бодож олох аргыг хэрэглэдэг. Жишээ нь, Газар зүйн нэр, хятадын хаадын нэр оноосон нэрийг зөвхөн (жишээ нь, Шихуан-ди - Нэг дэх хаан) орчуулах нь эртний бүх Хятадын түүхийн шинжлэх ухаанч фактуудыг түүхэн үнэ цэнэгүй факт болгон хувиргаж, хүмүүст эргэлзээ төрүүлэх болно. Чучхе -주체, 主體) үгчилсэн орчуулга주(чу)- эзэн, 체 (че) -“бие, агуулга, мөн чанар, байгаль”, уг үгийн утга зохиолын агуулга нь өөрийн ахуй, бие даасан байдал, хүн өөрийнхөө болон хүрээлэн байгаа орчны эзэн, эзэн хүн бүхнийг өөрөө шийддэг. БНАСАУ-д оршин тогтнох өвөрмөц чанар байдал /“самобытность”/-ын эртний солонгосын сэтгэлгээний үндсэн дээр марксизм, ленинизмд шилжүүлэх Ким Ир Сений томъёолсон өөрийн үндэсний онцлог бүхий, дэлхийн хувьсгалаас тусдаа болон дэлхийн хувьсгалаас татгалзсан “өөрийн хүчин дээр тулгуурласан социализмыг байгуулах” гэдэг гаргалгаа юм. Гэвч энэхүү томъёолол “чучхе”-г Өмнөд Солонгост ижил утгатай шашин, философийн нэр томъёонд хэрэглэдэг (Зохиогчийн тэмдэглэл).

2 Ан Чон Хун. Чхинэханын чидоча кимченар тончие ыхан инмин чонгвон рироный симхвапальчон (Хүндэт удирдагч Ким Чин Ирийн ардын засгийн онолыг гүнзгийрүүлэн хөгжүүлэх нь). Пхеньян, 1991. Х.268.

3 Үзэх: Ким Чен Ир. Ставить во главу угла идеологическую работу-закономерное требование дела социализма. Пхеньян, 1995. С.3.с.21.

Намд үнэнч байх ёстой, зөвхөн СХН-ын удирдлага дор, улс орны иргэд “үнэ цэнэтэй улс төрийн амьдралаар амьдарч чадах бөгөөд ингэснээр “жинхэнэ амьдрал, аз жаргалын таашаалыг авна”. Энэ бол намаас олгох БНАСАУ-ын иргэний амьдрал, хувь заяа бөгөөд “түүнд үнэнч байх нь тэдний зайлшгүй үүрэг болно¹.”

Намын бодлогоор хүмүүжих, эсхүл илүү оновчтойгоор түүний бодлогын сурталчилгаа нь “бүх ард түмэн намын бодлогыг хамгийн үнэн, хамгийн шударга гэж үзэж хүлээн авах”, мөн “тэдгээрийг амьдралд нэвтрүүлэхэд “хязгааргүй, амь бие хайргүй” тэмцэхэд орших ёстой.

Хувьсгалт уламжлалд хандах нь удирдагчтай харьцах харилцаатай адил юм. Хувьсгалын уламжлалыг хамгаалах бол хувь хүнийг жинхэнэ хувьсгалч мөн эсэхийг шалгадаг шалгуур² мөн. “Манай ард түмэн, нам өвлөж авах ёстой” хувьсгалт ёс заншил бол - Пхеньянд онцлон тэмдэглэснээр Ким Чен Ир-ийн байгуулсан хувьсгалын ёс суртахуун - чучхе юм”³.

БНАСАУ-д ийм ёс заншлын онцгой ач холбогдлыг “орчин үеийн ревизионист, социализмаас урвагчид удирдлагын нэр хүнд, удирдах байр суурийг харлуулсан, хувьсгалчдын хойт үеийнхний үйл хэргийг устгасан, ингэснээр социализмын сүйрэлд тусалсан” гэж тайлбарладаг⁴.

Хүмүүжлийн сүүлчийн хоёр төрлийн гол чухал элемент нь империализмын “дайсагнагч чанарыг” болон түүний “нийгмийн хор хөнөөл”-ийг тайлбарлах юм.

XX зууны 90-ээд оны эхээр Зөвлөлт Холбоот Улс, Орос, Зүүн Европын улсуудад гарсан ард түмний амьдралын түвшингийн уналт, ажил хаялт, ажилгүйдэл, гэмт хэрэг зэрэг эдгээр улсуудад гарсан социалист ололтын уналтын тухай мэдээлэл бас нэмэгдсэн⁵.

Социалист эх оронч үзлийн хүмүүжил нь үнэн хэрэгтээ “Манайх-аар амьдрах”. “Нэн тэргүүнд - үндэстэн” гэсэн уриан дор “солонгос маягийн социализм”-ын давуу талын сурталчилгаа болж хувирсан.

1990-ээд оны дундуур БНАСАУ-д “армийг чухалчлах” бодлогыг социалист эх оронч хүмүүжлийн чухал хэлбэр болгон тунхагласнаар эх оронч үзлийг инминбаны шугамаар армид туслах ажлыг зохион байгуулах чухал хэлбэр болгосон. Ардын бүлгийн ахлагч нар “бэлэг”, хувийн ариун цэврийг сахихтай холбоотой бараа, ихэвчлэн бүлгийн гишүүдийн өөрсдийн гараар

1 Невэ Тхонсин. Сеул. 1997.01.23.

2 Осёлок 1) гуранз хэлбэртэй чулуу; 2) үнэт зүйлийн үйлдвэрлэлд чулууны чанарыг шалгадаг чулуу; 3) шилжсэн утгаар- ямар нэг шинж чанар, чанарыг тодорхойлоход хэрэглэдэг хэрэгсэл гэх мэт. (зохиогчийн тэмдэглэл)

3 Үзэх: Ким Чен Ир Жагсаалтад дурдсан бүтээл. х. 3, 24.

4 Мөн тэнд х.3, 4-6.

5 로동신문 (Нодон синмун, Ажилчны сонин) 2000.05.25.

хийсэн дулаан зүйлсийг армид тусламж болгохоор байнга цуглуулах болсон. Хүн амаас дайчдад зориулан бичсэн “урамшуулан дэмжсэн” захидлыг ихээр урамшуулах болсон¹. Социалист ёс суртахууны хүмүүжлийн тухайд хамтын ёс суртахуун дээр гол тулгуур хийдэг бөгөөд үүний илрэл нь нийгэмд бүхэлдээ “хувьсгалын санаачлага буцалж”, социалист бүтээн байгуулалт “эрчимтэйгээр урагшлах”-д илэрнэ.

Үзэл суртлын ажлын эдгээр бүх чиглэл хоорондоо нягт уялдаатай. Тухайлбал, намд үнэнч байхыг “хамт олонч үзлийн хамгийн дээд санаа”, “коммунист-хувьсгалчийн хамгийн үндсэн шинж”² гэж үздэг.

Улс орны удирдагчдын заасны дагуу орон сууцны хорооллын контор болон түүний ажилчдын гол зорилго нь орон сууцны хорооллын бүх оршин суугчдад “их удирдагчийн хайр халамжийг жигд түгээх” явдал байдаг. Орон сууцны хорооллын ажилтнууд “хүн ам солонгосын удирдагчийг нягт тойрон хүрээлсэн байх”, “гэр бүлийг хувьсгалжуулах” нөхцөлийг хангах, үүний үндсэн дээр “бүх нийгмийг хувьсгалжуулах” үүрэгтэй³.

Чучхе үзэл санаагаар хүмүүжүүлэхийн гол арга нь БНАСАУ-ын удирдагчдын сургаал, “СХН-ын бодлого хэрэгжүүлэх”, төрийн удирдлагын байгууллагын шийдвэрийг системтэйгээр судлах, тайлбарлах, хэрэгжүүлэх юм. Хувьсгалт уламжлал, ангич хүмүүжлийг олгохын тулд ардын бүлгийн гишүүд хотын нийтийн хуралд оролцох, ойролцоо байрлах дурсгалын цогцолбор дээр хамтаар цуглах, японы эсрэг тэмцэлд оролцсон ахмадуудтай уулзалт зохион байгуулах, “Киноны баатруудаас суралцах”-ын хүрээнд кино үзэх ажлыг зохион байгуулна.

Орон сууцны хорооллын контор болон ардын бүлэгтэй нягт холбоотойгоор Ким Чен Ирийн 1958 оны 7 сард өгсөн даалгаврын дагуу байгуулсан “таван гэр бүлийг хариуцах” тогтолцоо үйл ажиллагаа явуулдаг. Хэрвээ инминбан захиргааны болон засгийн чиглэлээр улс төрийн индоктринацийн үүрэг гүйцэтгэдэг бол таван гэр бүлийг хариуцсан сурталчилгааны тогтолцоо нь зэрэгцээ үйл ажиллагаа явуулахдаа тухайн ажлыг харин намын шугамаар хэрэгжүүлдэг. Энэ нь намын тогтолцооны хамгийн доод үүр байж, хүн амын улс төрийн найдвартай байдлыг хянаж, инминбаны үйл ажиллагааг хамгаалж байгаа юм шиг ажилладаг.

Ардын бүлэгт үзэл суртлын салбарт СХН-ын гол бодлогын нэг болох “гэр бүлийг хувьсгалжуулах” зорилтыг шийдвэрлэдэг. Ким Ир Сений зааснаар “Бид гэр бүлийг хувьсгажуулахаас эхэлж, дараа нь үүр, бригад, ардын бүлэг, цаашид цех, сууриныг хувьсгалжуулж, (энэ асуудлаар)

1 민주 조선 (Минчжү чосон. Ардчилсан Солонгос) 2000.03.07.

2 Үзэх: Ким Чен Ир. Жагсаалтад дурдсан бүтээл. х.3, 22.

3 Ан Чон Хун. Жагсаалтад дурдсан бүтээл. х. 264-265.

жишгийг бий болгож, тэдгээрийн туршлагыг алгуураар түгээж, нийгмийг бүхэлд нь хувьсгалжуулах, түүний бүх гишүүдийг ажилчин ангийн загвараар өөрчилнө.”¹

Эдгээр хичээл зүтгэл нь ялангуяа өдөр бүр удирдагчдын ажиглалтад байгаа ард түмэн болон үг, ажлын хоорондын зөрүү зэрэг тодорхой бэрхшээлтэй тулгардаг байж магадгүй.

Мөн тодруулбал, нам, төрийн ажилтнуудын зүгээс албан тушаалаа урвуулан ашиглах, тэдэнд албан тушаалын шугамаар олгосон автомашиныг тэдний гэр бүлийнхэн нь ашиглах тохиолдол олноор гарах болсныг Ким Чен Ирийн зүгээс шүүмжилж, нэрсийн жагсаалтад орсон ажилтнуудад хандаж үг хэлэхэд хүргэсэн. Үүгээр тэд “ярианы бай болох”-оос гадна өөрийн албан тушаалын нэр хүндэд хор учруулахыг урьдчилан сануулж, тэднээс “өөрийн гэр бүлийн гишүүдийн хувьсгалч хүмүүжилд онцгой анхаарал тавих”-ыг шаардсан².

“Хувьсгалч гэр бүл”-ийн тодорхой аргад - гэр бүлийн хурлыг байнга зохион байгуулж, “хувийн туршлагыг солилцох, хүн бүрийн хүрсэн амжилтыг бусдад танилцуулах, алдаа дутагдлыг шүүмжлэх...” . Ийм хурал дээр ардын бүлэг буюу орон сууцны хорооллын конторын “цөм”-ийн төлөөлөгчид оролцох нь ховор биш.

Гэр бүлийн гишүүний, магадгүй хүүхэд нь эцэг, эхийн талаар, эцэг эх нь нэгнийхээ, хүүхдийнхээ талаар мэдээлэл хүргэхийг зөвтгөх орчин үеийн нэг онолын үндэслэл нь “нийгэм-Улс төрийн”, “бие бялдын” амьдрал гэж нэрлэдэг зүйлийн үзэл баримтлал юм. “Нийгэм-Улс төрийн” амьдралыг нийгмийн гишүүн бүрт Удирдагч өгдөг, тийм учраас “хамгийн үнэ цэнэтэй” гэж зарладаг. Харин бие бялдрыг эх өгдөг бөгөөд БНАСАУ-д үүнийг эхнийх шигээ чухал биш гэж зарласан. XX зууны 80-аад оны эхнээс Ким Чен Ирийг хайрлах албан ёсны ухуулга сурталчилгаа иргэнийг хайрлах Ким Чен Ирийн хайр нь ”эхийн хайраас олон талаар илүү” мөн “эхгүйгээр амьдарч болно, харин хүндэт нөхөр Ким Чен Ирийн тэврэлтгүйгээр нэг минут ч амьдрахгүй” гэдэгт тухайн улсын бүх иргэдийг итгүүлдэг.³

БНАСАУ-ын удирдагчид залуусыг дээрх шалгуурын үзэл санаагаар “хязгааргүй үнэнч” хүмүүжүүлэх нь хүн амын индоктринаци /шүтлэгийн үндсийг бүрдүүлэх/ хийх хүрээн дэх ардын бүлгийн хоёр дахь ач холбогдол бүхий зорилт мөн. Үүнд мөн өмнөхөөс багагүй чухал ач холбогдол өгдөг, учир нь энэ тохиолдолд “ирээдүйн хувьсгалчдыг хүмүүжүүлэх” тухай, “чучхейн хэргийг найдвартай үргэлжлүүлэгчдийн” тухай ярьж байгаа юм.

1 Өнөөдрийн Солонгос. Пхеньян. 1983. # 6, х.20.

2 Үзэх: Ким Чен Ир. Яам, хороодын Захиргааны зөвлөлийн намын байгууллагын ажлыг сайжруулах тухай. Пхеньян, 1992. Х. 59.

3 Үзэх: Чве Ин Су. Ким Чен Ир- ард түмний удирдагч. Т. I. Пхеньян. 1983. Х. 331.

Ийм хүмүүжлийн гол зорилго нь орчин үеийн залууст “удирдагч болон түүнийг залгамжлагчдыг гүнээ хүндэтгэж” сургах, мөн тэдэнд удирдагчдыг өөрийн амьдралын үнэ цэнээр хамгаалахад бэлэн болгох юм.

1990-ээд оны эхэнд “удирдагчид хязгааргүй итгэх” дээр нэмж “хүүгийн хүндэтгэл үзүүлэх” гэсэн уриа гарч ирсэн. Албан ёсны ухуулгын заалт нь эдгээр зуун зуунаар гуйвашгүй Күнзийн үнэт сургаалыг дагахад чиглэсэн, учир нь үйлчилж буй дэглэм Солонгосын уламжлалт ёс заншилд тулгуурлан өөрийгөө хууль ёсны болгох шинэ үзэл санааг эрэлхийлсэн юм.

Энэхүү зорилгод хүрэхэд дээр дурдсан “хувьсгалт том гэр бүл”-ийн тухай ойлголтууд нь хот болон хөдөөгийн хүн амыг нэг зүйлд нэгтгэж байна. Хойт Солонгосын үзэл сурталчид СХН-ын “өндөр ёс суртахуунтай бодлого”-ын ачаар улсын бүх иргэд “нэг том найрсаг гэр бүлд аз жаргалтай амьдардаг”¹.

Ардын бүлгийн ахлагч өөрийн бүлгийнх нь гишүүдийн хүүхэд сурдаг сургуулиудтай байнгын холбоотой байх ёстой. Байнга оршин суух газраараа тэд бүгд бүлгэмд нэгддэг, бүлгэмийг хэрэв багш байдаг бол багш, үгүй бол бүлгийн өөр нэг гишүүн удирдана.

Ардын бүлэг нь төрөөс тогтоосон суурь шалгуураар зөвхөн авьяастай, нийгэмд дадсан хүмүүсийг олж илрүүлэх биш, харин бүр эхний шатанд дэглэмд тохирохгүй хүмүүсийг тодорхойлж, төрд мэдээлэн, нийгмийн шатаар дэвших боломжийг тэдэнд олгохгүй байх, нийгмийн тодорхой чиг үүргийг гүйцэтгэхгүй байлгахад тусалдаг.

Бүлгийн аж ахуй-зохион байгуулалтын ажлын хүрээнд бүлэг нь оршин байгаа газраар ариун цэвэр-эрүүл ахуйн үйл ажиллагааг эрхэлдэг. Ардын бүлэг өөрийн хүчээр, өөрийн зардлаар өөрийн амьдарч байгаа сууцаа болон хавсарга байр, шаг, орц, орох, гарах замд жижиг засварыг байнга хийх, эрүүл ахуйн шаардлагыг хангах үүрэгтэй. Бүлгийн хүчээр хашааны засвар, хүүхдийн тоглоомын талбай, нийтийн ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ, мод, бут суулгах ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

Энэ салбарт хяналтыг хэрэгжүүлэхэд хууль хамгаалах байгууллагыг татан оролцуулдаг. 1949 оны 2 дугаар сарын 15-нд сэргийлэхийн ажилтнуудын өмнө үг хэлэхдээ Ким Ир Сен тэднийг “ариун цэвэр, эрүүл ахуйн ажилд” санаа тавьдаггүй хүмүүстэй тэмцдэггүй гэж шүүмжилсэн. Эцсийн дүнд “оршин суугчид хувийн болон нийгмийн эрүүл ахуйг ухамсартайгаар дагаж, орон сууц, гудамжаа үлгэр жишээ цэвэрхэн байлгаж байгаад сэргийлэх хяналт тавих ёстой...”² гэдэг дүгнэлтийг хийсэн.

Хэвлэл, мэдээллийн албан ёсны хэрэгсэлийн батлаж байгаагаар

1 Үзэх: Өнөөдрийн Солонгос. Пхеньян, 1996. # 3. Х.27.

2 Үзэх: Ким Ир Сен., Собр соч Боть 5. Х.77.

байр сууц, орчны газрыг цэвэрлэхэд бүлгийн бүх гишүүд, тэр дундаа хариуцлагатай ажилтнууд, тэдгээрийн гэр бүлийн гишүүд оролцдог, Жишээ нь, СХН-ын хотын хорооны нарийн бичгийн дарга оролцдог. Орон сууцны хорооллын конторын үйл ажиллагааны тухай асуулттай Ким Чен Ирийн даалгаврыг тайлбарласан бүтээлд “ямар ч гэр бүл, хэн ч орон сууцны хорооллын өмнө тулгарсан хамтын ажиллагаанд оролцохгүй байх онцгой эрхгүй.”¹

Ардын бүлгийн ахлагч нь бүх хүмүүс “социалист маягийн амьдралд тохирсон” “энгийн, даруу, солонгос маягаар” хувцасласан байхад анхаарал тавьдаг. Энэ практик нь Ким Ир Сений 1970 онд өгсөн “ирж байгаа 2-3 жилд бүх эмэгтэйчүүдийг өвлийн пальто, эрчүүдийг хөвөнтэй пальтоогоор хангах” даалгаварт бүрэн тохирдог. Ийм халамжийн шалтгааныг тайлбарлахдаа БНАСАУ-ын удирдагч “энэ бол нэгэн зэрэг дайнд бэлтгэхтэй холбоотой асуудал. Хэрвээ бид ард түмнээ дулаан хувцаслачихвал дайнд ч айх зүйл байхгүй болно.”² гэжээ.

Бүлэг нь өөрийн гишүүдийг нийгэмд тустай хөдөлмөрөөр хангах үүрэгтэй. Бүлгийн дарга хороололоос ирсэн захиалгын дагуу олон тооны томоохон барилга барихад шаардагдлагатай тооны хүмүүсийг энэ ажилд хуваарилж ажиллуулдаг, эдгээр хүмүүс бүтэн хоногийн турш ажиллаж, хөдөө аж ахуйн ажил, хөдөө аж ахуйн жижиг тоног төхөөрөмж үйлдвэрлэх болон “олныг хамарсан хөдөлгөөн”-ий хүрээнд зохиогдох бусад ажилд оролцдог.

Ким Ир Сений даалгаврын дагуу “бүх ажилчид болон ажилтнууд тариачдад туслах, тосгонд жилд ядаж арван өдөр ажиллах үүрэгтэй.”³

1950-иад оны сүүлчээс орон сууцны хороолол бичиг хэрэг болон ардын бүлгийн үйл ажиллагааны чухал чиглэл нь гэрийн эзэгтэй нар болон бусад ажилгүй хүмүүсийг материаллаг үйлдвэрлэл, ахуйн үйлчилгээний үйл ажиллагаанд “хөршийн үйлдвэрлэлийн бригад” байгуулах замаар татан ажиллуулах болсон.

Ким Ир Сен 1958 оны 6 дугаар сард СХН-ын Төв хорооны хурал дээр “хөнгөн аж үйлдвэр, түүний дотор орон нутгийн аж үйлдвэрийг хурдан хөгжүүлэх, үүний зэрэгцээгээр төвд харьяалалтай хөнгөн аж үйлдвэрийг хөгжүүлэх” гэсэн зорилтыг дэвшүүлсэн. Энэхүү даалгаврын дагуу хот болон ажилчны тосгод, хоршоодын бригадад “өргөн хэрэглээний бараа, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг эрс өсгөх” арга хэмжээг авсан.

Их барилгын ажилд ажиллах хүчний дутагдлын асуудал хурцадсантай

1 Ан Чон Хун. Жагсаалтад дурдсан бүтээл. Х. 262.

2 Үзэх: Ким Ир Сен. Өгүүлэгийн түүвэр. Боть 25. Х.432, 434.

3 근로자 (Кыллочжа, Хөдөлмөрчин), 1991, #5. х. 57.

холбоотойгоор аж ахуйн асуудлыг тэргүүн ээлжинд тавих шийдвэрийн зэрэгцээгээр энэ кампанит ажил “хувьсгалч гэр бүл”, гол нь эмэгтэйчүүдийг “хувьсгалжуулах” хэд хэдэн үзэл суртлын болон улс төрийн зорилт тавьж байсан.

Ким Ир Сений санаагаар:

Эмэгтэйчүүдийн хувьд нь гэр бүлийн бүх гишүүдийн эзэгтэй гэдэг их агуу зүйл, хүүхдүүд эхийн нөлөөн дор байдаг, нөхөр ч бас тодорхой хэмжээнд эхнэрийн нөлөөнд байдаг. Хэрвээ өнгөрсөн үеийн үлдэгдэл толгойд нь байдаг бол гэртээ суучихаад, нэг бол хүнсний бүтээгдэхүүн хүрэлцэхгүй байгаа тухай, үгүй бол хувцас хунар муу байгаа тухай байнга гомдол гаргаж, түүний хүссэн бүхнийг худалдаж авч өгөхийг хүсэж нөхрөө залхаана. Ингэхлээр нөхөр нь эмэгтэйн хүслийг үнэхээр биелүүлэх гэж толгойгоо гашилгана. Яваандаа тэр ч бас худалдан авах дон тусч өвчилнө. Хувьсгалжаагүй, өнгөрсний үлдэгдлээс ангижраагүй эмэгтэй зөвхөн өөртөө биш бас нөхөр, хүүхэддээ ч хөнөөлтэйгээр нөлөөлнө....¹

Эмэгтэйчүүдийг “хувьсгалжуулах”-ын тулд хоногт 8, боломжгүй бол 6 цагаар тэднийг гэрийн үйлдвэрлэлд татан оролцуулах ёстой гэж БНАСАУ-ын удирдагч тооцсон. Гэрийн ажилтны бригадад оролцох нь сайн дурын хэрэг боловч БНАСАУ-д зарласнаар бүх эмэгтэйчүүд “агуу удирдагчийн алсын хараат санаа бодлыг” хэрэгжүүлэхийг тэмүүлэх, энэ уриаг эрч хүчтэйгээр дагах ёстой.

Төрөөс гэртээ оёдлын машинтай гэрийн ажилтны бригадад бөс даавуу болон тавилга олгоно. Бусад нь хиймэл цэцэг, шётка, эрдэнэ шиш, цагаан будааны ишээр нэхсэн эдлэл болон өдөр тутмын хэрэглээний жижиг зүйлсийг үйлдвэрлэнэ.

Энэ кампанит ажлын шинэ эрин үе 1984 онд Ким Чен Ир Пхеньяны Пхенчхоны районд орон нутгийн үйлдвэрлэл, гэрийн ажилтны бригадын бүтээгдэхүүний дэлгүүрээр орсны дараа эхэлсэн, энэ үйл явдлын дараагаас эдгээр бүтээгдэхүүнийг “8 сарын 3-ны бүтээгдэхүүн” гэж (Ким Чен Ирийн “орон нутагт даалгавар” өгсөн огноогоор) нэрлэсэн. улс орон даяар эдгээр бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх “нийтийг хамарсан хөдөлгөөн” өрнөсөн.

Жишээ нь, Өмнөд Пхеньяны Хванчу тосгоны гэрийн эзэгтэй нарын хөршийн үйлдвэрлэлийн хоршоо эхнэрүүд болон зарим тэжээгдэгчдийг оролцуулан өргөн хэрэглээний 300-гаас илүү төрлийн барааг үйлдвэрлэж, эдгээр бараагаар хошууны хүн амын хэрэгцээг бүрэн хангаж, улмаар бусад

1 Ким Ир Сен. Өгүүллэгийн түүвэр. Боть 26. Х.379-380.

район болон Ази, Европ, Америкийн 10 гаруй оронд экспортлосон¹.

СХН-ын Төв хорооны 6 дахь удаагийн 16 дугаар бүгд хурлын шийдвэрийн дагуу “хот, тосгосод гэрийн эзэгтэй нар, туслагчид, гэр бүлийн ажил эрхлээгүй гишүүд, өндөр настнууд, эрүүл мэндийн шалтгаанаар ажил эрхэлдэггүй бусад этгээдийн олон хэлбэрээр, бодит нөхцөлд тохирсон бригад зохион байгуулж, ажиллуулах” “Хөнгөн аж үйлдвэрийн хувьсгал” хөтөлбөрийг дэвшүүлсэн, үүний зорилго нь “ахуйн үйлчилгэний хөршийн ажилтнуудын үүргийг илүү дээшлүүлэх”, ингэснээр “8 сарын 3-ны бараа”-ны үйлдвэрлэлийг эрс өсгөх” явдал байсан.²

Хотын төв районы оршин суугчид хоосон шил, гялгар уут болон бусад юмханаар юм хийх түүхий эдийг цуглуулан, тушаах үүрэгтэй.

Хотын захын хүн ам болон хөдөөгийн хүн ам намын ажилтнуудыг оролцуулаад жилийн туршид хоёр гахай, 5 тахиа өсгөж улсад тушаах, тэдгээрээс үүссэн өтөг хороог тосгон руу органик бордоо болгож өгөх үүрэгтэй.

1981 онд хүн ам болон ардын бүлгийн үйл ажиллагааны шинэ чиглэлээр амьтан үржүүлгийг хамтаар эрхлэх (урьдын адил олон нийтээр) болно гэдгийг зарласан. Үүнтэй холбоотой өөрийн туслах аж ахуй эрхлэх нь энэ төрлийн иргэдэд албан шинжтэй болсон.

Хотын районууд, хошууд эх сурвалжид тэмдэглэснээр заавал биш шинжтэй боловч мал, гэрийн тэжээмэл шувуудыг өсгөх талаар дээд байгууллагаас төлөвлөгөөт даалгавар хүлээн авдаг. Орон сууцны хорооллын конторын ажилчид, ардын бүлгийн ахлагчийн хамт өөрийн харьяа оршин суугчдын энэ талаарх боломжийг судалсны үндсэн дээр хувийн өмчид үр төлийг нь худалдан авах тухай мэдүүлэг өгдөг бөгөөд үүний дагуу төрөөс буюу хөрш зэргэлдээ тосгодоос хувийн өмчид худалдан авдаг.

Айл бүр өөрийн туслах аж ахуйдаа гахай өсгөж, түүнийгээ өөрөө хэрэглэх буюу улсад худалдах эрхтэй.

Тухайн чиглэлээр амжилтад хүрсэн хүмүүсийг сурталчлан, хэвлэлд гахайн байр барих материалыг тэд өөрсдөө эрж олсон, өөрийн хүчээр барьж байгуулсан, амьтны тэжээлийг өөрсдөө гэрийн орчимд тарьж ургуулсан, аж ахуй дээрээ амралтгүй ажилласан гэх мэтээр бичдэг. “... ямар нэг материаллаг баазгүйгээр, нүцгэн гараараа гахай үржүүлэх ажлыг эхэлсэн, ингээд ийм хэмжээний мах үйлдвэрлэсэн нь энэхүү хөдөлгөөнийг өрнүүлсэн манай намын бодлого зөв болохыг гэрчилж байна.” гэж албан ёсны сурталчилгаа үздэг байсан³.

1 근로자 (Кылложка, Хөдөлмөрчин) 1991, #5, х. 59.

2 Мөн тэнд бий

3 평양신문 (Пхеньян синмун, Пхеньяны сонин), 1983.09.04.

“Арми-тэргүүн ээлжинд” бодлогыг хэрэгжүүлж эхэлснээр Ардын бүлгийн гишүүд дунд ийм маягаар гахай үржүүлэх кампанит ажлыг өрнүүлж цэргийн анги, эсхүл цэргийн анги нэгтгэлийн дэргэд байгуулсан туслах аж ахуйд гахай үржүүлсэн¹.

Бүлэгт нүүрс, цахилгаан, усыг хэмнэлттэй хэрэглэх, гэрийн аж ахуйг зохистой эрхлэх талаар байнга тэмцэл өрнөдөг. Энэ ажлыг хүмүүжүүлэх болон захиргааны аргаар хэрэгжүүлнэ. Хүмүүжүүлэх аргад үлгэр жишээ гэр бүлийн туршлагыг түгээх, тухайн үүрэгтээ сайн хандаагүй хүмүүсийг шүүмжлэх тусгай хурлыг хамруулж болно.

Ардын бүлгийн ахлагч тухайлбал, орой цахилгаан таслах цагийг зарлах, дурын цагт аль ч байранд орох (жишээ нь, орой хүртэл гэрлээ унтраагаагүй, эсхүл крантнаас нь ус удаан хугацаагаар дусалсан гэх мэт), түүнчлэн эдгээр эх үүсвэрийг цаашид дулаан шаардлагатай улиралд зориулан тэгшээр хуваарилахыг шаардах эрхтэй.

Үүнээс гадна, ардын бүлгийн ахлагч айл бүр хэрэглэх түлш (мод, нүүрс, хүлэрт) болон урт хугацааны (намраас хавар хүртлэх хугацаанд хэрэглэх кимчи гэх мэт) туршид хүнсний зүйлийн тогтоосон хэмжээний нөөцтэй байгаа эсэхийг ажиглах, түлшээ ирээдүйн дулаалгын хугацаа хүртэл жигдээр ашиглахыг шаардах эрхтэй.

Ардын бүлгийн энэ чиг үүрэг Ким Ир Сений шууд зааварчлагаар хийгдсэн гэж болно. 1970 онд ардын хороодын ажилтнуудын хурал дээр Ким Ир Сен “хотын оршин суугчдын дунд хүмүүжлийн ажлыг өргөнөөр зохион байгуулж, айл бүр хэмнэх хөдөлгөөнд оролцож, хоолоо хийхдээ бүтээгдэхүүнийг бага боловч хэмнэх, ингэснээр нэг, хоёр сарын нөөцтэй болох. Гэнэтийн нөхцөл үүссэн тохиолдолд бүтээгдэхүүнийг нэг, хоёр сарын хугацаагаар өгөхгүй байж болно.”² гэж хэлжээ.

Угаас хангалтгүй хүнсний нөөцийн жагсаалт дахь хэмжээг байнга хасч байдаг учраас ийм нөөц хуримтлуулах нь тийм ч амархан биш юм. 1973 онд өдөр тутмын нормыг (цагаан будаанд шилжүүлэн тооцсоноор-700 гр) байсныг батлан хамгаалах нөөц хуримтлуулах гэдэг нэрийн дор 10%-иар бууруулсан байсан. 1987 онд Пхеньянд 1989 онд зохион байгуулах дэлхийн залуучууд, оюутнуудын XIII Их наадамд бэлтгэх хөрөнгө хуримтлуулах зорилгоор дахин хүнсний нормыг хассан байсан.

Ийм маягаар БНАСАУ-ын хүн ам “хөршийн бүлэг” механизмын тусламжтайгаар өнөөгийн арван жилийн эхэнд оршин суугаа газрын кампанит ажил болон бусад нийгмийн хөдөлгөөнд оролцох замаар эдийн засгийн янз бүрийн салбарт тусалсан. Тэдгээрээс хамгийн олон хүнийг хамарсан нь армид туслах, хөдөө аж ахуй, нийтийн аж ахуй, барилга, төмөр

1 로동 산문 (Нодон синмун, Ажилчны сонин), 2001.02.02.

2 Дам эшлэл: Ким Ир Сен. Өгүүлэлийн түүвэр, Боть. 25. Х.429.

зам, уурхайд туслах хөдөлгөөн байсан. Үүнээс гадна тэд орон нутгагт цэцэг тарих, “8 сарын 3”-ны бараа үйлдвэрлэх, “хувьсгалын алдар”-ын орчныг арчлах, цахилгаан эрчим хүч, нүүрс хэмнэх, өтөг бууц бэлтгэх ажлыг гүйцэтгэж байсан.¹

Ардын бүлгийн үүрэг нь нийгэм, эдийн засгийн хяналтын механизмын хувьд, хараажаар БНАСАУ-д 1990-ээд оны эхэнд эхэлж, улмаар байнгын шинжтэй болсон эдийн засгийн хүндрэл хурцадсан нөхцөлд өсөн нэмэгддэг.

Түгээмэл жишээ нь, БНАСАУ-ын Нийгмийн аюулгүй байдлын яам “Цахилгаан, дулааны эрчим хүчийг хууль бусаар ашигласан этгээдийг хатуу шийтгэх тухай” 1993 оны 1 дүгээр сарын 26-ны мэдэгдлийг Пхеньянд нийтийн үйлчилгээний газруудаар өлгөсөн. Түүнд “хувь хүний хувиа хичээхийн илрэл”, олон байгууллага, аж ахуйн нэгж, зарим иргэн “төрөөс зөвшөөрөл авалгүй хууль бусаар цахилгаан болон дулааныг хэрэглэдэг” “ноцтой гэмт хэргийн” фактуудыг бичсэн байсан.

“Хувьсгалч сахилга бат болон дэг журам” тогтоох, янз бүрийн хэрэг явдлаас (гал түймэр гэх мэт) урьдчилан сэргийлэх нь орон сууцны хорооллын контор болон ардын бүлгийн гол чухал үүргийн нэг байдаг.

Хүн амын амьдралын бүх талыг хянах аюулгүй байдлын албаны хяналтыг бүр Солонгосын дайны эхэнд 1950-1953 онд өмнөд Солонгосын тагнуул, хорлон сүйтгэгчидтэй тэмцэх уриан дор Ким Ир Сен санкцжуулсан. БНАСАУ-ын удирдагч 1949 онд аюулгүй байдлын ажилтнуудын өмнө үг хэлэхдээ тэднээс “хүн амтай нягт холбоо тогтоох”, даалгасан нутаг дэвсгэр дээр нөхцөл байдлыг бүрэн гартаа авах, “хэн хэдэн халбага сэрээтэйг ч мэдэх”-ийг шаардсан².

Төр засгийн зүгээс нотолж байгаагаар ардын бүлэгт “нэвтрэхээр бүх талын арга сүвэгчилж байгаа “тагнуул”, “хорлон сүйтгэгчид”, “бохир” элементийн эсрэг тэмцэх нь Хувьсгалын дэг журмыг хадгалах гол чухал элемент мөн. Орон сууцны контор нь инминбаны бүх гишүүн “хувьсгалын сэрэмжтэй байдлаа” байнга дээшлүүлж байх, тэднийг дайсны тэмцлийн арга, тэдэнтэй тэмцэх тэмцлийн арга, энэ тэмцэлд “бүх нийт”-ээр оролцох нөхцөл бүрдүүлэх үүрэгтэй байсан³.

БНАСАУ-д “ангийн дайсны эсрэг диктатурыг хэрэгжүүлэхэд учрах зарчмын асуудлын нэг нь тэдгээрийн эсрэг нийтийн хөдөлгөөнийг өрнүүлэх явдал мөн. Энэ тэмцэл бол социалист нийгмийн бүх гишүүний ариун, хүндэт үүрэг мөн”.⁴

1 Үзэх: 로동신문 (Нодон синмун, Ажилчны сонин) 2001, 01.04, 2001.02.27, 2001.02.21, 민주 조 선 (Минчжу чосон, Ардчилсан Солонгос), 2001.04.04, 2001.05.22.

2 Үзэх: Ким Ир Сен. Өгүүллэгийн түүвэр. Боть 5. Х.75-76.

3 Ан Чон Хун. Цагсаалтад дурдсан бүтээл. Х.273.

4 Ли Ге Себ. Сахвечужуй минчжучуый (Социалист ардчилал). Пхеньян. 1987. Х.150.

Хувьсгалт журмыг хадгалах нэг чухал элемент нь бүлгийн байнгын оршин суугчдыг бүртгэх, тэдгээрийг гадагш явсан, бүр гэртээ хоносныг ч тооцох, ирж очсон хүмүүсийг бүртгэх юм.”¹

Ардын бүлгийн гишүүд тухайн нутаг дэвсгэрт сэжигтэй буюу ердөө танихгүй хүн ирснийг ч инминбаны удирдлагад мэдээлэх нь тэдний хувьд хамгийн үр дүнтэй арга бөгөөд төрөл төрөгсөд, зочныг хүлээн авч байгаа хүний тухайд нөлөө бүхий урамшуулал юм.

Ийм “аюулгүй байдлын арга хэмжээ”-г Пхеньянд “Улс орны хагарал болон АНУ-ын болон Өмнөд Солонгос дахь тэдний утсан хүүхэлдэйнүүдийн дайсагнагч явуулгаас үүдсэн” гэж нотолдог.

Бүлэг нь иргэдийг оролцуулан хийх иргэний хамгаалалтын сургалт болон бусад батлан хамгаалах арга хэмжээг зохион байгуулах анхан шатны нэгж мөн.

Бүлгийн гишүүд соёлын арга хэмжээнд, ялангуяа гадаадынхантай харьцах боломжтой, жишээ нь, олон улсын хөдөлмөрчдийн эв нэгдийг тэмдэглэх зэрэгт оролцдог. 1970-80-аад онд Пхеньянд гадаа зохиогдсон ийм арга хэмжээн дээр БНАСАУ-д байгаа дипломат корпусынхан бусад гадаадын иргэдийг урин оролцуулсан.

Бүлгийн гишүүд “хамтран амьдрах социалист хэм хэмжээ”-г зөрчсөн үйлдлийг инминбаны хурал дээр хэлэлцэж, хууль зөрчсөн үйлдэл байвал орон сууцны конторт мэдэгддэг. Эдгээрээс хамгийн их түгээмэл гардаг нь хулгай юм.

Жижиг зөрчлийг орон сууцны хорооллын контор буюу Ардын аюулгүй байдлын яамны районы тасаг дээр хэлэлцэх бөгөөд гэм буруутай этгээдийг захиргааны журмаар зургаан сарын хугацаатайгаар дахин хүмүүжүүлэх тухайлбал, барилга дээр ажиллуулахаар тухайн районд буцаадаг. Илүү ноцтой зөрчлийн тухайд нийслэлээс хөөн гаргана.

Хөдөөд байнга амьдруулахаар шилжүүлэн суулгах практикийг засгаас том хотуудын хүн амын тоог зохицуулах зорилгоор байн байн хийдэг. Шилжин суугчдыг үдэх баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулах бөгөөд хэвлэл мэдээллийн хэрэгслийнхний мэдээлснээр тухайн өдөр нь шилжин суугчид хөдөөд тэдэнд зориулж бэлтгэсэн шинэ байшинд очдог².

БНАСАУ-ын удирдагчид ардын бүлгийг дараах зүйлд ашигладаг:

- Сургуулийн сурагчаас тэтгэврийн хөгшид хүртэл бүх оршин суугчдын хувийн амьдралыг байнга, бүх талаар хянах;
- Чучхе-албан ёсны үзэл санааны зарчмаар бүх хүн амыг хүмүүжил, үзэл суртлын ажилд хамруулах;

1 Ан Чон Хун. Жагсаалтад дурдсан бүтээл. Х. 273.

2 로동신문 (Нодон синмун, Ажилчны сонин), 2000.10.27.

- Дотоод, гадаад бодлогын асуудлаар өөрийн бодлого, тодорхой шийдвэрийг хүн амд шуурхай хүргэх;
- Батлан хамгаалах, нийгэм-Улс төрийн арга хэмжээнд дурын шаардлагатай хүмүүсийг татан оролцуулах;
- Аж ахуйн бодлогыг эдийн засгийн бус албадлагын аргаар хэрэгжүүлэх.

Иймэрхүү практик нь Ким Ир Сений улс орны “бүх ажил, ахуйг зохицуулах ёстой” гэсэн чиглэлд бүрэн тохирдог¹.

Бүлгийн жишээ нь, “таван гэр бүлийг хариуцдаг” үйл ажиллагааны аливаа чиглэл орчин үед хир оновчтой үйлчилдэг, ер нь үйлчилдэг эсэхэд зарим мэргэжилтнүүд эргэлздэг.

Намын болон хойд Солонгосын хэвлэлийн материал өнөөдөр эдгээр бүлгийн үйл ажиллагаа улс орны дээд удирдагын хараа хяналтад байсаар байгаа бөгөөд хамгийн онцлог үйл ажиллагааг “өндрөөр үнэлж”, талархсаар байдаг².

Ардын бүлгийг илүү алдаршсан улс төрийн болон засгийн бүтэц-намын аппарат, аюулгүй байдлын байгууллага, армийн хамт ашигласнаар БНАСАУ-ын төрийн дэглэмийг урт хугацаанд буюу шинэ түүхэнд байгаагүй урт хугацаагаар хадгалах боломжийг өгсөн.

Ардын бүлэг нь бүх нийтийн тэгш байдал, нэгдмэл сэтгэлгээний хэм хэмжээнээс хазайсан бүх гажилтыг илрүүлдэгээрээ хойд Солонгосын тогтолцооны тогтвортой байдлыг хангах чухал хөшүүрэг болж хувирсан.

Ардын бүлгийн үйл ажиллагааны онцлогийг судлах нь БНАСАУ-ын нутгийн удирдлага, нутгийн өөрийн удирдлагын механизмын талаар тодорхой төсөөлөл авахад тусална.

Зарим уламжлалт нийгмийн институтыг шинэ нөхцөлд илүү амархан тохируулж болох байсан байх. Нэгдүгээрт, тэдгээрийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн болон олон нийтийн ухамсарын түвшинд тохирсон, тусгай, харьцангуй идэвхтэй функциональ шинжийн ачаар, хоёрдугаарт, нийгмийн хөгжил нэгэн хэмнэлээр бус явагдаж байгаа, заримдаа урьдчилж харах боломжгүй чанарын өөр байдалд шилжих хөгжлийн явцад шинэ улс төрийн элитүүдээс хүлээж болох нийгмийн тогтвортой байдалтай холбоотойгоор. Үйл явдлын ийм өрнөлт ялангуяа, Солонгосын хувьд маш их байх магадлалтай байсан. Тухайлбал, солонгосын хойгийн өмнөд хэсэгт одоо хүртэл орон нутгийн хүн амын хэлбэрийн хувьд болон зарим талаар агуулгын хувьд ч инминбантай харьцуулж болохоор засаг захиргаа, нутаг дэвсгэрийн байгууллага хадгалагдсаар байгаа.

1 Үзэх: Ким Ир Сен. Өгүүллэгийн түүвэр Боть 10. Х.438.

2 로동신문 (Нодон синмун, Ажилчны сонин) 1999.02.04, 2001.01.23.

Ардын бүлгүүд юуны өмнө БНАСАУ-ын одоогийн улс төрийн дэглэмийг хадгалах ашиг сонирхлын үүднээс авч нэтрүүлсэн орон нутгийн хүн амын өөрөө зохион байгуулагдах уламжлалт хэлбэрийн тодорхой илрэлийн нэг бөгөөд нийгмийн хөгжлийн зам дээр байгаа чухал саад тогтор мөн¹.

Үүний зэрэгцээгээр эдгээр нь хот, хөдөөгийн зарим бүлэг хүн амд (хөгжлийн бэрхшээлтэй, ганц бие, хөгшин настай)-д тэдгээрийн өдөр тутмын амьдралд үйлдвэрлэлийн бус хүрээнд тулгарч байгаа бэрхшээлд “амортизац хийх/багасгах/” боломж олгодог².

Үүнээс гадна ирээдүйд бий болж болох улс төрийн эрс өөрчлөлт, нийгмийн хурдацтай өөрчлөлтийн дүнд болох нийгмийн эмх замбараагүй байдалд эдгээр нь тогтворжуулагчийн үүрэг гүйцэтгэж болно.

7.2. Бүгд Найрамдах Солонгос Улс

대한민국

Тэ Хан Мин Гук

БНСУ-ын түүх бол БНАСАУ-ын түүхтэй адил 1945 оны зуны сүүлчээр хойгийг өөрсдийн нөлөөллийн хүрээнд хуваах тухай зөвлөлт-америкийн хэлэлцээрээс эхлэлтэй. Энэ гэрээгээр 38 дугаар өргөргөөс урагших хойгийн хэсэг АНУ-ын харьяалалд, харин хойт хэсэг нь Зөвлөлт Холбоот Улсын харьяалалд үлдсэн.

1945 оны 8 дугаар сард Солонгосын хойгийг Зөвлөлтийн цэрэг чөлөөлсний дараа өмнөд хэсэгт шууд эхэлсэн ардчилсан өөрчлөлт Өмнөд Солонгосыг америкийн цэргүүд 1945 оны 9 сард эзэлснээс шалтгаалж тасалдсан³.

1948 оны 5 дугаар сарын 10-нд хойгийн өмнөд хэсэгт гарсан олон улсын гэрээг зөрчиж, салан тусгаарлах Үндсэн хуулийн хурлын сонгуулийг хийсэн, үүнээс 1948 оны 7 дугаар сарын 12-нд Үндсэн хуулийг баталсан.

Солонгос Улс дахь нутгийн өөрийн удирдлага нь оросын орон нутгийн эрх зүйд хамгийн их судлагдсан нь байдаг.

БНСУ-ын түүхэнд ардчилсан болон авторитар (дангаар ноёрхох) удирдлагын үеүүд ээлжлэн байсан. Иргэний Засгийн газрыг тухайн улсад уламжлал ёсоор Нэгдүгээр Бүгд Найрамдах Улсаас одоогийнхыг хүртэл Зургадугаар Бүгд Найрамдах Улс гэж дугаарладаг. Ийм дугаарлалтын үндэс нь Үндсэн хуульд орсон томоохон өөрчлөлтүүд байдаг. Гэхдээ Үндсэн хуульд үнэн хэрэгтээ 8 өөрчлөлт орсон. Анхны Бүгд Найрамдах Улсыг Ли

1 Үзэх: Жебин А.З. Жагсаалтад дурдсан бүтээл. х. 87.

2 Өнөөдрийн Солонгос. Пхеньян. 2000. #11. Х. 22-23.

3 Үзэх: Конституция государств Азии: В 3х т (Под.ред. Хабриевой Т.Я. с.978.)

Сын Ман¹тэргүүлж байсан, энэ улс эхлээд барууны ардчилсан зарчим дээр үндэслэсэн байснаа, маш хурдан дангаар ноёхох дэглэмд шилжсэн бөгөөд 1960 онд нийтийг хамарсан эмх замбараагүй байдлаар төгсгөл болсон.

Хоёр дугаар Бүгд Найрамдах Улс ардчилсан зарчим дээр үндэслэгдсэн боловч Ерөнхийлөгч Юн Бо Соном, Ерөнхий сайд Чан Мён нараар удирдуулсан Засгийн газар нь авилгад автагдаж, ажлаа хийж чадаагүй бөгөөд 8 сарын дараа түүнийг түлхэн унагасан. 1961 онд Пак Чон Хигийн толгойлсон “Үндэсний Шинэчлэлийн Дээд Зөвлөл” нэртэй цэргийн Засгийн газар гарч ирсэн².

1 Ли Сын Ман, (сол. 박정희, 1875-1965). Өмнөд Солонгосын анхны Ерөнхийлөгч. Хванхэдо тосгонд сурвалжит гэр бүлд төрсөн. Солонгост өрнөсөн японы эсрэг хөдөлгөөний идэвхтэн байсан. 1897 онд Японы хаант Улсыг эсэргүүцсэн жагсаалд оролцсоны төлөө баривчлагдсан. 1904 онд АНУ руу явж, Жорж Вашингтоны, Харвард, Принстоны Их Сургуулиудад суралцсан. 1910 онд Солонгост буцаж ирсэн. 1919-1925 онд Шанхай дахь Солонгосын Түр Засгийн газрын Ерөнхийлөгч байсан. 1925 онд Түр Засгийн газраас өөрийг нь тухайн албан тушаалыг урвуулан ашигласан гэсэн импичментийн дараа өөрийн албан тушаалыг орхисон. 1945 онд хойгийн өмнөд хэсгийн удирдагч, 1948 оноос Бүгд Найрамдах Солонгос Улсын Ерөнхийлөгч болсон. 1960 онд олон нийтийг хамарсан үймээн, сонгуулийн үр дүнг гуйвуулсан гэдэг шалтгаанаар жагсагчдыг (4 сарын хувьсгал) буудсан (130 гаруй хүн үхсэн). Жагсагчид хотыг эзэлсний дараа Ли Сын Ман огцорч, АНУ-руу зугтахаас өөр аргагүй болсон. Хавайн Хонолулуд насан эцэслэсэн.

2 Пак Чон Хи (1917-1979) - БНСУ-ын цэргийн болон төрийн зүтгэлтэн, 1963-1979 онд улсын Ерөнхийлөгч байсан. Солонгост төрсөн, дэлхийн хоёрдугаар дайны үед Японы талд байлдаж байсан. Маньжчу-Го армийн явган цэргийн 8 дугаар дивизд Такаки Масао гэдэг япон нэртэйгээр байлдсан. Дайны дараа Пак коммунист үүрт элссэн бөгөөд баривчлагдаж алах ял заагдсан боловч үүрийн бусад бүх гишүүнийг барьж өгсөн гэдэг шалтгаанаар армиас чөлөөлөгдсөн. 1950-1953 оны Солонгосын дайны үед цэрэгт буцаж орсон, цэргийн эрдмээр онцгойрч, АНУ-д жилийн хугацаатай тусгай бэлтгэл хийж ложистикийн мэргэжилтэн болсон. Солонгосын дайны үед нэгдүгээр генералын цол хүртсэн. Ерөнхийлөгчийн албанд байхдаа Япон Улсыг стратегийн гол түншээ гэж үзэж, японы хөрөнгө оруулалтад үүд хаалгыг нээж өгсөн нь хүн амын зүгээс олон нийтийн эсэргүүцэлтэй тулгарсан. 1965-1973 онд Вьетнамын дайны үед Пак Чон Хи АНУ-д маш том тусалцаа үзүүлсэн. Вьетнамд 300 000 бие хүний бие бүрэлдэхүүнийг аваачсан нь америкчуудын дараа орсон гадаадын хамгийн том бүрэлдэхүүн байсан. Өмнөд Солонгосын цэргүүд дайнд маш сайн оролцсон, гэхдээ энгийн иргэдтэй хэтэрхий харгис харилцаагаасаа болж вьетнамчуудын дунд туйлын муу нэр хүндтэй болсон. 1971 онд гуравдахь удаагаа давтан сонгогдоод Пак Чон Хи “олон улсад бий болсон аюултай нөхцөл байдалтай холбоотойгоор” улс оронд онцгой байдал тогтоохоо зарласан. 1972 оны 10 сард Пак Чон Хи парламентыг тарааж, Үндсэн хуулийн үйлчлэлийг зогсоосон, харин 1972 оны 12 сард бүн нийтийн санал асуулгаар шинэ Үндсэн хууль Юсин (сэргэн засварласан) -ыг баталсан. 1972-1979 он Дөрөвдүгээр Бүгд Найрамдах Улс гэдэг нэрийг авсан. Үндсэн хууль нь Ерөнхийлөгчийн эрх мэдлийг ихээхэн өргөтгөж, үнэн хэрэгтээ түүний дарангуйллыг баталгаажуулсан, сонгуулийг сонгогчдын хамт олон хийх болсон, бүрэн эрхийн хугацааг 6 жил болгосон, дахин сонгогдож болох тооны хязгаарлалтыг үгүй болгосон. 1972-1978 оны Ерөнхийлөгчийн сонгуульд ганцаар нэр дэвшиж дахин ялалт байгуулсан. 1979 оны 10 сарын 26-нд Сеулд эхэлсэн ээлжит эмх замбараагүй байдлын дараа Пак Чон Хи Төв тагнуулын байгууллагын дарга Ким Дэ Кю буудаж хороогоод, сүүлд нь өөрөө дүүжлүүлсэн. Өөрийн эдийн засгийн шинэчлэлээр эдийн засгийн өрсөлдөгч

Пак Чон Хиг гурав болон дөрөвдүгээр Бүгд Найрамдах Улсын үед олон дахин албан ёсоор Ерөнхийлөгчөөр сонгосон.

Тавдугаар Бүгд Найрамдах Улсыг баруунд албан ёсоор ардчилсанд тооцдог боловч энэ нь цэргийн удирдлагын үргэлжлэл байсан. Тавдугаар Бүгд Найрамдах Улсыг Пак Чон Хигийн цэргийн хамтрагч асан Чон Ду Хван¹ толгойлж байсан. Энэ албан тушаалд эсэргүүцийн үйлдлийн дараагаар Ро Дэ У² гарч ирсэн бөгөөд түүнийг энэ эрх мэдэлд ирсэнээр Зургадугаар Бүгд Найрамдах Улсыг тунхагласан.

Түүнийг Ерөнхийлөгч болсны дараа удирдлагын ардчилсан зарчим эргэж ирсэн гэж тооцдог.

БНСУ-ын одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Үндсэн хуулийг 1987 онд бүх нийтийн санал асуулгаар баталсан.

Одоо Өмнөд Солонгосын төрийн тэргүүн нь Ерөнхийлөгч гэж тооцдог. Одоогийн Ерөнхийлөгч нь -Ли Мён Бак³.

Хууль тогтоох үндсэн байгууллага нь нэг танхимтай, 299 депутатаас бүрддэг Үндэсний хурал.

Үндэсний хурлын ихэнх хэсэг болох 245 гишүүн нь нэг мандаттай тойргоос, мажоритар тогтолцоогоор, 54 депутат нь - саналын 5%-ийн босгын хязгаартай улсын хэмжээний намын жагсаалтаар сонгогддог. Депутатын бүрэн эрхийн хугацаа нь дөрвөн жил.

Парламентын сонгуулийг 1948 оноос ёс төдий хийж эхэлсэн. 1988 онд

болох Хойт Солонгосыг гүйцэж түрүүлсэн гэдгээрээ алдартай, “солонгосын эдийн засгийн гайхамшиг” болон улс төрийн залхаан цээрлүүлэлтийг ч нэгэн адил бүтээгч гэж үздэг.

1 Чон Ду Хван (сол. 전두환, 1931 онд төрсөн) - солонгосын цэргийн офицер асан, 1980-1988 онд БНСУ-ын Ерөнхийлөгч байсан. Солонгост төрсөн, Солонгос болон АНУ-д цэргийн академийг дүүргэсэн. Вьетнамын дайнд хороодын нэгнийг удирдан оролцсон. 1980 онд Кванжуд бослогыг дарахад орлцсон, энэ үеэр 2000 орчим хүн амиа алдсан. Ерөнхийлөгчийн албан тушаалд 1980 оны 8 сард очсон, 1981 оны 2 сард албан ёсоор шинэ Ерөнхийлөгчөөр сонгогдсон. Хүчтэй төвлөрсөн удирдлагыг тунхаглаж, Пак Чон Хигийн эхлүүлсэн эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлсэн. 1987 оны олон нийтийн эсэргүүцлийн хөдөлгөөний дараа чөлөөнд гарсан. 1988 онд Кванжуд гарсан бослогын үеэр авлига авсан хэргээр цаазын ял заагдсан боловч хожим нь өршөөгдсөн.

2 Ро Дэ У (сол. 노태우, 1941 онд төрсөн) Солонгосын Ерөнхийлөгч асан, генерал, улс төрч, Өмнөд Солонгосын 6 дахь Ерөнхийлөгч (1988-1993), Чон Ду Хваны залгамжлагч, 1987 онд анхны олон мандаттай сонгуульд ялсан. 1993 онд авилгын хэрэгт буруутгагдаж баривчлагдсан, хойно нь Кванжуд болсон бослогын үед урвасан гэсэн ял тулгасан. 1996 онд 22 жил хорих ялаар шийтгүүлж, 1998 онд Ерөнхийлөгч Ким Дэ Чун өршөөл үзүүлсэн.

3 Ли Мён Бак (сол. 이명박, 1941 онд төрсөн), 2008 оны 2 сараас БНСУ-ын Ерөнхийлөгч. Японд төрсөн, япон нэр нь -Ли Цукяма Ахикиро. Энгийн биш хувь заяатай хүн. Манаачаас компанийн (“Хёнде констракшн” кор. (“현대건설” Англи “Hyundai Construction”) захирлуудын зөвлөлийн даргын албыг хашч, компаниа дэлхийн томоохон корпорацийн нэг болгож чадсан. 2002 онд Сеул хотын даргын сонгуульд тэр үедээ эрх барьж байсан намын төлөөлөгчийг ялсан. 2007 онд Ерөнхийлөгчөөр сонгогдсон.

анхны чөлөөт сонгуулийг зохион байгуулсан.

Хүчин төгөлдөр дагаж мөрдөж байгаа Үндсэн хуулийн 8 дугаар бүлэг нутгийн өөрөө удирдах байгууллагын статус, эрх зүйн байдлыг тогтоосон.

БНСУ-ын Үндсэн хуулийн 117 дугаар зүйл нутгийн өөрийн удирдлагын эрхлэх асуудлыг тодорхойлсон, үүнд, орон нутгийн хүн амын нийгмийн хангамж, өмчийн удирдлага болон хуулиар тогтоосон хэмжээнд нутгийн удирдлагын асуудлаар чиглэл өгөх зэрэг хамаарна.

Үндсэн хуульд заасан зайлшгүй байх шаардлагатай (de jure) нутгийн өөрийн удирдлагын цорын ганц байгууллага бол -нутгийн зөвлөл юм.

Нутгийн засгийн байгууллагын төрөл, бүтэц, нутгийн зөвлөлийн бүрэн эрх, түүний гишүүдийг сонгох журам болон нутгийн засгийг бий болгохтой холбоотой бусад асуудлыг хуульд заасны дагуу тодорхойлдог.

Нутгийн нийтийн засгийн байгууллагын тогтолцоонд нутгийн зөвлөл, дээд шатны захиргаа - төвлөрсөн харьяалал бүхий хот, суурин, *доод шат*-засаг захиргааны нэгжийн үүнтэй төстэй төвлөрсөн харьяалал бүхий хот, сууринг бүрдүүлдэг нэгж ордог.

Нутгийн өөрийн удирдлагын байгууллагууд өөрсдийн үйл ажиллагааг “*Нутгийн өөрийн удирдлагын тухай*” 1949 оны хуулийн дагуу явуулдаг. Гэхдээ нутгийн өөрийн удирдлагын бодит тогтолцоо нь зөвхөн 1988 оны хавар батлагдсан Нутгийн өөрийн удирдлагын тухай хуульд оруулсан өөрчлөлтийн дараа тогтвортойгоор үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

Ийм нөхцөл байдлаар Солонгос Улс түүхийн хувьд төрийн төвлөрлийн онцгой хүчтэй түвшин бүхий улс байсан, орон нутаг дахь бүх ажилтныг зөвхөн төвөөс томилдог байснаар тайлбарлаж болно. Энэхүү тогтолцоог өөрчлөх нь маш хэцүү байсан.

Нутгийн өөрийн удирдлагын тухай хуулийн дагуу засаг захиргааны байгууллага бүрийн дэргэд нутгийн депутатуудын зөвлөлийг байгуулах ёстой байсан. Анхны зургаан нутгийн зөвлөлийг өмнө талын зургаан сууринд дөнгөж 1952 онд, Солонгосын дайны үед байгуулсан. Сеул, онцгой статустай хотод болон Кенгидо, Канвондо сууринуудад нутгийн зөвлөлийг анх 1956 онд байгуулсан.

“Нутгийн өөрийн удирдлагын тухай” 1949 оны хуульд, эсхүл шууд сонгууль, эсхүл захиргааны тэргүүнийг төвөөс сонгох гэх мэт нэг бус удаа өөрчлөлт орсон. Хоёрдугаар гэгч Бүгд Найрамдах Улсын үед нутгийн өөрийн удирдлагад иж бүрэн бүрэн эрх олгосон өөрчлөлтийг хийсэн боловч хоёрдугаар Бүгд Найрамдах Улсын уналттай холбоотойгоор энэ заалт хэрэгжээгүй.

Гуравдугаар Бүгд Найрамдах Улсын үед нутгийн удирдлагын чиг үүргийг холбогдох суурины Захирагч (губернатор)-ид болон Дотоод хэргийн яаманд шилжүүлсэн.

Тавдугаар Бүгд Найрамдах Улсын Үндсэн хуульд нутгийн зөвлөлийг нутгийн удирдах байгууллагын санхүүгийн хувьд хүрсэн түвшинг харгалзан байгууллахаар тооцсоны үндсэн дээр байгуулахаар заасан боловч практикт нэг ч зөвлөлийг байгуулаагүй.

Бүс нутгуудийн эдийн засгийн эрчимтэй хөгжлийн ачаар 1979-1980 онд орон нутгийн захиргааны орлого ихээхэн өссөн, үүний зэрэгцээгээр тэдгээрийн үйл ажиллагааны хүрээг өргөтгөх шаардлага мэдрэгдсэн.

1980-аад оны дунд үед БНСУ-д нутгийн өөрийн удирдлагын зохион байгуулалтын асуудал, нутгийн өөрийн удирдах үйл ажиллагааны тодорхой санал, холбогдох арга хэмжээг идэвхтэйгээр судалж эхэлсэн.

1984 онд эрх баригч нам, гол сөрөг хүчний намын хооронд нутгийн өөрийн удирдлагыг хэсэгчлэн сэргээх талаар улс төрийн харилцан буулт хийсэн. 1986 оны 10 сард Засгийн газар нь Үндэсний хуралд хэлэлцүүлэхээр “Нутгийн удирдлагын тухай” хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг 1988 оны 3 сарын 8-нд баталж, 1988 оны 4 сарын 6-наас хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн.

1991 оны 3 сард сүүлчийн 30 жилд анх удаа Солонгост нутаг дэвсгэр, засаг захиргааны доод шатны нэгжийн зөвлөлд сонгох сонгуулийг, харин 6 сард нутаг дэвсгэр, засаг захиргааны томоохон нэгжүүдэд ийм сонгуулийг зохион байгуулсан.

Солонгосын нутаг дэвсгэр, засаг захиргааны хуваарь байн байн өөрчлөгдөж байснаас үл шалтгаалан орчин үеийн гурван шатлалт тогтолцооны үндсэн зарчим нь 1895 онд Кожоны¹ хаанчлалын үед тавигдсан байдаг.

Өмнөд Солонгост нутгийн удирдлага (нутгийн өөрийн удирдлага)-ын хамгийн дээд түвшин нь сууриных бөгөөд дараахаас бүрдэнэ:

1) Онцгой статустай хотын, (특별시 тхыкпёльси;

Онцгой статустай хот- АНУ-ын холбооны тойрогтой адил, энд засгийн газрын байгууллага байрладаг, улсын нийслэл-Сеул. Солонгосын Бүгд Найрамдах Улсын нийслэл нь хотын тойргуудад хуваагддаг;

2) Шууд харьяалалтай хот (광역시 (кванъёкси)

Шууд харьяалалтай хот -нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгжийн үндсэн нэгжийн нэг. Өмнөд Солонгост одоо үед шууд харьяалалтай зургаан хот байдаг: Пусан, Тэгу, Инчон, Кванжу, Тэжон, Ульсон. Шууд удирдлагатай Кванжу, Тэжон хотууд нь өөрийн бүрэлдэхүүндээ хотын тойрогтой. Шууд харьяалалтай Пусан, Тэгу, Инчон, Ульсан хотууд нь хотын тойргоос гадна

1 Кожон (сол. 고종, 1852-1919)- Чосоны хаанчлал 1863-1897, 1897-1907 -үеийн Солонгосын ван (хаан) (Чосон), улсыг “Те Хан Че Гук” гэж өөрчлөн нэрлэсний дараа (대한제국, “Их Ханы хаант улс”) хаан гэж дуудагдах болсон, 1910 оны 8 сарын 22-ны гэрээгээр Японд нэгдэхийн өмнөх хамгийн сүүлчийнхийн урьдах удирдагч.

бүрэлдэхүүндээ хошуудтай.

3) Суурингууд (ᄃ, (то- провинция)

Суурин нь-нутаг дэвсгэр, засаг захиргааны үндсэн нэгж. БНСУ-д 8 суурин (Чхунчхон-Пукто, Чхунчхон-Намдо, Канвондо, Кёнгидо, Кёнсан-Пукто, Чолла-Намдо), нэг онцгой автономит суурин (Чежудо)-тай. Суурин бүр нь хот болон хошуудад хуваагддаг.

Нутгийн өөрийн удирдлагын дунд түвшин нь дараах засаг захиргааны нэгжээс бүрдэнэ:

1) Хотын тойрог (ᄃ, (ку).

Сеул хот- шууд харьяалагддаг хот нь Кванжу, Тэжон болон хэд хэдэн томоохон хотууд жишээлбэл, Сувон буюу Чхонжу хотын тойргуудад хуваагддаг, гэхдээ тэдгээрийн нутаг дэвсгэр дээр хошууд байхгүй, учир нь хотод шууд харьяалалтай бусад хотууд нь хотын тойрог болон хошуудыг өөртөө багтаадаг. Хотын тойргууд нь районуудад хуваагддаг.

2) Хотууд (ᄃ, (си).

Хот - нь суурингийн бүрэлдэхүүн хэсэг. Хотууд нь 15000-аас багагүй оршин суугчтай, ихэвчлэн энэ босгыг давсан хошуудад хотын статус олгодог. Зарим хотууд нь 50 000-аас дээш хүн амтай (жишээ нь, Сувон, Чхонжу, Чонжу) нь хотын тойрогт, тойрог нь хотын районуудад хуваагддаг.

3) Хошууд (ᄃ, (кун-уезд).

Хошууд нь суурингийн бүрэлдэхүүн хэсэг, түүнчлэн шууд харьяалалтай Пусан, Тэгу, Инчон, Ульсан хотуудын бүрэлдэхүүн хэсэг. Хошууд нь 150 000-аас бага бөгөөд хотын тойрогтой харьцуулахад хүн ам багатай, хотжилт багатай байна. Хошуудыг тосгон, волость-д хуваана.

Удирдлагын доод түвшин нь дараах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээс бүрдэнэ:

1) Тосгон (ᄃ, ып -посёлок).

Тосгон нь Волостийн нэгэн адилаар хошуу болон 500000-аас бага хүн амтай хотуудын нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгжийн нэг мөн. Хошуудын төв хэсгийн районууд, эсхүл хотын хязгаар доторх илүү жижиг районууд ихэвчлэн тосгоны статустай байдаг. Тосгоны хүн ам нь ихэвчлэн 20000-аас дээш хүн байдаг.

2) Волость (ᄃ, мён)

Волость нь хошуудын (мөн 500000-аас доош хүн амтай хотын) засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нэг мөн. Волость нь тосгоноос цөөн хүн амтай, хот болон хошуудын доторх хүн ам багатай хэсэг мөн. Волость нь гамаануудад хуваагдана.

3) Хотын район (ᄃ, тон).

Хотын район-орон нутгийн тойрог болон тойрогт хуваагддаггүй хотын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн ганц нэгж. Хотын район “өөрийн захиргаа бүхий хамгийн бага нэгж. Хүн шигүү суурьшсан хэд хэдэн районууд нь (ᠭ᠎) ка-д хуваагддаг, энэ нь зөвхөн хаяг үүсгэх зорилготой бөгөөд тусдаа удирдлага байхгүй.

4) Гацаа (деревня- 리, ри)

Гацаа-тосгон, волостийн дор байдаг ганц нэгж. Гацаа нь Солонгосын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хамгийн жижиг нэгж мөн.

Нутгийн удирдлагын тухай хуулийн хамгийн сүүлчийн редакци нутгийн зөвлөлүүдийн бүрэн эрхийг өргөтгөж, тэдэнд нутгийн удирдах байгууллагуудын үйл ажиллагааг шалгах, хянах боломжийг өгсөн.

“Нутгийн удирдлагын тухай” хуулийн дагуу нутгийн засаг захиргааны удирдагч өөрийн орон нутгийн район, хот, хошууны ажлыг хуульд заасан хүрээнд удирддаг.

Нутгийн гүйцэтгэх засгийн чиг үүрэг:

- Түүнд төв Засгийн газраас эрх шилжүүлсэн чиг үүрэг (төрийн тодорхой бүрэн эрх);
- Төрийн өмч болон объектыг удирдах;
- Орон нутгийн татварыг тогтоох, хураах;
- Үйлчилгээ, худалдааны хүрээний асуудал;
- Орон нутгийн түвшний захиргааны бусад асуудал.

Бүх түвшний нутгийн удирдах байгууллагын бүтцэд боловсролын удирдлага заавал орох бөгөөд өөрийн засаг захиргаа, нутаг дэвсгэрт боловсрол, соёлын асуудлыг эрхэлдэг.

2005 оны 4 сард Үндэсний хурал нутгийн удирдлагыг өөрчлөн байгуулах асуудлаар тохиролцоонд хүрсэн.

Өөрчлөн байгуулалтыг 2010 онд эхлэх, ингэхдээ одоогийн нутгийн удирдлага, нутгийн өөрийн удирдлагын гурван түвшинт тогтолцоог хоёр түвшинт тогтолцоогоор солихыг санал болгосон. Тосгон болон шууд харьяалалтай хотуудыг өөрчлөн байгуулж, татан буулгах ёстой байсан. Үүний оронд нутгийн өөрийн удирдлага, удирдлагын дээд шат нь шинэчлэлийн төлөвлөгөөгөөр, одоогийн хотын тойрог, хотууд болон хошуудыг шууд харьяалалтай, ойролцоогоор тус бүр 1 сая оршин суугчтай 60 хот болгох юм.

Гэвч шинэчлэлийн нарийн зүйлсийг боловсруулаагүй байсан учраас одоог хүртэл эхлээгүй л байна гэж мэдээлж байна.

7.3. Бүгд Найрамдах Хятад Ард Улс

中华人民共和国

Чжунхуа Женьминь Гунхэго¹

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн болон үндэсний төрийн байгуулалтын оновчтой бүтцийг эрэлхийлэх нь төрийн зохион байгуулалтын чухал асуудлын нэг мөн бөгөөд энэ асуудлыг шийдвэрлэх нь төрийн аппаратын үр нөлөөг дээшлүүлэх, түүний үйл ажиллагааны чанарыг сайжруулах, хүн амтай холбоог бэхжүүлэх үр ашигтай хүчин зүйл мөн. Үүний үр дүн нь төрийг бэхжүүлэх, аж үйлдвэржүүлэх хүчнийг хөгжүүлэх, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх, хүний бүх талын, иж бүрэн хөгжлийн үндэс болох юм.

Төрийн байгуулалтын гол чухал элементийн болон төрийн зохион байгуулалтын шинж чанарын нэг нь тодорхой нутаг дэвсгэрийн хүн амыг хамрах байдаг. Нутаг дэвсгэр том, хүн ам олон байх нь удирдлагыг хамгийн зохистой болгох шаардлагын сонирхлыг бий болгох бөгөөд үүний тулд улсын нутаг дэвсгэрийг тодорхой хэсэгт хувааж, тэдгээрт зориулж удирдах байгууллагыг бий болгодог.

Орчин үеийн хятадын төрийн бий болсон түүх туйлын сонирхолтой бөгөөд олон талтай. Хятадад үндсэн хуульт ёсны үзэл санаа XIX зууны эцэст үүссэн. Ийм төрлийн санааг агуулсан анхны баримт бичиг бол хааны сэнтийд зориулж шинэчлэлийн талыг баримтлагч Кан Ювэй, Ли Цичао, Тань Сыгун нарын бичсэн “Мянган үгний санамж бичиг” (一万词备忘录, yī wàn cí bèiwànglù) гэж үздэг.

Үүнд зөвхөн үндсэн хуулийг батлахыг шаардаад зогсохгүй, парламентыг зарлан хуралдуулах, улс төрийн удирдлагад хятадын бүх нийгмийн давхаргыг татан оролцуулахыг шаардсан².

Хятадын хөгжлийн шинэ эрин 1911 оны Синьхайн хувьсгал гэж нэрлэдэг Учаны бослогын ялалтын дараа эхэлсэн³.

1 Цаашид эх бичвэрт хятад ханзын дуудлагын утгыг шилжүүлэх текстийн тухайд Хятад хэлний “рентген” хэмээх албан ёсны системийг (拼音 pīnyīn) “Пиньин” хэрэглэнэ. Ханзыг бичихэд 1964 оны Хятадын стандартын товчилсон бичлэгийг хэрэглэдэг. Ийм маягаар, БНХАУ- 中华人民共和国 (zhōnghuá rénmin gònghéguó).

2 Егоров К.А. Хятадын төлөөллийн тогтолцоо: түүх болон орчин үе. (Гудошникова Л.М, М. Спарк нарын хянан тохиолдуулсан, 1998.х.7.)

3 辛亥革命 (xīnhài gémìng) - 1912 оны хувьсгал. (辛亥年 (xīnhàinián) - Хятадын зурхайн жаран жилийн календараар 1911.01.01-1912. 01.23 жилийн нэрийг галигласан; 革命(gémìng) - үгчлэн: амьдралын өөрчлөлт Хятадад эртнээс хэрэглэсээр ирсэн); Энэ талаар дэлгэрэнгүйг үзнэ үү: История Китая: Учебник/Под.ред. А.В.Меликсетова. 3-е изд.М. :Изд-во МГУ:Изд дом “Оникс 21 век”, 2004.с.365-378.

Бослогын гол хүч нь хувьсгалт арми байсан бөгөөд цөм нь босогчдын талд орсон германы цэргийн туршлагаар зохион байгуулагдаж, зэвсэглэсэн “шинэ арми”-ийн хэсэг, ангиуд байсан бөгөөд дараа дараагийн бүх үйл явдлын явцад онцгой үүрэг гүйцэтгэсэн юм. 1911 оны 12 сарын 29-нд болсон тосгоны хурлаас хувьсгалт хөдөлгөөний нэрт зүтгэлтэн Сунь Ятсенийг түр ерөнхийлөгчөөр сонгосон. Тэр 1912 оны 1 сарын 1-нд Нанжинд тангараг өргөсөн. Энэ үйл явдал нь БНХАУ-ын тунхагласан өдөр болсон¹.

Босогчид болон Хятадын хаант Улсын Засгийн газрын хооронд 2 дугаар сарын 12-нд хийсэн хэлэлцээрийн дүнд хааны бэлэвсэн хатан бага насны хаан Пу И-гийн өмнөөс хаан суудлаас татгалзаж, төрийн эрхийг ард түмэнд шилжүүлэх тухай эдикт гаргасан.

Гэвч өөр янз бүрийн шалтгаанаар Синьхайн хувьсгалын дараа 1911-1913 онд Хятадад хөрөнгөтний ардчилсан төрийн байгуулалт тогтвортой бүрдэж тогтоогүй. БНХАУ-д барууны хөрөнгөтөн улсуудын үндсэн хуульт загварын үндсэн дээр төрийн байгуулалт хий оролдлого амжилтгүй болсон. XX зууны хоёр дахь хагаст Хятадын нийгмийн болон төрийн хөгжил төрийн байгуулалтыг хөрөнгөтний-ардчилсан үндсэн хуулийн зарчмаар зохион байгуулах боломжгүй гэдгийг нотолсон².

Гэвч Зөвлөлүүдийн зарчим болон хувьсгалт ангийн дэглэм дээр тулгуурласан, ЗСБНХУ-ын дараа дэлхийд хоёрт орох-Хятадын Зөвлөлт Улсын (1931-1934 ардын төрийг байгуулах гэсэн анхны оролдлого нь дотоод гадаад зүйлээс шалтгаалж мөн л амжилтгүй болсон³.

Бүгд Найрамдах Хятад ард Улс (БНХАУ)⁴-ыг тунхаглах улс төр-эрх зүйн нөхцөлийг хангах үйл ажиллагаа 1949 оны 7 сарын 15-наас 9 сарын 30-ны

1 中华民国 (zhōnghuá mínguó)- 1912-1949 онд Хятад дахь, түүнчлэн 1949 онд Тайванд улсуудын ерөнхий нэр,. (үгчилбэл: 民国 ардын төр)

2 Улс төрийн амьдралд Гоминьдан ноёрхол, болон төрийн эрх мэдлийг хуваарилах хөрөнгөтний-ардчилсан зарчимтай нэг хүний засгаас Сунь Ятсений үзэл рүү шилжих нь эцсийн бүлэгт нэг хүнийг шүтсэн хөрөнгөтний-партократ (нам шүтсэн), түүхийн тодорхой шатанд улс орныг нэгтгэх асуудлыг шийдвэрлэх, улс төрийн тогтолцоог ардчилах, төв болон орон нутгийн засгийн хоорондын асуудал, чадваргүй төрийг бий болгосон нь үндсэн хуулийн зохицуулалт бодитой бус болохыг ямар нэг хэмжээнд харуулсан, улмаар эцэст нь ийм дэглэм 1949 онд улсын бүх нутаг дэвсгэрт уналтыг авчирсан.

3 БНХАУ-д тогтвортой эрх зүйн тогтолцоо, тухайлбал, үндсэн хуультай болсон нь цаашид ардын- ардчилсан төрийн хөгжлийн үзэл суртлын суурь нь болсон. Бүхэлдээ төрийн ийм хэлбэр нь Хятадад өмнө нь байсан бүх төрөөс илүү дэвшилттэй байсан боловч, энэ нь гол нь дотоод хүчин зүйлийн улмаас цаашид хөгжөөгүй. Хувьсгалын үйл явцын бодит нөхцөл, субъектив хүчин зүйлүүд нь гадаадын дайсанагч нөхцөлд зөвлөлтийн хөдөлгөөнийг ялагдахад хүргэж дараа нь шинэ ардын-ардчилсан хэлбэр рүү шилжсэн.

4 中华人民共和国 (Зонгуа ренмин) Хятад хэл дээр түүхэн томъёо 民国 анхаарлаа хандуулах нь зүйтэй. -үгчилбэл:”ардын (иргэний) төр”, БНХАУ-ын нэр 共和国(gònghéguó) Үгчилбэл: “нийтийн зөвшлийн төр” орос хэл дээр “Бүгд Найрамдах Улс” гэж бууна.

хооронд явагдсан бөгөөд үүнд дараах үндсэн арга хэмжээнүүд хамрагдсан:

- Хятадын ардын улс төрийн зөвлөлдөх зөвлөлийн Бэлтгэл хорооны хоёр чуулганы хуралдаан;
- Зөвлөлийн өөрийнх нь чуулганы хуралдаан.

Зөвлөлийн хуралдаан 1949 оны 9 сарын 21-нд Бэйпинд¹ нээгдэж Ардын Бүгд Найрамдах улсыг байгуулах хурлын чиг үүргийг өөртөө хүлээсэн.

Чуулганы хуралдаан ардын нэгдсэн фронтын зохион байгуулалт-эрх зүйн үндсэн хэлбэр болсон Хятадын ардын улс төрийн зөвлөлдөх зөвлөлийн Бэлтгэл хорооны “Зохион байгуулах статут” (Дүрэм), “Ардын Төв Засгийн газрыг зохион байгуулах тухай” хууль, Намын Ерөнхий хөтөлбөрийг баталсан.

Чуулганаас түүнчлэн “БНХАУ-ыг байгуулсан тухай тунхаглал”-ыг баталж, төрийн дуулал, далбаа, нийслэлийн тухай, түүний нэрийг өөрчлөх тухай тогтоолыг баталсан.

БНХАУ-ыг албан ёсоор тунхаглах ёслол 1949 оны 10 сарын 1-нд Бээжинд олон нийтийг хамарсан хурал дээр болсон. 10 сарын 2-нд БНХАУ-г ЗСБНХУ² хүлээн зөвшөөрсөн. Хятадын түүхийн шинэ үе шат эхэлсэн.

Чөлөөлөгдсөн районуудад БНХАУ-ыг тунхаглахаас өмнө бодитой зүйл болсон энэ улсын төрийн шинэ байгуулалт хууль зүйн хувьд улс даяар эрх зүйн хувьд хэлбэржсэн.

БНХАУ-д нутгийн удирдлага, нутгийн өөрийн удирдлагын хөгжлийн үндсэн чиглэл нь үндэсний (Улсын) хэмжээний асуудлыг шийдвэрлэхтэй салшгүй холбоотой байсан. Тэдгээрийг чухамаа БНХАУ-ыг байгуулахын өмнөхөн байгуулж, Хятадын ардын улс төрийн зөвлөлдөх зөвлөлийн Бэлтгэл хорооны ерөнхий төлөвлөгөөнд оруулсан. Үндэсний бодлогын шинэ чиглэлийн онцлог нь үндэсний хэмжээний бодлогыг шийдвэрлэхэд нам зөвлөлтийн загвараас (苏联模式, sūlián móshì) өөр замыг сонгосон явдал байсан. Хятадын Коммунист Нам энэ загварын дараах суурь зарчмуудаас татгалзсан:

- үндэсний өөрийн хуваарилалт (хэсэг хүртэл);
- улс орны холбооны төрийн байгуулалт³.

Түүнчлэн улс орны ард түмнийг үндэстэн, ястанд хуваахаас татгалзсан. Хятадын бүх үндэстнүүдийг тэгш үндэстэн (民族, mínzú) -д тооцсон.

Энэ нь улс орон дахь үндэстнүүдийн тэгш байдлыг баталгаажуулахад

1 北平, běipíng - “Хойт амгалан тайван байдал”, Бээжин гэж нэрлэхээс өмнөх нэр, 北京, běijīng-“Хойт нийслэл”

2 Энэ тухай: Тихвинский С. Под звуки “Марша добровольцев” // Родина. Спец.вып. 55: Россия и Китай. Великие соседи. М. ИДВ РАН, 2004. Х.302 -оос үзнэ үү.

3 Энэ тухай Үзэх: Москалёв А.А., Лазарева Т.В. Национальная политика// КНР 55 лет. Политика, Экономика, культура. М., ИВД РАН, 2004.с.302.

дэмжлэг болох ёстой байсан.

Хятадын ардын улс төрийн зөвлөлдөх зөвлөлийн Бэлтгэл хорооны Ерөнхий хөтөлбөрийн 6 дугаар бүлэгт зааснаар:

- Хятадын бүх үндэстний тэгш эрхт байдал;
- Их хан үндэстний үндсэрхэг үзлийг ялан дийлэх, жижиг үндэстний “явцуу” үзлийг даван туулах;
- Үндэсний эв нэгдлийг бутаргахад чиглэсэн дөнгө, үйлдэл, ялгаварлан гадуурхалтыг хориглох;
- Үндэсний цөөнхийн оршин суухад тохиромжтой нутаг дэвсгэрт нутаг дэвсгэрийн хараат бус байдлыг хэрэгжүүлэх;
- Үндэстний хараат бус нутагт үндэсний нутгийн өөрийн удирдлагыг бий болгох;
- Нутгийн эрх мэдлийн байгууллагад хан бусчуудын төлөөллийг бий болгох;
- Үндэстний цөөнхөд өөрийн хэл, бичгийг хөгжүүлэх, өөрийн ёс заншлаа хадгалах, өөрчлөх, шашныг саадгүй шүтэх эрх чөлөөг олгох;
- Үндэстний цөөнхөд тэдний улс төр, эдийн засаг, соёлын хөгжилд туслалцаа үзүүлэх үүргийг засгийн газар өөртөө авах.

Нутгийн өөрийн удирдлага, хараат бус байдлыг бий болгох эхний шатанд гол үүргийг “БНХАУ-д районы үндэсний бие даасан байдлыг хэрэгжүүлэх үндсэн зарчмууд” хэм хэмжээний акт чухал үүрэг гүйцэтгэсэн. Энэ актад зааснаар үндэсний автономит район нь БНХАУ-ын салшгүй хэсэг, нутгийн өөрийн удирдлагын байгууллагууд өөрийн үйл ажиллагааг нэг төвлөрсөн удирдлагын дор гүйцэтгэж, орон нутагт ардын дээд засгийн захиргаан дор явуулна¹.

Энэ баримт бичигт үндэсний автономит районы бодлогын үндсэн асуудлыг зохицуулсан:

- автономит районуудыг байгуулах зарчим;
- нутгийн өөрийн удирдлагын эрх;
- үндэсний автономит район дахь үндэсний харилцаа;
- дээд шатны захиргааны байгууллагаас үндэсний автономит районтой харьцах харилцаа.

Үндэстний шинж чанараараа хүн ам гурван үндсэн автономит нэгжид хуваагддаг:

- 1) аль нэг үндэстний оршин суух район;
- 2) тооны хувьд дийлэнх олонх болсон үндэстнээс гадна бусад (цөөн

тооны) бүлэг үндэстэн оршин суудаг район;

3) хоёр буюу түүнээс дээш харьцангуй олон тоотой үндэстэн оршин суудаг район.

Энд нутаг дэвсгэрийн автономит нэгжид хан үндэстний оршин суугаа нутаг дэвсгэрийг оруулахыг зөвшөөрч байсан бөгөөд энэ нь эдийн засаг, улс төрийн болон бусад шаардлага, түүнчлэн “тэдний өнгөрсөн түүхтэй ч холбоотой”.

Автономит районы засаг захиргаа-эрх зүйн статусыг Хятадад тогтоосон засаг захиргааны хуваарийн дагуу тогтоодог.

Эцэст нь автономит нэгжийг нэрлэх стандарт хэлбэрийг хэрэглэх болсон (зарим онцгой тохиолдлоос бусдад), үүний дагуу нэр нь хоёр бүтэцтэй: газарзүйн нэр болон автономийг хэрэгжүүлж байгаа үндэстний¹ нэр.

Дээр дурдсан баримт бичгүүдийн нөлөөн дор Хятадад үндэстний асуудлыг шийдвэрлэх бодитой, одоо хүртэл хэрэглэж байгаа арга бий болсон, энэ нь төрийг бэхжүүлэх, үндэстнүүдийн нэгдэл нягтрал, улсын онцлог, түүнчлэн одоо үед ОХУ-д хэрэгжүүлэх гэж оролдож байгаа “үндэстнүүдийг нэгтгэх”-ээс зарчмын хувьд татгалзсан явдал юм.

Энэ чиглэлийн гол санааг БНХАУ-ын Үндсэн хуулийн Оршил болон 4 дүгээр зүйлд тогтоосон, эдгээрийн дагуу Хятад Улс бол “олон үндэстний нэгдсэн улс”² мөн “бүх үндэстний цөөнхийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг баталгаажуулж, бүх үндэстний тэгш, нягт харилцан туслах харилцааг хөгжүүлж, хамгаална.”

Хятадын эрдэмтдийн үзэж байгаагаар Төрийн нэгдмэл хэлбэр нь “бодитоор оршин байгаа болон хятадын түүхэн нөхцөл”-өөс шалтгаалж байгаа. Үүний дотор улс орон доторх үндэстний харилцааны онцлог орно. ³

Төрийг нэгдмэл гэсэн тодорхойлолт БНХАУ-ы анхны болон одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Үндсэн хуульд орсон⁴.

Судлаачдын тэмдэглэж байгаагаар, Хятадын Коммунист нам энэ нөхцөлд “Улс үндэсний асуудлыг шийдвэрлэх өөрийн, Хятад замаар явахдаа

1 Үзэх: Основные нормативные акты о местных органах власти и государственном управлении Китайской народной Республики. М., 1958.с.64-65.

2 统一的多民族国家 (tōngyī de duō mínzú guójiā) Единая (нэгдмэл), олон үндэстний орон

3 Дэлгэрэнгүйг үзэх: 羊惊人. 批判地方民族主义. - 反对地方民族主义为建设祖国社会主义大家庭而奋斗一 北京. 一九五八年. (Yáng Jīngrén. Pīpàn dìfāng mínzúzhūyì.- Fǎnduì dìfāng mínzú zhūyì wèi jiànshè zǔguó shèhuìzhūyì dà jiāting ér fèndòu.) Үзэх: Ян Цзинжэнь. Критика местного национализма. Выступая против местного национализма, бороться за создание большой социалистической семьи родины. Пекин, 1958.с.94..

4 Үзэх: Конституция и законодательные акты Китайской Народной Республики. М., 1955. С.30. 中华人民共和国宪法 (2004年宪法修正案) // 人民日报. 1982年12月5日 - 2004年3月17日. (Zhōnghuá rénmin gònghéguó xiànfǎ (2004 nián xiànfǎ xiūzhèngàn). rénmin rìbào) БНХАУ-ын Үндсэн хууль (2004 оны өөрчлөлттэй) // Народный ежедневник. 1982.12.05-2004.03.17.

зөвхөн районы үндэсний автономийн бодлогыг хэрэгжүүлж болох байсан.”¹

Гагцхүү ийм байр суурь нь өөрийн сайн, муу талтай. Үндэстнийг хүлээн зөвшөөрөх, түүний нэрийг улсын хэмжээнд БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн шийдвэрээр хүлээн зөвшөөрдөг нөхцөл бий болсон нь хэдийгээр хүмүүсийн нийгэмлэг бүрийн онцлогийг харгалздаг ч гэсэн үүнийг үндэстнийг нийгэмлэг болон овог омгоос тусгаарлах хамгийн зөв шийдэл гэж болохгүй².

Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн болон үндэстний-төрийн байгуулалт нь харилцан маш нарийн уялдаа холбоотой байдаг. БНХАУ байгуулагдсан үеэс хөдөөгийн, хошууны (үезд) болон волость гэсэн гурван шатлалт хуваарь хэвээр үлдсэн. Өөрчлөлт нь үндсэндээ дараах байсан:

- Аливаа засаг захиргаа - нутаг дэвсгэрийн нэгж, газар зүйн объектын хил, нэрийг тодруулсан;
- Тэдгээрийн тоог нэмэгдүүлэх, эсхүл цөөрүүлэх гэх мэт.

Өмнө байсан бүтцийн хүрээнд тодорхой өөрчлөлтүүд гарсан. Энэ нь ихэвчлэн эдийн засгийн тусгай хүчин зүйлүүдээр тодорхойлогдоно: хот маягийн суурингуудын тоо олширч, өмнө байсан хотууд хөгжих шалтгаан болсон, тосгодыг нэгтгэх болон аж үйлдвэржүүлэлтэд тодорхой өөрчлөлт гарсан³.

Үүний зэрэгцээгээр одоо үед улсыг районуудад хуваахдаа үндэстний болон түүхийн онцлог дээр тулгуурлахаас илүүтэйгээр эдийн засгийн зохистой байдлыг хангах дээр тулгуурладаг.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тогтолцооны үндсэн хуулийн загварын үндсэн заалтуудыг Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлд тодорхойлсон. БНХАУ-ын Үндсэн хуульд зааснаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн дараах хуваарь байдаг:

Улсын нийт нутаг дэвсгэр дараах байдлаар хуваагддаг:

1) Муж (провинци)⁴ (省, shěng), өөртөө засах район (自治区, zìzhìqū), шууд /төвөөс/ захирагдах хотууд (直辖市, zhíxiá shì);

1 黎鸿烈论区域自治的理论政策和实践 // 民族研究. 1983年. 2号. (Lí Hóngliè. Lùn qūyù zìzhì de lǐlùn, zhèngcè hé shíjiàn. - Mínzú yánjiū) Үзэх: Ли Хунле. Районы үндэсний автономийн онол, бодлого, практикийн тухай // Үндэсний судалгаа. 1983. # 2. С.2.

2 БНХАУ-ын үндэстнүүдийн нэрийг харьцуулахад нэлээд хүндрэл гардаг учраас судалгааны иж бүрэн байдлыг хангах үүднээс Хятадад албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн жагсаалт, тоог харууллаа. 2000 оны хүн амын тооллогын материал дээр үндэслэсэн үндэстнүүдийн тухай нэгтгэсэн мэдээллийг Хавсралт 1-д харуулав.

3 Энэ талаар дэлгэрэнгүйг үзэх: Государственный строй Китайской Народной Республики /Хариуцлагатай ред. Л.М.Гудошников М., Наука. Гл. Ред. Востлит., 1988, С.112-114.; Гудошников Л.М. Политический механизм Китайской Народной Республики. М., 1974. С.91.

4 “губерния” гэж орчуулсан байдаг нь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжтэй илүү тохирч байгаа юм.

2) Муж болон өөртөө засах район нь өөртөө засах тойргууд¹ (自治州, zìzhì zhōu), хошууд (自治州, zìzhì zhōu), өөртөө засах хошууд (县, xiàn) болон хотуудад (自治县, zìzhì xiàn) хуваагддаг;

3) Хошуу, өөртөө засах хошуу нь волость-д (乡, xiāng), үндэсний волость (民族乡, mínzú xiāng)-д хуваагддаг;

4) Төвд захирагдах хотууд болон харьцангуй том хотууд² (较大的市: jiào dà de shì район (区, qū) болон хошуудад (县, xiàn) хуваагдана.

Өөртөө засах тойрог нь хошууд, өөртөө засах хошууд, хотод хуваагддаг.

Үүний зэрэгцээгээр Үндсэн хуульд зөвхөн ардын төлөөлөгчдийн хурлыг хуралдуулдаг, *ардын засгийн газрыг* байгуулдаг засаг захиргаа - нутаг дэвсгэрийн нэгжийг нэрлэсэн гэдгийг тэмдэглэх ёстой. Үндсэн хуульд өгсөн засаг захиргаа - нутаг дэвсгэрийн нэгжийн хүрээ нь бүрэн гүйцэд биш юм.

Үүнд шаардлагатай тохиолдолд захиргааны онцгой районыг (онцгой захиргаат орон) (特别行政区, tèbié xíngzhèng qū) байгуулж болно гэсэн Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлд заасан. Захиргааны онцгой районы дэглэмийг тодорхой нөхцөл байдлыг тооцож, Бүх Хятадын Ардын төлөөлөгчдийн хурлаас хуулиар тогтооно.

Нутаг дэвсгэрийн бүтцийн дээр дурдсан гурван үүр (шат) (муж, хошуу, волость)-ээс гадна зарим мэргэжилтнүүд засаг захиргааны тогтолцооны дөрөв дэх шатыг ангилдаг. Энэ нь хошуу, муж хоёрын хоорондын маягийн тойргийн шат³ юм. Энэ нь нэлээд үндэслэл бүхий.

2012 оны 1 сарын 1-ний үзүүлэлтээр БНХАУ-д дараах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүд мужийн шатанд байгуулагдан ажиллаж байна:

- 22 муж (省, sheng);
- 5 автономит район (自治区, zìzhì qū);
- шууд харьяалалтай 4хот (直辖市, zhíxiá shì);
- засаг захиргааны 2 онцгой район (онцгой захиргаат орон) (特别行政区, tèbié xíngzhèng qū);
- эчнээгээр мужийн шатанд Тайвань⁴ бас ордог.

1 “область”, “край”, “штат”, болон “префектура” гэсэн орчуулгууд тааралдна.

2 Мужийн дэд (субпровинциальный) ач холбогдол бүхий хот, өнгөрсөн үед тусгай “төлөвлөгөөт жагсаалт”-д ордог байсан. Эдгээр хотын засгийн газар нь засаг захиргааны нэгжийн хувьд мужийн засгийн газрын дор ордог боловч захиргааны харилцаанд үнэн хэрэгтээ мужийн засгийн газраас харьцангуй хараат бус. Хятадад нийт 15 ийм хот байдаг: Шэньян, Дальян, Чанчунь, Харбин, Цзинань, Циндао, Нанжин, Нинбо, Ханчжоу, Сямэнь, Ухань, Гуанжоу, Шэньжэнь, Сиань, Чэнду.

3 Ийм үзлийг тухайлбал, Хятадын эдийн засгийн-газар зүйн нэрд гарсан мэргэжилтэн К.Н.Черножуков баримталдаг. Үзэх: Глунин В.И. Третья гражданская революционная война в Китае. М., 1958. С.29-33.

4 Мужийн шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн жагсаалт, тэдгээрийн жинхэнэ

Завсрын тойргийн шатанд:

- тойрог (州, zhōu), өөртөө засах тойрог (自治州, báizhìzhōu);
- аймаг¹;
- мужийн шууд харьяалалтай хот (自治州, báizhìzhōu) ордог.

Мөн засаг захиргааны районыг (行政区, xíngzhèng qū) тойргийн шаттай адилтгаж болно.

Ийм онцгой статустай районд Хайнаны засаг захиргааны район ордог. Энгийн засаг захиргааны районыг мужийн ардын засгийн газрын эрх шилжүүлсэн байгууллага-районы засаг захиргааны удирдлага (мужийн ардын засгийн газраас шууд байгуулсан) удирддаг.

Тэдгээрээс ялгаатай нь Хайнаны засаг захиргааны район сонгуулийн замаар ардын төлөөлөгчдийн хурлыг байгуулж, хуралдуулах эрхийг авсан, ардын төлөөлөгчдийн хурал нь районы Засгийн газрыг бүрдүүлнэ. Засгийн газар нь (босоогоор захирагдах журмаар) Гуандун мужийн Засгийн газарт харьяалагдана. Хайнаны захиргааны районыг байгуулах тухай шийдвэрийг БХАТХ-ын 2 дугаар чуулганаас 1984 оны 5 сарын 31-нд гаргасан².

Түүнд онцгой эрх зүйн байдал олгосон захиргааны нэрийн өмнөөс гадаадын фирмүүдтэй гэрээ байгуулах нь тэдгээрийн ач холбогдлыг нэлээд бууруулж байсан. Учир нь, түүний бүрэн эрх нь нутгийн ардын засгийн газрынхаас ихээхэн бага байсан³. Сүүлд мөн энэ шалтгаанаар 1988 оны 4 сарын 13-нд БХАТХ-ын анхдугаар чуулган дээр Хайнань⁴ мужийг байгуулах, төв нь Хайкоу байх тухай шийдвэр гаргасан. Үүнтэй нэгэн зэрэг эдийн засгийн тусгай бүс - Хайнань-ийг байгуулах тухай шийдвэр гаргасан⁵.

Ийм байдлаар мужийн шатанд ардын төлөөлөгчдийн хурал чуулуулах эрхийг зөвхөн өөртөө засах тойрог (自治州, zìzhì zhōu) болон байгуулсан тохиолдолд засаг захиргааны район (行政区, xíngzhèng qū) эдэлнэ.

Хошууны шатанд:

- уезд (хошуу) (县, xiàn);

нэрийг Хавсралт 2-оос үзнэ үү.

1 Аймаг (монг- аймаг) засаг захиргаа - нутаг дэвсгэрийн нэгж монгол, турк иргэдийн гарал, овгийн нэрээс үүсэлтэй. БНХАУ-өвөр монголын өөртөө засах районы тойрогтой адилтгана. Аймаг нь хошуунд хуваагдана.

2 人民日报 (rénmín rìbào) Народный ежедневник, 1984.06.01.

3 Энэ тухай үзэх: Государственный строй Китайской Народной Республики. С.114-115.

4 全国人民代表大会■于设立海南省的决议//人民日报1988年4月17日。(quánguó rénmin dàibiào dàihuì guān yú shèlì hǎinán shěng de juéyì. rénmin rìbào) Хайнань мужийг байгуулах тухай БХАТХ-ын тогтоол// Народный ежедневник, 1984.04.17.

5 全国人民代表大会■于建立海南经济特区的决议 // 人民日报。1988年17月4日(quánguó rénmin dàibiào dàihuì guān yú jiànli hǎinán jīngjì tèqū de juéyì. rénmin rìbào) Хайнанийн эдийн засгийн тусгай район (эдийн засгийн онцгой бүс) байгуулах тухай, БХАТХ-ын тогтоол// Народный ежедневник, 1984.04.17.

- хошуу (хошуны);¹
- автономит уезд (自治县, zìzhì xiàn);
- автономит хошуу (хошуны);
- мужийн харьяалалтай хот (市, shì), район (区, qū);
- төвд шууд харьяалалтай хотын (直辖市, zhíxíá shì) хошуу (县, xiàn);
- харьцангуй том хотуудын (төвлөрсөн) хошууд (较大的市, jiào dà de shì) байгуулагдаж болно.

Мөн хошууны шатанд тусгай болон онцгой район (特区, tèqū) хамаарна. Хамгийн доод волостийн шатанд нь:

- отог (волость) (乡, xiāng);
- үндэсний отог (民族乡, mínzú xiāng);
- суурин (镇, zhèn), түүнтэй адилтгах сум болон кочи хамаардаг.

БНХАУ-ын нийгэм-эдийн засгийн түргэвчилсэн хөгжлийн нөхцөлд хотжуулалт болон хотын ойлголтыг тодорхойлохыг шаарддаг. Тухайлбал, Төрийн Зөвлөл²-ийн мэдээлэлд хотыг дараах байдлаар ангилдаг:

- төвд харьяалалтай хотууд;
- мужид харьяалалтай болон засаг захиргааны өөр өөр төвүүдэд харьяалалтай харьцангуй том хотууд;
- хотын ойролцоох тосгон (посёлок);
- хот гэж нэрлэдэггүй отогийн төвүүд.

Хотын категорт түүнчлэн уул уурхайн район болон хот маягийн тосгон ордог.

Төрийн Зөвлөлөөс хотын гурван үндсэн бүлгийг ангилсан:

- том хотууд (500 мянгаас дээш хүн амтай);
- дунд зэргийн хотууд (200- 500 мянган хүн амтай);
- жижиг хотууд (200 мянгаас доош хүн амтай)

Үндсэн хууль (62 дугаар зүйлийн 12 дугаар заалт)-д зааснаар тосгон, автономит район, хотыг байгуулах шийдвэрийг БХАТХ гаргана.

Муж, өөртөө засах район, төвд харьяалалтай хот, түүнчлэн өөртөө засах муж, хошуу, хотын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн ангиллын тухайд үүнийг Төрийн Зөвлөл батална (зүйл 89, заалт 15).

Ийм байдлаар улсын нутаг дэвсгэрийн зохион байгуулалтыг төрийн эрх барих төв байгууллага (БХАТХ) болон төрийн удирдлагын төв байгууллага (Төрийн Зөвлөл) шийдвэрлэнэ.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Үндсэн хуульд зааснаар өөртөө засах район, өөртөө засах тойрог, өөртөө засах хошууд нь үндэсний өөртөө засах

1 хошуу (знамя) Өвөр Монголын монгол хүн ам оршин суух орон нутаг дахь засаг захиргааны нэгж. БНХАУ-д өөрийн ач холбогдлоор уезд (хошуутай)-тай адил.

2 Үзэх: (广西日报 (guǎngxī rìbào) Гуансийн өдрийн сонин. 1984.05.25.

нутаг дэвсгэр (自治地方, zìzhì dìfāng) мөн.

Үндэсний өөртөө засах районы тогтолцоо гэдэг нь үндэстний цөөнх цомхоноор амьдрах районд өөртөө засах байдлыг тогтоох, тэнд өөрийн удирдах байгууллагыг байгуулах, төрийн нэгдсэн удирдлагын дор өөртөө засаглах эрхийг хэрэгжүүлэхийг хэлнэ.

Үндэсний өөртөө засах районы захиргааны статус зарчмын хувьд тухайн районы хэмжээ, тэнд амьдарч байгаа хүн амын тооноос шалтгаална. Өөртөө засах район мужийн шатанд, өөртөө засах тойрог нь тойргийн шатанд, өөртөө засах хошуу нь хошууны шатанд хамаарна. 2003 онд янз бүрийн түвшний үндэсний өөртөө засах 154 нэгж тоологдсон байсан¹.

1980 онд БНХАУ-д үндэстний (үндэстний цөөнхийн) хууль тогтоомжийн олон шатлалт тогтолцоог бий болгож эхэлсэн. Энэ тогтолцооны үндсийг:

- Үндсэн хуулийн холбогдох заалт;
- “Үндэсний районы өөртөө засах тухай” 1984 оны хууль;
- Өөртөө засах тухай дүрэм;
- Үндэстний районуудад боловсруулж, баталсан хэм хэмжээний акт;
- Орон нутгийн бусад хууль тогтоомжийн акт бүрдүүлнэ.

Үндэсний өөртөө засах районуудыг “хан бус үндэстнүүд” цомхоноор амьдрах нутаг дэвсгэрт байгуулна. Энэ үүднээс Хятадад Үндэстний өөртөө засах район нь “ердийн өөртөө засах (автономит) нутаг дэвсгэртэй адил биш” (自治地方, zìzhì dìfāng)² гэдгийг тэмдэглэсэн байна³.

Үндэсний өөртөө засах район (民族自治地方, mínzú zìzhì dìfāng) гэдэг нэр томъёо нь өөрөө БХНАУ-д хүлээн авсан автономит тогтолцооны томоохон онцлогийг илэрхийлж байна. Энэхүү өөртөө засах тогтолцоо нь орон нутгийнх биш (дурын нутаг дэвсгэрт зориулсан), харин үндэстний, өөрөөр хэлбэл, үндэстний цөөнхийн өөртөө засах (автономи) юм. Үндэстний районы засаг захиргааны байгууллагыг өөрөө удирдах байгууллага гэдэг. Тэдний бүрэн эрх нь дараахаас бүрдэнэ:

- Зохих түвшний “орон нутгийн ердийн төрийн байгууллага”-ын бүрэн эрх;
- “өөрийн удирдлагын эрх” гэж нэрлэддэг эрхүүдээс бүрдэнэ.

Энэ хоёр төрлийн бүрэн эрх нь “хоорондоо ялгаатайн зэрэгцээгээр харилцан маш нягт холбоотой учир олон районд тэдгээрийг ялгахад их

1 民族研究 (Mínzú yánjiū) Национальные исследования. 2003.# 5.C.5.

2 中华人民共和国民族区域自治法 (2001修正) //人民日报。2001年3月15日。

(zhōnghuá rénmin gònghéguó zhōnghuá rénmin gònghéguó mínzú qūyù zìzhì fǎ (2001 xiūzhèng). rénmin rìbào) БНХАУ-ын “Үндэсний өөртөө засах районы тухай” хууль (2001 онд шинэчилэн найруулсан) //Ардын өдрийн сонин. 2001.03.15.

3 Бидний мэдэж байгаагаар, нутгийн захиргааны автономийг (хүн амын үндэстний бүтцийг үл харгалзан) дэмжигч нь Сунь Ятсен, цаашид гоминданчууд байсан.

хүндрэлтэй байдаг.”¹

“Өөрөө удирдах эрх” олгохын гол утга учир нь үндэстний районуудын онцлогийг харгалзан үзэх явдал өөрөөр хэлбэл, засаг захиргааны байгууллагыг орон нутгийн онцгой нөхцөлд илүү ажиллах чадвартай болгоход оршдог.

Үндэстний районы автономийн бодлогын тухай Үндсэн хуулийн заалтыг “Үндэстний районы автономийн тухай” хуульд илүү тодотгон, нарийвчлан, өргөтгөсөн. Үндэстний өөртөө засах районыг асуудлыг шийдвэрлэх “гол бодлого”, “төрийн улс төрийн тогтолцооны” чухал бүрэлдэхүүн хэсэг гэж тодорхойлсон. Хуулийн онцлог нь Үндэсний өөртөө засах районуудын зарчмыг хамгийн нийтлэг байдлаар илэрхийлсэн явдал юм.

Хуулийн 19 дүгээр зүйлийн дагуу Үндэстний өөртөө засах районы ардын төлөөлөгчдийн хурал нь өөртөө засах орны Дүрэм, тусдаа үйлчлэх Дүрмийг тухайн районы үндэстний улс төр, эдийн засаг, соёлын онцлогийг тооцож боловсруулах эрхтэй.

Өөртөө засах Дүрэм нь тухайн район дахь үндэстний өөртөө засах районы суурь асуудлыг хамарна.

Тусдаа үйлчлэх дүрмүүд нь тухайн район дахь автономитой холбоотой асуудлыг хэрэгжүүлэх тодорхой асуудлыг хамарна. Өөртөө засах районы Өөртөө засах дүрэм болон Тусдаа үйлчлэх дүрмүүд нь БХАТХ-ын Байнгын хороо баталсны дараа хүчин төгөлдөр болно Өөртөө засах тойрог, өөртөө засах хошууны автономийн дүрэм, тусдаа үйлчлэх дүрэм нь муж, өөртөө засах районы ардын төлөөлөгчдийн хурлын Байнгын хороо баталсны дараа хүчин төгөлдөр үйлчилж эхлэх бөгөөд энэ тухай БХАТХ-ын Байнгын хороо уг баталсан байгууллагад мэдэгдэх үүрэгтэй.

Үндэстний автономийн нэг суурь эрх нь тэдгээрийн шийдвэр, тогтоол, тушаал, зааврын гүйцэтгэлийг түр зогсоох байдаг.

Үндэстний өөртөө засах районы өөрөө удирдах байгууллага нь санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд харьцангуй их бие даасан байдалтай, гэхдээ улсаас тусламж, хөнгөлөлт хүлээн авдаг.

Үндэсний өөртөө засах районд орж байгаа санхүүгийн бүх орлогыг Төрийн тогтоолд заасны дагуу өөртөө засах районы өөрөө удирдах байгууллага ашигладаг.

Үндэстний өөртөө засах районы санхүүгийн орлого, зарлагын зүйлийг эдгээр районд үзүүлсэн хөнгөлөлтийн зарчимд нийцүүлэн Төрийн зөвлөл тодорхойлно. Үндэстний өөртөө засах районы төсвийн зарлагад эргэлтийн хөрөнгийн сан байгуулдаг, урьдчилсан зардалд зориулсан төсвийн хөрөнгийн эзлэх хувь нь ердийн районыхаас илүү өндөр байдаг.

1 红旗(hóngqí) Красное знамя. 1984. #12. С.24.

Үндэстний өөртөө засах районы өөрийн удирдах байгууллага өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ тухайн районы өөртөө засах дүрмийн дагуу тухайн нутагт өргөн тархсан нэг буюу хэд хэдэн хэл, бичиг хэрэглэж болно. Өөрөө удирдах байгууллага нь нэг буюу хэд хэдэн хэл, бичиг ашиглахын зэрэгцээгээр өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ үндэстний өөртөө засах районд хэрэглэдэг хэлийг гол хэл болгож сонгож болно.

Өөрөө удирдах байгууллага нь үндэстний өөртөө засах районд улсын цэргийн тогтолцоо болон тухайн район дахь бодит шаардлагад нийцүүлэн, тухайн районд нийтийн дэг журмыг сахиулахын тулд Төрийн зөвлөлийн зөвшөөрөл (санкц)-тэйгээр нийтийн аюулгүй байдлын цэргийн хүчийг бүрдүүлж болно.

Түүнчлэн албан тушаалтныг томилохдоо ихэвчлэн үндэстний цөөнхөөс гарсан хүмүүсийг ажиллуулна.

2001 онд “Үндэстний өөртөө засах районы тухай” хуулийн нэмэлт өөрчлөлт оруулсан редакцийг баталснаар үндэстний хууль тогтоомжийн үйлчилж байгаа тогтолцоо мэдэгдэхүйцээр өөрчлөгдөж эхэлсэн. Үүнд Төрийн Зөвлөлд болон түүний байгууллагуудад (ведомства) түүнийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай захиргаа-удирдлагын хуулийн заалт, журам, хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг боловсруулах үүрэг өгсөн 73 дугаар зүйл нөлөөлсөн. Мөн адил чиг үүргийг үндэстний өөртөө засах район, шууд харьяалалтай хотын ардын төлөөлөгчдийн зөвлөл болон тэдгээрийн байнгын хороодод хүлээлгэсэн.

Өөртөө засах районуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, эдийн засаг, соёлыг хөгжүүлэх багц асуудлаар олон тооны өөрчлөлт орсон.

Эдгээр районд улсын зүгээс тусламж үзүүлэх, юуны өмнө санхүүгийн хэрэгслийг шилжүүлэх (ердийн, тусгай, түүнчлэн бодлогод туссан хөнгөлөлт) журмыг тогтоосон. Түүнчлэн ядуурлыг даван туулах, соёл, боловсролыг хөгжүүлэх, суурь дэд бүтцийг бий болгоход ихээхэн анхаарал хандуулсан.

Ийм байдлаар зарчмыг тодорхой болгохын тулд өөртөө засах нэгжүүдийн ашиг сонирхлыг харгалзан, юуны өмнө өөртөө засах дүрэм (өөртөө засах нутаг дэвсгэр бүрт), түүнчлэн тусдаа үйлчлэх дүрэм (орон нутгийн хууль-тэй байх шаардлагатай. Тэдгээрийг төв засгийн байгууллагын удирдлага, хяналтын дор боловсруулах үүргийг үндэстний районуудад хүлээлгэсэн. 1980-1990 онд үндэстний өөртөө засах бараг бүх район эдгээр хууль тогтоомжийг боловсруулж дээд байгууллагын зөвшөөрлийг авсан.

Зөвхөн (мужийн шатны) Үндэстний өөртөө засах районы дүрэм хэдийгээр боловсруулагдсан боловч 2005 оны эхэнд батлагдаагүй байсан нь онцгой тохиолдол болсон. Иймэрхүү байдлаар үндэстний (үндэстний

цөөнхийн) хууль тогтоомжийн тогтолцоо бий болгох ажил дуусаагүй байна.

Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлд тэмдэглэснээр шаардлагатай тохиолдолд төр онцгой захиргаат районыг (特别行政区 tèbié xíngzhèng qū) байгуулж болно. Онцгой захиргаат районы дэглэмийг тодорхой нөхцөл байдлыг харгалзан БХАТХ-аас баталсан хуулиар тогтооно.

Онцгой захиргаат район байгуулах санааг хятадын удирдагчид анх 1981 онд гаргасан. Энэ нь Тайванийг онцгой статустайгаар, хоёр өөр нийгмийн системийг нэг улсын хүрээнд байлгах боломжтойгоор нэгтгэх санаачлага байсан юм.

“Нэг улс, хоёр тогтолцоо” (一国两制 yī guó liǎng zhì) үзэл баримтлалын хүрээнд Тайваньд бий болсон улс төр, эдийн засаг, нийгмийн тогтолцоо, амьдралын хэв маяг, бусад орнуудтай тогтоосон гадаад эдийн засгийн болон соёлын харилцаагаа хадгалах, өөрийн зэвсэгт хүчинтэй байхыг санал болгосон.

БНХАУ-ын удирдлага хувийн өмчид (газар, үйлдвэр, эзэмшил газартай байшин гэх мэт) халдахгүй болохоо амласан¹. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Үндсэн хуульд Тайваныг “БНХАУ-ын ариун газар нутгийн нэг хэсэг” гэж бичсэн, ийм маягаар эчнээгээр засаг захиргааны онцгой районы эрхтэйгээр БНХАУ-ын бүрэлдэхүүнд орсон².

Тайвань Улс тусгаар тогтнолоо зарлах боломжоос урьдчилан сэргийлэх зорилгоор 2005 оны 3 сарын 14-нд БХАТХ-аас “Улсын бүрэлдэхүүнээс гарахын (сепессия) эсрэг”³ хуулийг баталсан.

Хуулийн арван зүйлд “Тайваны асуудлыг” авч үзсэн, Тайваныг Хятадаас хүчээр салах, салан тусгаарлах хүч хэрэглэхээс урьдчилан сэргийлэх, улсад энхийн замаар нэгдэх болон “энхийн бус хэрэгсэл”-ийг авч үзсэн, түүнчлэн үйл ажиллагааны зорилго, хууль зүйн хүрээг зохицуулсан.

Гэхдээ энэ үзэл баримтлал болон Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлийн заалт нь английн колоничлолын Сянган⁴, португалийн колони Аомэн⁵-ийн тухайд Хятадын бүрэн эрхт байдлыг сэргээхэд ач холбогдолтой болсон.

Сянгань, Аомэнийг эргүүлэн авах үйл ажиллагаа зөвхөн гэрээ-эрх зүйн үндсэн дээр тухайн газруудад эдийн засгийн тогтолцоо, улс төрийн

1 人民日报 (rénmín rìbào Ардын өдрийн сонин. 1981.01.

2 Үзэх: Государственный строй Китайской Народной Республики. С.117.

3 中华人民共和国反分裂国家法//人民日报。2005年3月15日。(Zhōnghuá rénmin gònghéguó fǎn fēnlìe guójiā fǎ/rénmín rìbào улсын бүрэлдэхүүнээс гарахын эсрэг БНХАУ-ын хууль. 2005.03.15.

4 香港 (xiānggǎng) -үгчилбэл, “анхилуун усан зогсоол ” буюу “анхилуун порт”, Сянган-путунхуа дуудлага, Гонконг-юэ хэлний гуанжоу дуудлага.

5 澳门(àomén)- үгчилбэл “булан (тохой) -гийн хаалга”, “булант хаалга”. “Аомень “-путунхуа дуудлага (орос хэл дээр хазгай хэлэгдсэн Аомынь гэж тааралддаг). Өөр нэр нь Макао, португаль хэлний “Macau” гэсэн колонийн нэрнээс гаралтай.

дэглэмийг өөрчлөхгүйгээр болж өнгөрсөн. Үнэн хэрэгтээ энх тайвны замаар урьдын колонийн эзэмшлийг улс төрийн өөр өөр тогтолцоотой улс орны хооронд шилжүүлсэн.

Сянганий эрх зүйн байдал бүрэлдэн тогтох эхлэл нь Сянганы асуудлаар БНХАУ болон Их Британи Хойт Ирландын Нэгдсэн Вант Улсын Засгийн газрын хамтарсан мэдэгдэл байсан¹.

Түүнд 1984 оны 12 сарын 19-нд гарын үсэг зурсан. Сянганы талаарх хамтарсан мэдэгдэлд Сянганд Хятадын бүрэн эрхт байдлыг сэргээх тодорхой огноог заасан бөгөөд энэ нь Их Британи шинэ нутэг дэвсгэрийг түрээслэх хугацааны сүүлчийн өдөртэй давхцаж байсан².

Сянганий онцгой захиргаат район (香港特别行政区, xiānggǎng tèbié xíngzhèng qū) 1997 оны 7 сарын 1-нд байгуулагдсан.

1987 оны 4 сарын 13-нд БНХАУ, Португалийн засгийн газрууд Аомэнийн асуудлаар Хамтарсан Мэдэгдэлд³ гарын үсэг зурсан бөгөөд үүний дагуу БНХАУ-ын Засгийн газар 1999 оны 12 сарын 20-нд Аомэнд бүрэн эрхт байдлаа зарласан.

Аомэний онцгой захиргаат район 1999 оны 12 сарын 20-нд байгуулагдсан.

Дээрх хоёр Хамтарсан Мэдэгдэлд хоёуланд нь колони байсан орнуудад хятадын бүрэн эрхт байдлыг сэргээснээр хууль тогтоох, улс төрийн болон нийгмийн тогтолцоо нь хүн амын амьдрах хэв маяг нь 50 жилийн туршид өөрчлөлтгүй байхаар заасан.

Хамтарсан Мэдэгдлүүд шинэ хэм хэмжээний баримт бичиг гаргахыг зөвшөөрсөн.

1990 оны 4 сарын 4-нд БХАТХ-аас Сянган, Аомэны нутаг дэвсгэр дээр эдгээр бүс БНХАУ-ын харьяанд шилжсэний дараах удирдлагыг зохицуулсан БНХАУ-ын Сянганы онцгой захиргаат районы (СОЗР)⁴ суурь хуулийг баталсан, 1993 оны 3 сарын 31-нд БНХАУ-ын Аомэний онцгой захиргаат районы (АОЗР)⁵ суурь хуулийг баталсан.

1 Үзэх: См:当代各国政治体制。中国港澳台地区o兰州:州大学出版社o 1998年。(dāngdài gèguó zhèngzhì tìzhì. Zhōngguó gāng'ào tái dìqū o lánzhōu: Zhōu dàxué chūbǎn shè) Современные государственные политические системы. Китайские регионы Сянгань, Аомэнь, Тайвань, Ланьчжоу: Изд-во Ланьчжоуского университета, 1998.с.32-45. 人民日报(rénmín rìbào Ардын өдрийн сонин. 1984.09.27.

2 Цюлуны хойг, түүний орчмын газруудтайгаа 1898 онд 99 жилээр “түрээслүүлсэн” байсан.

3: 当代各国政治体制。中国港澳台地区。兰州: 州大学出版社。 1998年。(dāngdài gèguó zhèngzhì tìzhì. zhōngguó gāng'ào tái dìqū. lánzhōu. lánzhōu dàxué chūbǎnshè. Современные государственные политические системы. Китайские регионы Сянган, Аомэнь, Тайвань, Ланьчжоу. Ардын өдрийн сонин. 1990.04.20.

4 中华人民共和国香港特别行政区基本法 //人民日报。1990年4月20日。(zhōnghuá rénmin gònghéguó xiānggǎng tèbié xíngzhèngqū jīběn fǎ. rénmin rìbào.БНХАУ-ын Сянганы Онцгой Захиргаат районы Үндсэн хууль. Ардын өдрийн сонин. 1990.04.20.

5 中华人民共和国澳门特别行政区基本法//人民日报。1993年4月13日。(zhōnghuá rénmin

Эдгээр баримт бичиг нь агуулгын хувьд онцгой захиргаат районы Үндсэн хууль бөгөөд Хятадын төрийн бүтцэд онцгой захиргаат бүс ямар байр суурь эзэлдэг, мөн онцгой захиргаат районд (ОЗР) төрийн бүтцийг хэрхэн бий болгож, үйл ажиллагаагаа хэрхэн явуулахыг харах боломжийг олгодог.

ОЗР-уудын суурь хууль нь ижил бүтэцтэй.

СОЗР-ын суурь хууль нь 160 зүйлтэй, АОЗР-ын суурь хууль нь 145 зүйлтэй. Сэдвийн хувьд найман бүлэгтэй (АОЗР-ынх нь есөн бүлэг эцсийнх нь -Нэмэлт), бүлгүүдийг нь дараах байдлаар нэгтгэж болно:

- 1) Нийтлэг заалтууд;
- 2) Төв болон ОЗР-ын хоорондын харилцаа;
- 3) ОЗР-ын оршин суугчдын үндсэн эрх, үүрэг;
- 4) Улс төрийн байгуулалт (бүтэц);
- 5) Эдийн засаг;
- 6) Соёл, нийгмийн амьдрал;
- 7) Гадаад эдийн засгийн үйл ажиллагаа;
- 8) Суурь хуулийг тайлбарлах, өөрчлөх.

Үүнээс гадна суурь хууль тус бүр нь гурван хавсралттай:

- 1) ОЗР-ын засаг захиргааны Тэргүүнийг томилох журам;
- 2) ОЗР-ын Хууль тогтоох байгууллагыг бүрдүүлэх болон, санал хураалтын журам;

- 3) ОЗР-ын нутаг дэвсгэр дээр үйлчлэх БНХАУ-ын улсын хууль тогтоомжийн актууд.

ОЗР-ын эрх зүйн байдалтай холбоотой гол заалтуудыг авч үзье.

Онцгой захиргааны район нь *de jure* БНХАУ-ын нутаг дэвсгэр-засаг захиргааны район мөн. БХАТХ ОЗР-ын суурь хуулийг боловсруулна.

ОЗР-ын хууль тогтоох байгууллага нь суурь хуулийн үндсэн дээр тогтоосон журмын дагуу хууль баталж болох боловч эдгээр хуулиудын тухай БХАТХ-д мэдэгдэнэ. Хэрвээ төрийн эрх барих дээд байгууллага нь ямар нэг хууль тогтоомжийн актыг ОЗР-ын суурь хуульд нийцэхгүй байна гэж үзвэл тухайн баримт бичгийг ОЗР-ын хууль тогтоох байгууллагад буцаах бөгөөд тухайн хууль хүчингүй болно.

ОЗР-ын захиргааны Тэргүүнийг сонгуулийн буюу зөвлөсний үндсэн дээр БНХАУ-ын Ардын Төв Засгийн газар томилно.

ОЗР төрийн тусгаар тогтносон байдал болон гадаад улс төрийн хэргийг хэрэгжүүлэхгүй, улс төрийн гадаад бодлого, батлан хамгаалах асуудал нь Хятадын Төв Засгийн газрын бүрэн эрхэд байна. ОЗР нь янз бүрийн улсууд,

район, холбогдох олон улсын байгууллагатай өөрийн нэрийн өмнөөс эдийн засаг, соёлын холбоог хадгалан хөгжүүлэх, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан-техникийн салбарт хоёр талт болон олон талт хэлэлцээр байгуулах, олон улсын албан бус байгууллагад элсэх, гэхдээ “Бүгд Найрамдах Хятад Ард Улс гээд ОЗР-ын нэрээ тавина. ” ОЗР нь ОЗР-т орох, гарах баримт бичгийг бие даан олгох эрхтэй.

Суурь хуулийн дагуу ОЗР нь дараахыг батлах үүрэгтэй:

- Эх орноосоо урвах, улс орныг хуваах, үймээн самуунд өдөөн хатгах, улсын нууцыг хулгайлахыг хориглох тухай хууль;
- ОЗР-т гадаадын улс төрийн байгууллага, бүлэглэл улс төрийн үйл ажиллагааг хориглох тухай хууль;
- ОЗР-д улс төрийн байгууллага, бүлэг, хилийн чанадын улс төрийн байгууллага, бүлэгтэй холбоотой байхыг хориглох тухай хууль.

БХАТХ-аас Хятад Улсад дайны байдал буюу Сянган, Аомэньд онцгой байдал зарласан нөхцөлд Төв Засгийн газар нь ОЗР-д үндэсний холбогдох хуулийг хэрэгжүүлэх тухай зарлигийг хэвлэн нийтэлж болно.

ОЗР нь өөртөө засах өргөн эрхийг *de jure* ашиглана. Батлан хамгаалах, гадаад бодлогын талаарх хуулийн заалт болон ОЗР-ын өөртөө засах эрхэд үл хамаарах улсын нэгдмэл байдал, тусгаар тогтнолтой холбоотойгоос бусад БХТАХ-аас баталсан эрх зүйн актыг ОЗР дагаж мөрдөхгүй (хэрэглэхгүй).

Төвд харьяалалтай бүх муж, өөртөө засах район, хотууд, төв Засгийн газарт харьяалагддаг бүх байгууллага нь ОЗР-ын нутгийн өөрийн удирдлагад (хуулийн дагуу) байгаа байгууллагын үйл ажиллагаанд оролцох эрхгүй.

ОЗР-ын хууль тогтоох байгууллага болон Засгийн газрын бүтцийг тухайн районд оршин суугчдаас бүрдүүлнэ. ОЗР-ын хууль тогтоох байгууллага нь суурь хуультай зөрчилгүй хуулийг батлах, хүчингүй болгох, өөрчлөлт оруулах эрхтэй.

ОЗР шүүхийн эцсийн шатны шийдвэр гаргах, орлогоос Төв Засгийн газарт хувь өгөхгүй байх эрхтэй, Төв Засгийн газар нь ОЗР-д татвар ногдуулахгүй.

Ийм маягаар ОЗР (болон эдийн засгийн онцгой бүс) байгуулах нь “нийт улсын хэмжээний хэрэг”. Гагцхүү нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тооноос хамаарч ОЗР-ыг мужийн доод шатны нэгжтэй адилтгаж болно.

Одоогийн байдлаар онцгой гэрээ-эрх зүйн статус болон өгч байгаа ач холбогдлыг үл харгалзан ОЗР нь мужийн шатны захиргааны онцгой нэгж байдаг.

Хууль зүйн хэлбэр талаас Сянган, БНХАУ-ын бусад нутаг дэвсгэртэй харьцах харьцаа нь холбоог (конфедерация) санагдуулам гэж болно. Гэвч онцгой районы захиргааны тэргүүн болон бусад өндөр албан тушаалтныг

ардын төв засгийн газар томилж, Сянганы засгаас гаргасан хуульд БХАТХ-ын Байнгын хороо хяналт тавьж эцэст нь буцааж, хүчингүй болгох эрхтэй байгаа нь өөр зүйлийг нотолж байна.

Хууль тогтоомжийн гол актад ОЗР-ын хууль тогтоох байгууллагаас баталсан ямар ч хууль нь ОЗР-ын суурь хуультай зөрчилдөх ёсгүй. БНХАУ бол нэгдмэл улс юм. ОЗР болон БНХАУ-ын харилцаа нь “шилжилтийн хугацаа”-ны тавин жилийг дуусах хүртэл хууль зүйн бодит болон хэлбэр талаас авч үзвэл колончлолын харилцаа юм. Энэ байр суурь ОЗР-уудын хувьд дэмжлэг хүлээдэг¹.

Ийм боловч ОЗР-ыг жинхэнэ утгаар нь колони гэж үзэж болохгүй, учир нь нэг талаас, эх газрын талаас улс төрийн дөнгө, эдийн засгийн мөлжлөг байдаггүй. ОЗР-ын нутаг дэвсгэрийг нь ямар нэг империалист улс эзэлж аваагүй, эсрэгээр колончлолоос чөлөөлөгдсөн нутаг дэвсгэр мөн. ОЗР-ыг статус нь ивээлийн газар нутагтай ойролцоо². Тийм маягаар ОЗР-ыг БНХАУ-ын түр онцгой ивээлдээ авсан газар гэж нэрлэж болно.

Орон нутгийн түвшний засаг захиргааны онцгой нэгж ОЗР-ын төрийн байгуулалтын илүү нарийн элементийг тусгай бүтээлүүдэд авч үзсэн байна³.

Ийм маягаар БНХАУ бол үндэстний асуудлыг шийдвэрлэх онцгой хэлбэрийг хэрэгжүүлэх-үндэстний цөөнхийн давуу эрхээр өөрийгөө удирдах шинж тэмдэгтэй үндэстний өөртөө засах районы бүсчлэлийн элемент бүхий нэгдмэл улс мөн.

Хятадад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн гурван шатлалт хуваарийг хүлээн авсан ба үндэстний өөртөө засах районд дөрвөн шатлалтай байж болох бөгөөд энэ нь төрийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн байгууламжийн цаашдын хувиралд томоохон ач холбогдолтой юм. Үүний зэрэгцээгээр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн онцгой бүс байгуулахыг de jure зөвшөөрдөг бөгөөд улсын хууль тогтоох дээд байгууллагаас эдийн засаг, аж ахуй, улс төрийн аливаа бодлогыг шийдвэрлэхийн тулд тэдгээрийн статусыг тогтоодог.

Мөн түүнчлэн ОЗР байгуулах нь үндсэндээ тодорхой нэг улс болон “ивээлийн” нутаг дэвсгэр алгуур өөр улсын бүрэлдүүнд орох олон улсын

1 Der Spiegel. 51/ 1996. p.134.

2 “ивээл дэх газар нутаг” буюу “ивээлд авсан газар” -НҮБ-ын ивээлд орсон олон улсын тогтолцоонд хамрагдсан, статусынх нь эрх зүйн үндсийг НҮБ-ын Дүрмийн (Сан-Франциско, 1945 оны 7 сарын 26) XI-XII бүлгийн дагуу тодорхойлсон-өөрийгөө удирдах нутаг дэвсгэр биш.

3 Энэ талаар дэлгэрэнгүйг үзэх: Кокарев К.А. Политический механизм особых автономий Китая. М., БФРГЗ “Слово”, 2004.; Гудошников Л.М., Кокарев К.А Гонконг: Особая автономия Китая.М. // Информационный бюллетень #8.М: ИДВ РАН, 1999; Как управляется Китай: Эволюция властных структур Китая в конце XX - начале XXI века/Под ред М.Л.Титаренко.М: Памятники исторической мысли, 2004.

гэрээний эрх зүйн тулгамдсан асуудлыг үндсэн хуулийн эрх зүйн аргаар шийдвэрлэх арга юм. Сянганы ОЗР, Аомэны ОЗР болон Тайвань нь БНХАУ-ын түр “ивээлд байгаа нутаг дэвсгэр” юм.

Хавсралт 1. Өөртөө засах эрх эдэлдэг БНХАУ-ын үндэстнүүдийн жагсаалт¹

Сянган, Аомэнь, Тайваньд үндэстний бүрэлдэхүүний болон хүн амын тоог харгалзан үздэггүй. Нэг багананд орос хэл дээр угсаатны зүй болон дорно дахин судлалд тааралддаг нэр томъёог оруулсан². Хятадын хэд хэдэн үндэстнүүдэд нийтлэг хэрэглэгддэг нэрийн ард <<*> тэмдэг хэрэглэсэн.

Үндэстэн	Хүний тоо	Үндэстэн	Хүний тоо
1	2	3	4
Китайцы (Ханьцы, Хань) 汉族 (hànzú)	1 159 400 000	Ту (Монгоры) 土族 (tǔzú)	241 200
Чжуанцы 壮族 (zhuàngzú)	16 178 880	Мулао *木佬族 (mùlǎozú)	207 400
Маньчжурь 满族 (mǎnzú)	10 682 300	Сибо 锡伯族 (xíbózú)	188 800
Дунгане ² (Хуэй) 回族 (huízú)	9 816 800	Киргизы 柯尔克孜族 (kē'ěrkèzīzú)	160 800
Мяо (Мео)* 苗族 (miáozú)	8 940 100	Дауры (Даруры) 达斡尔族 (dǎwò'ěrzú)	132 400
Уйгуры 维吾尔族 (wéiwú'ěrzú)	8 399 400	Цзинпо (Джингпхо, Качин) 景颇族 (jǐngpōzú)	132 100
Туцзя (Бисека) 土家族 (tǔjiāzú)	8 028 100	Маонань ³ (Гунун) 毛南族 (máonánzú)	107 200

1 Хүн амын тооны бодит баримт болгон ашигласан эх сурвалж: 中国二零零零年人口普查资料. 第一卷, 第二卷, 第三卷. -北京. 2003. (zhōngguó èr líng líng nián rén kǒu pǔchá zīliào. Běijīng) Хятадын хүн амын 2000 оны тооллогын материал. Боть. 1-3. Бээжин. 中国统计年鉴. 2003. (zhōng-guó tǒngjì niánjiàn) 2003. Хятадын статистикийн жилийн мэдээ (Статистический ежегодник КНР). 2003.

2 Жагсаалтыг хийхдээ ашигласан материал: Сердюченко Г.П., К вопросу о классификации народов и языков Китая. // Советское востоковедение. 1957. # 4. С. 117-124; Брук С.И. Население мира: Этнодемографический справочник. М., 1988; Концевич Л.Р. Китайские имена меньшинства в Китае. Спецтема //Китайский информационный интернет-центр. <http://www.china.org.cn>. 2002.

2 Дотоодын үндэстний цөөнхийн талаарх бүтээлүүдэд энэ үндэстний нэрийг “дунгане” (тюрк.), дорно дахины судлалд – “хуэй” (Хят). Үндэстний нэр нь – “хуй”.

3 БНХАУ байгуулагдсаны дараа үндэстэн маонань гэдэг нэрийг авсан, (毛南族, máonánzú), харин 1986 оны 6 сард маонань (毛南族, máonánzú) нэрийг авсан.

Хавсралтын үргэлжлэл 1

1	2	3	4
И (Ий)* 彝族 (yízú)	7 762 300	Салары () 撒拉族 (sālāzú)	104 500
Монголы 蒙古族 (ménggǔzú)	5 813 900	Булан (План) 布朗族 (bùlǎngzú)	91 900
Тибетцы (Цзан, Пёба, Бод)* 藏族 (zàngzú)	5 416 000	Таджики 塔吉克族 (tǎjīkèzú)	41000
Буй 布依族 (bùyīzú)	2 971 500	Ачан 阿昌族 (āchāngzú)	33 900
Дун (Кам, Гам, Бугам) 侗族 (dòngzú)	2 960 300	Пуми* 普米族 (pǔmǐzú)	32 600
Яо (Зао, Ким мьен)* 瑶族 (yáozú)	2 637 400	Эвенки 鄂温克族 (èwēnkèzú)	30 500
Корейцы 朝鲜族 (cháoxiǎnzú)	1 923 800	Ну* 怒族 (nùzú)	28 800
Бай 白族 (báizú)	1 858 100	Цзин ¹ 京族 (jīngzú)	22 500
Хани* 哈尼族 (hānīzú)	1 439 700	Цзино ² (дино) 基诺族 (jīnuòzú)	20 900
Казахи 哈萨克族 (hāsàkèzú)	1 250 500	Дэан ³ 德昂族 (dé'ángzú)	17 900
Ли 黎族 (lízú)	1 247 800	Баоань 保安族 (bǎo'ānzú)	16 500
Тай (дай) 傣族 (dǎizú)	1 159 000	орос 俄罗斯族 (èluósīzú)	15 600
Шэ 畲族 (shēzú)	709 600	Юйгуп (Юйгү, Югүп) 裕固族 (yùgùzú)	13 700
Лису 傈僳族 (lìsùzú)	634 900	Узбек 乌孜别克族 (wūzībiékèzú)	12 400

1 1958 онд БНХАУ-ын Төрийн зөвлөл “цзин” гэж өөрчлөн нэрлэх хүртэл “ею” нэртэй байсан. Мөн “гурван арлын цзин” (京族三岛 jīngzúsāndǎo) гэдэг нэр ч тааралддаг. Дотоодын үндэстний цөөнхий бүтээлүүдэд “гурван арлын вьетул” гэсэн байдаг.

2 1979 онд БНХАУ-ын Төрийн зөвлөл үндэстэнд “дино” үндэстний цөөнхийн статус өгсөн, “дай” үндэстнээ тасарсан, 55 онд үндэстний цөөнх гэж хүлээн зөвшөөрсөн.

3 Шинэ нэрийг БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн зарлигаар 1985 оны 9 сараас тогтоосон. Урьдах нэр нь –бэнлун benlongzu)

Гэлао 仡佬族 (gēlǎozú)	579 499	Мэньба (Монпа) 门巴族 (ménbāzú)	8 900
Дунсян 东乡族 (dōngxiāng)	513 800	Орочон (Эвены, Ламуты) 鄂伦春族 (èlúncūnzú)	8 200
Лаху 拉祜族 (lāhùzú)	453 700	Тырун (Дулун, Трунг) 独龙族 (dúlóngzú)	7 400
Шуй (Ашуй, Суй) 水族 (shuǐzú)	406 900	Татар 塔塔尔族 (tǎtǎ'ěrzú)	4 900
Ва 佯族 (wǎzú)	396 600	Нанай (Хэчжэ) 赫哲族 (hèzhézhú)	4 500
Наси 纳西族 (nàxīzú)	308 800	Гаошань ¹ 高山族 (gāoshānzú)	4 500
Цян (Жума) 羌族 (qiāngzú)	306 100	Луба (Люба Лопи) 珞巴族 (luòbāzú)	2 900

京族三岛 (jīngzúsāndǎo)

Хавсралт 2. БНХАУ-ын мужийн шатны засаг захиргаа-нутаг дэвсгэрийн нэгжийн жагсаалт

Нэр	Униших (транскрипц)	Орчуулга
省	shěng	Муж (провинция)
安徽	ānhuī	Аньхой
甘肃	gānsù	Ганьсу
广东	guǎngdōng	Гуандун
贵州	guìzhōu	Гуйчжоу
辽宁	liáoníng	Ляонин
四川	sìchuān	Сычуань
福建	fújiàn	Фуцзянь
海南	hǎinán	Хайнань
湖北	húběi	Хубэй

1 Үгчилбэл нэр – уулынхан. Тайванийн үндэстний цөөнхийг нэгтгэсэн нэр, 1949 оны дараа ямэй, амэй, сайся, тая, бунун, цоу, пайван, бэйнань, пинпу болон бусад овгийнхныг нэгтгэж өгсөн. Эх газарт гаошанийг хэлдэг.

湖南	húnán	Хунань
河北	héběi	Хэбэй
黑龙江	hēilóngjiāng	Хэйлунцзян
河南	hénán	Хэнань
吉林	jílín	Цилинь (Гирин)
江西	Jiāngxī	Цзянси
江苏	jiāngsū	Цзянсу
青海	qīnghǎi	Цинхай
浙江	zhèjiāng	Чжэцзян
山东	shāndōng	Шаньдун
山西	shānxī	Шаньси
陕西	shǎnxī	Шэньси
云南	yúnnán	Юньань
自治区	zìzhìqū	Өөртөө засах район
内蒙古	Nèi ménggǔ	Дотоод Монгол
广西壮族	guǎngxī zhuàngzú	Гуанси-Чжуаний
宁夏回族	níngxià huízú	Нинся-Хуэйн
新疆维吾尔族	xīnjiāng wéiwú'ěr	Шинжаан Уйгурын
西藏	xīzàng	Төвдийн
直辖市	zhíxíashì	Ардын төв Засгийн газарт шууд харьяалалтай хотууд
北京	běijīng	Бээжин
天津	tiānjīn	Тяньжин
重庆	chóngqìng	Чунцин
上海	shànghǎi	Шанхай
特别行政区	tèbié xíngzhèngqū	Засаг захиргааны онцгой район
香港	xiānggǎng	Сянганы
澳门	àomén	Аомэний

ISBN 978-9919-9618-1-7



9 789919 961817